



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 5ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-78
<hr/>	
1.Хуулийн төслийг эцэслэн батлах	12-13
2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай/	13-21 75
3.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	22-39 76
4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	39-73 77
5.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	73-75

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
5 дугаар сарын 01-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Рэгдэл, Р.Сэддорж, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, П.Ганзориг, Б.Дэлгэрсайхан, Г.Лувсанжамц, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Бум-Очир, Б.Тулга;

Тасалсан: Д.Амарбаясгалан;

Хоцорсон: О.Алтангэрэл-06 минут, С.Амарсайхан-1 цаг 36 минут, О.Амгаланбаатар-07 минут, Ч.Анар-22 минут, Х.Баасанжаргал-05 минут, Ц.Баатархүү-07 минут, Д.Батбаяр-11 минут, Ж.Батжаргал-16 минут, Б.Батцэцэг-25 минут, Э.Батшугар-16 минут, Х.Болормаа-14 минут, Х.Булгантуяа-17 минут, Ш.Бямбасүрэн-08 минут, Ж.Галбадрах-3 цаг 11 минут, Д.Ганбат-47 минут, Л.Гантөмөр-05 минут, Х.Ганхуяг-2 цаг 23 минут, Ц.Даваасүрэн-33 минут, Г.Дамдинням-04 минут, Т.Доржханд-10 минут, Б.Жавхлан-3 цаг 07 минут, Б.Жаргалан-11 минут, Д.Жаргалсайхан-16 минут, С.Лүндэг-01 минут, П.Мөнхтулга-14 минут, З.Мэндсайхан-15 минут, Н.Наранбаатар-3 цаг 07 минут, М.Нарантуяа-Нара-20 минут, О.Номинчимэг-01 минут, С.Одонтуяа-14 минут, Ц.Туваан-01 минут, Б.Түвшин-09 минут, Г.Уянгахишиг-08 минут, Б.Хэрлэн-01 минут, Б.Чойжилсүрэн-14 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөх талаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналыг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэх асуудлын дарааллын тавдугаарт тусгагдсан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёрдугаар асуудал болгон хэлэлцүүлэх Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 1 гишүүн ирцэд нэмэгдсэн.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 26
Бүгд: 86

69.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хэлэлцэх асуудлын хоёрдугаарт оруулж хэлэлцэхээр тогтов.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 21
Бүгд: 89

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 76.4 хувиар хууль батлагдлаа.

2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 20
Бүгд: 90

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 77.8 хувиар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 21
Бүгд: 92

Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу 77.2 хувиар хууль батлагдлаа.

4.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 22

Бүгд: 93
Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар буюу **76.3** хувиар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Тэмүүжин, О.Номинчимэг, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./10:42/

Гурав.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалахын дэд сайд Д.Баасандамба, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн дарга П.Идэр, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч Б.Мөнх-Ирээдүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Д.Батлут, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Энхтүвшин, Б.Батбаатар, Г.Ганбаатар, Д.Пүрэвдаваа, М.Ганхүлэг, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалахын дэд сайд Д.Баасандамба, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:39/

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Батбаатар, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Н.Алтаншагай, С.Цэнгүүн, С.Зулпхар, Г.Тэмүүлэн, Д.Пүрэвдаваа, Ш.Бямбасүрэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Г.Тэмүүлэн О.Номинчимэг, Ш.Бямбасүрэн, Д.Үүрийнтуяа, О.Алтангэрэл нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:24/

Тав.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Байнгын хорооноос гаргасан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	45
Бүгд:	99

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай/-ийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	40
Бүгд:	100

60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа нар байлцав.

С.Бямбацогт: 1.Байнгын хорооны саналаар Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 44

Бүгд: 100

56.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 46

Бүгд: 100

54.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 45

Бүгд: 100

55.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн

газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

С.Бямбацогт: 1.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 46

Бүгд: 100

54.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 49

Бүгд: 100

51.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 57

Бүгд: 100

43.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул “Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов. /13:41/

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын урилгаар Эдийн засгийн үндэсний дээд сургуулийн оюутнууд, Нийслэлийн ерөнхий боловсролын “Амжилт Кибер” сургуулийн багш, сурагчдын төлөөлөл, “Монгол-92” спортын тэмцээний Баян-Өлгий аймгийн тамирчид, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Сум дундын ойн анги орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1992 оны төгсөгчид, Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1976 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн урилгаар ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 8^г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ц.Туваан, С.Эрдэнэболд нарын урилгаар Дархан-Уул аймгийн Хонгор ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын урилгаар Завхан аймгийн Алдархаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн Социал демократ эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгчид, Нийслэлийн ерөнхий боловсролын "Орчлон" сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, "Монголын бартаат замын авто спортын холбоо"-ны удирдах зөвлөлийн гишүүд, тамирчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 41 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 5 дугаар сарын 01-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн чуулганы хуралдаанд 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 57.1 хувийн ирцтэй байгаа учраас чуулганы хуралдаанд нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганы хуралдаанд өглөө 9 цагт ирсэн эртэч гишүүдээ бас танилцуулъя. Мэндбаярын Мандхай, Мөнхчулууны Энхцэцэг, Лутаагийн Энхнасан, Ганбатын Хосбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүд өглөө 9 цагт ажилдаа хүрэлцэн ирсэн байна. Ирцдээ орж бүртгүүлсэн байна. Чуулганы хуралдааны ирцдээ орж бүртгүүлсэн байна. Баяр хүргэе бүгдэд нь.

Зочин танилцуулъя. Эдийн засгийн үндэсний дээд сургуулийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Хамгийн эртэч зочин орж ирсэн байна. 10 цагт.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт нь хуулийн төслүүдийг эцэслэн батална. Ирцдээ ороод өрөөндөө оччихсон байгаа гишүүд танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Санал хураалтаар эхлэх учраас хуулийн төслийг эцэслэн батлахад 64 гишүүнээс дээш саналаар хуулиуд батлагдах ёстой. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

2.Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 8 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн.

4.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг явуулна.

5.“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6.9-д нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хэлэлцэх асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулах тухай 01/34 дугаартай албан бичгийг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг хэлэлцэх асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулах тухай,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Баасан гаргийн хэлэлцэх асуудлын эхэнд оруулж хэлэлцүүлж өгнө үү гэсэн байна.

Тэгэхээр энэ асуудлаар горимын саналаар санал хураалт явуулна. Хэрвээ дэмжигдвэл эцэслэн батлах санал хураалтуудын араас орно тийм үү? Дэмжигдэхгүй бол товлогдсон дарааллаар явна.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6.10-д хуралдаан даргалагч тухайн өдрийн хуралдааныг нээж, хэлэлцэх асуудалтай холбоотой нам эвслийн бүлгээс ирүүлсэн горимын саналыг уншиж танилцуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Энэ саналаар, энэ талаар хэлэлцүүлэг явуулахгүй гэж заасан байгаа.

Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү?

Тийм 5 дугаар асуудлыг л урагшлуулж байгаа гэж байгаа. Байрыг нь сольчихъё гэж байгаа. Энд бас хүндэтгэн үзэх шалтгаан байгаа юм байна лээ. Тийм зүгээр асуудлын байр солих л асуудал. Санал хураалтад одоогоор 48 гишүүн бэлэн болсон байна. Санал хураалтад 32 гишүүн бэлэн болоогүй байна. Ирц 81 гишүүн ирцтэй байгаа. Бусад гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг хүсэж байна.

51 гишүүн санал хураалтад бэлэн болсон. 30 гишүүн бэлэн болоогүй байна. Энэ 30 гишүүнийг санал хураалтдаа бэлдэхийг урьж байна. Үүний дараа бас 4 хуулийг нь эцэслэн батлах санал хураалт байгаа. 64-өөс дээш гишүүнээр. Тийм болохоор ирцдээ орчхоод өрөөндөө орсон гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Амжилт” Кибер сургуулийн 11-ийн 1 дүгээр ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт хүсье. Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Аав, ээжийнхээ үгэнд, багшийнх нарынхаа үгэнд сайн орж байгаарай хүүхдүүд ээ.

59 гишүүн ирцдээ орсон байна. Одоо санал хураалт явуулна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 69.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналыг санал хураалтад, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явагдсаны дараа хэлэлцэхээр шийдвэрлэлээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Ирцэд 88 гишүүн бүртгүүлсэн байна. Санал хураалтад одоогоор 63 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн бус 24 гишүүн байна. Ирцдээ орчхоод өрөөндөө сууж байгаа гишүүдийг чуулганы хуралдаандаа хүрэлцэн ирж санал өгөхийг урьж байна. Жангабыл гишүүн санал хураалтдаа бэлдсэн үү?

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн батлагдсанд тооцно гэж заасан байгаа. Нийт гишүүдийн олонх буюу 64 гишүүнээс дээш гишүүд дэмжиж байж энэ хуулиуд эцэслэн батлагдана. Гишүүдийг бас анхааралтай байхыг хүсэж байна. Санал хураалтаа явуулъя. Гишүүдээ суудалдаа суухыг хүсэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 76.4 хувийн саналаар энэ санал эцэслэн батлагдлаа.

Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

90 гишүүн санал хураалтад оролцсоноос 70 гишүүн буюу 77.8 хувийн саналаар энэ санал батлагдлаа. Бас чухал хууль батлагдсан байгаа Шинжлэх ухаан технологийн.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 77.2 хувийн саналаар энэ санал батлагдлаа. Энэ хууль батлагдлаа.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 76.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа. Хуулийн төслүүдийг эцэслэн батлахад оролцсон гишүүд, ажлын хэсэгтээ талархлаа илэрхийлье.

10.15 цаг

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакирын урилгаар “Монгол-92” спортын тэмцээний Баян-Өлгий аймгийн тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сая Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатарын 9 дүүргээс “Монгол- 92” тэмцээн зохион байгуулагдсан Буянт-Ухаа спортын ордонд. Манай Аубакир гишүүн, манай 92 оны төгсөгчдийн Батлут сайд маань бас зохион байгуулсан байгаа энэ тэмцээн, арга хэмжээг. Төлөөлөл орж ирсэн байна. Тэгээд та бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа хүргэе.

Манай төгсөлтийнхөн байгаа шүү. Тийм 92 онд 10 дугаар анги төгссөн хүүхдүүд. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгаа хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Эрдэнэболд: “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сард эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт асуудлаар Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүйн байнгын хороо 2024 оны 10 дугаар тогтоолоор эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ахалж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Х.Баасанжаргал, Д.Ганбат, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүжин, Г.Уянгахишиг нар ажилласан болно.

Хууль зүйн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсгийг тус тус үндэслэн боловсруулсан “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хэрэг хянан шийдвэрлэх явцад эрүү шүүлт, хүнлэг бус хэрцгий хандалтад өртсөн талаар ажлын хэсэгт өргөдөл, гомдол ирүүлсэн 40-өөд иргэдийн эрхийг сэргээх, нөхөн төлбөр олгох зэрэг асуудлыг энэхүү тогтоолоор нэг мөр шийдвэрлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурал цаашид эдгээр иргэдийн төлөө ямар үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара нь эрх нь зөрчигдөж хохирсон эдгээр иргэдийн хэргийг парламентын зүгээс дахин шинээр илэрсэн нөхцөл байдал гэж тогтоохтой холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх боломжтой эсэх, ингэснээр эрүү шүүлтэд өртсөн иргэдийн хэргийг эхнээс нь дахин хянан шийдвэрлэх боломж бий болгох талаар, мөн төрийн албаны хууль тогтоомжид эрүүдэн шүүлтийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин төрийн албанд ажиллахгүй байх зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагын талаар ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг тогтоолыг батлаад орхих бус цаашид хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг анхаарах талаар хуульч болон хууль сахиулагчдын сургалтын орчны тогтолцооны суурь асуудлыг цогцоор нь анхаарах шаардлагатай талаар, хүний эрхийн мэдрэмжтэй, нийгэм эдийн засгийн мэдлэгтэй хүмүүсээр хэрэг маргааныг шийдвэрлүүлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд сайн

бэлтгэдэг болох шаардлагын талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин 3 шатын шүүхээр хэрэг маргаан нь шийдэгдсэн хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад эрх нь зөрчигдсөн, хэлмэгдсэн иргэд Үндсэн хуулийн шүүхэд хандах замаар эрхээ сэргээлгэх боломжийг нээж өгөх шаардлагын талаар, Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх харьяалалд хүний үндсэн эрхийн маргааныг нэмж тусгах шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал тогтоолын төслийг Байнгын хороо болон Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх хамгийн боломжит арга хэмжээг тусгаж боловсруулсан талаар, мөн тогтоолын төслөөр Засгийн газарт тодорхой арга хэмжээг тодорхой хугацааны дотор хэрэгжүүлэхийг даалгасан байгаа тул тогтоолын хэрэглэгчдэд Байнгын хороо анхаарч ажиллах шаардлагын талаар тус тус байр сууриа илэрхийлж үг хэллээ.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч байгаа системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ердийн горимоор кнопоо дарж нэрээ өгөх бололцоотой.

Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Би асуулт асуухгүй. Өөрөө ажлын хэсэгт ажилласан байгаа. Яг энэ эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлаар бид нар бас Улсын Их Хурал дээр сонсгол хийсэн. Маш олон хүмүүс бас хохирогч болсон. Зарим нь бол шүүхээр эцэслэгдсэн байхад зарим нь бол бас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явж байгаа гэдэг зүйлүүд, мэдээллүүд авагдсан.

Тэгэхээр бид хэд бас кэйс болгоныг тухайлан ярилцах гэхээсээ илүүтэй энэ цаашдаа хэргийн бодит байдлыг тогтоох энэ үйл ажиллагаанд хүний эрх зөрчигддөггүй байх, дээрээс нь хэн нэгнийг хэлмэгдүүлж, эсвэл хэн нэгнийг хилсээр гэдэг юм уу, эсвэл хэн нэгэнд ял завшуулах энэ байдлыг хэрэг хянан шийдэх ажиллагааны явцад гаргахгүй байх чиглэлдээ л суурь асуудлуудыг анхаарья л гэж байгаа юм.

Тэгэхээр би бас Байнгын хорооны түвшинд бас хэлсэн. Энэ хуульч бэлтгэх, хууль сахиулагч бэлтгэх тогтолцоог ер нь Монгол Улсад ярихгүй бол үнэндээ хэлэхэд бас хэт их нийтийн эрх зүйгээр сурч хүмүүжсэн гэдэг юм уу ийм хуульчид

бол гарч байна. Хувийн эрх зүйн чиглэлийн хууль, эрх зүй буюу эдийн засаг, бизнесийн ойлголт багатай хүмүүс гарахаар ялангуяа энэ чиглэлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхдаа л хүний эрхийг зөрччихөөд байгаа байхгүй юу. Ойлгодоггүй.

Ер нь эрүүдэн шүүх гэдгийг манайхан бас ойлгох хэрэгтэй. Заавал physically буюу бие махбодод нь хохирол учруулах гэхээсээ илүү сэтгэл санаа, эргээд энэ бусад байдлаар залхаан цээрлүүлэх энэ үйл ажиллагаанууд хамаарч байгаа юм. Зарим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бараг мөрдөгч, прокурорууд ч гэдэг юм уу өөрсдөө эрүүдэн шүүхийн ажиллагааг хийж байгаа эсэхээ ч мэдэхгүйгээр бас энэ бусад байдлаар эрүүдэн шүүхийн ажиллагаануудыг бас гаргачхаад байгаа талууд бол байгаа. Тэгэхээр энийг бид хэд цаашдаа анхааръя гэдэг зүйлүүд бол байгаа. Тэгээд энэ тогтоолын хэрэгжилтийг бас Засгийн газар, тэр дундаа Хууль зүй, дотоод хэргийн яам, манай дундаа Хууль зүй, дотоод хэргийн яам координац хийгээд энэ шүүх эрх мэдлийн байгууллага болон прокурорын байгууллага, энэ мөрдөх чиглэлийн албатуудтайгаа бас ярилцаж энэ намрын чуулган гэхэд энэ асуудлуудаа яаралтай оруулж ирээсэй гэж хүсэж байна.

Ер нь цаашдаа бас энэ тогтолцооны асуудлуудыг бид хэд эргэж харах ёстой. Өөрөөр хэлэх юм бол энэ Мөрдөх албыг байгуулах юм уу үгүй юү? Ер нь энэ мөрдөх чиглэлийн үйл ажиллагаануудын 3 газар ингээд явж байгаа нь хэр оновчтой юм бэ гэдэг асуудал байна. Энэ цаашдаа гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг сайжруулах ажил байгаа шүү. Тэгээд хамгийн суурь асуудал бол энэ хуульч, хууль сахиулагчдыг бэлтгэх энэ тогтолцооны асуудал дээр өөрчлөлт хийхгүй бол энэ дээр бас өөр бусад байдлаар чанарын үр дүнгүүд гарахгүй байна. Бас хандлага, сэтгэлгээний асуудлууд өөрчлөгдөхгүй байна гэдэг зүйлийг бас эцэст нь ингээд хэлмээр байна.

Тэгээд Эрдэнэболд дарга бас мэдээж идэвхтэй ажилласан. Иргэд маань бол бид нарыг бас кэйсүүдийг бараг шийдчих юм яриад байсан боловч энэ Улсын Их Хурлаас бас яг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд оролцох боломжгүй байгаа гэдэг зүйлийг бас эцэст нь хэлмээр байна. Тэгээд хохирлыг барагдуулах энэ үйл ажиллагаа дээр бол уг нь Засгийн газрын тусгай сангийн хуулийг миний бие бас санаачлаад явж байгаа.

Тэгэхдээ аль болохоор төрөөс татвар төлөгчдийн мөнгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зөрчиж байгаа албан хаагчдын гаргасан үйлдлийг зөвтгөж хохирлыг барагдуулах гэхээсээ илүүтэй буруутай албан тушаалтанд л эцсийн хариуцлага энэ эдийн засгийн ч гэсэн асуудалд агуулга талаасаа хариуцлага хүлээдэг байх энэ механизм манай Монгол Улсад бас чухал байгаа гэдэг зүйлийг эцэст нь ингээд хэлье.

Тэгээд хуулийг хэрэгжүүлэх ажил дээр Засгийн газар онцгой анхаараарай гэж хүсэж байна. Өнөөдөр бол ингээд энэ хуулийг, тогтоолыг хэлэлцэж байхад Засгийн газар болон холбогдох байгууллагуудаас ерөөсөө төлөөлөл алга байна. Уг нь энийг ингээд сонсоод оролцоод сууж байх ёстой.

С.Бямбацогт: Хууль зүй, дотоод хэргийн сайдыг танхимд урьж байна. Яг өөрийнх нь эрхэлсэн асуудалтай холбоотой асуудал хэлэлцэж байна. Сайнзориг

гишүүний хэлж байгаа санал, шаардлага зөв шүү. Хууль зүй, дотоод хэргийн сайдыг урьж байна.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Юуны өмнө энэ өдрийн мэндийг гишүүддээ хүргэе. Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хороон дээр ажлын хэсэг байгуулагдаад эрүү шүүлттэй холбоотой асуудлаар хохирсон иргэдтэй бүүр биечлэн тусгайлан уулзаад, хэрэг болгоноор нь бас шинжээч томилоод, шинжээчийн дүгнэлтүүдийг сонсоод тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоолын төсөл гарч байгаа юм. Үнэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос олон жил дараалан Улсын Их Хуралд хүргүүлсэн хүний эрхийн нөхцөл байдлын илтгэлд дурдагдсан энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал чинь бол хувь хүний гэхээсээ илүүтэй системийн асуудал болчихсон юм байна. Тэнд байгаа ажил, албан хаагчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлээд албан хаагчдыг сольж сэлгээд дараад хариуцлага тооцоод энэ асуудал ерөөсөө шийдэгдэхгүй юм байна. Энэ өөрөө тогтолцооны шинж чанартай учраас бодлогын түвшинд, тогтолцооны түвшинд өөрчлөлт хийх шаардлагатай байна гэж анх удаагаа бараг Улсын Их Хурал дүгнэх хэмжээний тогтоол гаргах гэж байгаа юм.

Тэгээд энэ тогтолцооны шинжтэй гажиг чинь өөрөө Монгол Улсыг хүнийг эрүүд шүүддэг. Социализмын үеийн Вишинскийн аргаараа хэрэг маргаанаа шийдвэрлэдэг. Хүн нь байвал хэрэг нь олддог. Хорьж мөрдөж байгаад, айлган сүрдүүлж байгаад, мэдээллийн дутмаг байдлаар түшиглэж байгаад хуурч байгаад хэргийг нь хүлээлгэдэг. Гэмт хэргийг илрүүлэхэд, нотлоход гэмт хэрэгтний өөрийнх нь мэдүүлэг 1 номерын ач холбогдолтой байдаг гэдэг энэ коммунист, фашист аргаараа одоо ч хүртэл гэмт хэрэгтэйгээ тэмцдэг гэдэг энэ муу жишгийг энэ тогтолцооныхоо гажгаас болоод ардчилсан улс руу шилжээд хүний эрхийг хамгаалдаг 1992 оны Үндсэн хуулийг баталснаас хойш 36 жил ингэж явж байгаа юм байна гэдгийг чинь одоо бараг Улсын Их Хурал өөрөө анх удаа хүлээн зөвшөөрч, нотолж байгаа тогтоол гарч байна.

Тийм учраас гишүүд бүгдээрээ энэ дээр ач холбогдол өгч хэлэлцэхээс гадна Засгийн газар уул нь ирээд сонсох ёстой юм. Энэ тогтоолоор Учрал Ерөнхий сайдад үүрэг даалгавар өгч байгаа. Учрал Ерөнхий сайд Улсын Их Хурлын өмнө хууль тогтоомжийн биелэлтийг хариуцахынхаа сацуу өөрийнхөө кабинетад энэ салбарыг хариуцуулсан сайддаа бас үүрэг даалгавар өгөх ёстой болж байгаа. Тийм учраас Засгийн газар уул нь өнөөдрийн энэ хэлэлцүүлэг дээр бие бүрэлдэхүүнээрээ ирээд сууж байх ёстой байсан. Харамсалтай нь Батцэцэг сайд өөр сайд байгаа юм уу? Тэгээд энэ тогтоол дээр 3 зүйл бол маш чухал байгаа. Их Хурлын даргаа та 2-ыг ярьж байхад би энд

С.Бямбацогт: Тэмүүжин гишүүнд 1 минут нэмээд.

Х.Тэмүүжин: Эрүү шүүлт гэдэг зүйл бол бидний өнөөдрийнх шиг ийм хөнгөмсөг бас ярилцах, хэлэлцэх зүйл бол биш шүү. Төр гудамжинд иргэнээ гэмт хэрэг хийхэд шалгаж шийдэж чаддаг мөртөө төр өөрийнхөө байгууллага дотор төрийн албан хаагчид нь гэмт хэрэг хийхэд шалгаж чадахгүй байгаагийн хамгийн том жишээ чинь энэ эрүү шүүлт байхгүй юу. Тийм учраас энэ эрүү шүүлттэй холбоотой хар жагсаалт гаргадаг болох хэрэгтэй төр өөрөө. Эрүү шүүлт хийгээд

энэ гэмт хэргийн хохирогчид төрийн нэрийн өмнөөс хохирлыг нь барагдуулсан бол буруутай этгээдээс буцаагаад төлдөг тэр чадвартай болох ёстой. Энэ гэмт хэргийг бие даан мөрдөн шалгадаг байгууллагатай болох ёстой. Энэ гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг нийгмээрээ жишиж хардаг нүдтэй болох ёстой гэдгийг чинь энэ тогтоолоор хэлж байгаа юм шүү гэдгийг дахин сануулж хэлье.

Тэгээд гишүүд минь энэ дээр анхааралтай хандаад хууль тогтоогч шиг хараач ээ гэж хүсэж байгаа юм.

С.Бямбацогт: Тэмүүжин гишүүн үг хэллээ. Анхаарах ёстой шүү.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсье.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Номинчимэг: Парламентын үүрэг бол зөвхөн сонсоод өнгөрөх биш энэ дээр системийн доголдол байгаа бол энийг засах бодлогын шийдвэр гарах ёстой. Тэгээд энэ ч дагуу эрүүдэн шүүлттэй холбоотой хүний эрхийн сонсгол хийгээд Хүний эрхийн дэд хороон дээр ажлын хэсэг гарч энэ асуудлуудыг бас нэлээн удаан хугацаанд ажиллалаа. Юуны өмнө бас энэ дээр санаачилгатай ажилласан бас нэлээн амаргүй ийм нөхцөл байдлыг бид нар бас дүн шинжилгээ хийсэн, ажлыг хийсэн Эрдэнэболд гишүүндээ бас талархаж байна.

Бид нарын авч хэлэлцсэн энэ кэйсүүд яг хувь хүмүүстэй холбоотой. Ер нь дийлэнх нь 100 байдаггүй юм гэхэд 90-ээд хувь нь 2012-2016 онд гарсан хэргүүд байгаа юм. Гишүүд ээ 2012-оос 16 онд гарсан хэргүүд. Тэгээд тэр үед бид нарын бүүр ингээд ярианы аманд орчихсон шударга бусын хонгил гэдэг юм угсрагдаж хийгдэж байсан системийн доголдол гарсан байна гэдэг нь тодорхой болсон. Анх удаагаа энэ бол тов тодорхой болсон.

Тэгээд төрийн бодлого үнэхээр түүнд ингээд системийн алдаа, дутагдал гарсан юм бол энэ дээр ажилласан шинжээчид, хуулийн шинжээчид бас энд орсон хувь хүмүүсийн хувьд эрх нь зөрчигдсэн, эрүүдэн шүүгдсэн ийм нөхцөл байдлууд бол байхаар байна гэдгийг бүүр тогтоогоод гаргаж ирсэн. Тэгээд ийм бол энэ хүмүүсийнхээ эрхийг бол сэргээх ёстой.

Тэгээд энэ хүмүүс маань хүний амьдрал ер нь богинохон шүү дээ 2012 онд орсон бол одоо 14 жилийн дараа хүртэл нэр төрөө сэргээчих юмсан, худал хэлсээр энд ял авсан асуудлаа нэрээ цэвэрлээд үхэхдээ үр хүүхдүүддээ нэр цэвэр байх юмсан гэдэг энэ хүслийг нь төр бас шуурхай ажиллаж энийг нь шийдэх ёстой. Тэр буруутай албан тушаалтнуудад нь хариуцлагыг нь тооцож нөхөн төлбөрийг нь гаргах ёстой. Тэр ч чиглэлээр энэ Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа.

Гэхдээ энэ Улсын Их Хурлын тогтоол чиглэл гаргаад Засгийн газарт гараад биелдэггүй зүйл байгаа юм. Улсын Их Хурлын даргаа энийг бас та анхааралдаа аваасай гэж бодож байна. Өмнөх өмнөх чуулганаар ч гэсэн Улсын Их Хурлаас Засгийн газарт хугацаа өгсөн чиглэл, үүрэг даалгавар өгөхөөр Засгийн газар үүнийг нь биелүүлдэггүй, хугацаанаасаа хэтэрдэг. Бүүр даамжраад энийг чинь хийхгүй ээ, дахиад хэлэлцэнэ гэдэг ийм байдал гаргадаг нь үнэхээр Улсын Их Хурал Засгийн газартаа үүрэг даалгавар өгч үүнийг нь хянан шалгаж чадаж байна уу гэдэг дээр бид нар бас харах ёстой. Энэ асуудал дээр ч гэсэн намрын чуулганд хугацаа өгсөн байгаа учраас анхаараасай гэж хүсэж байна.

Ингээд энэ асуудалтай холбоотой бас юмыг харахаар бид нар энэ прокурорын шинэчлэл гэдэг зүйлийг ялт ч үгүй хийх цаг нь болжээ. Системийн доголдол, алдаа бол тэнд байна гэдэг нь тодорхой харагдаж байгаа. Прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөв явагдаж байна уу гэдэг дээр хяналт тавих ийм чиг үүрэгтэй.

Гэтэл сүүлдээ мөрдөгчтэйгөө хамтраад зөвхөн яллах талыг баримталж ажилладаг ч юм харж байна. Хэрэг нь буруу байна гээд шүүхээс буцаагдах, цагаатгах асуудал болохоор зүгээр ажлын алдаа шиг авч үзээд тэгээд л үйл ажиллагаа нь жигдрэхгүй яваад байгаа бас асуудлууд харагдаж байна.

С.Бямбацогт: Номинчимэг гишүүний ярьж байгаа асуудал зөв өө. Улсын Их Хурлаас тодорхой хууль батлаад, тогтоол гаргаад Засгийн газарт үүрэг, чиглэл өгөөд тэдгээрийн биелэлт нь ерөөсөө хангалтгүй, биелүүлээгүй олон асуудлууд байх шиг байна.

Тийм болохоор энэ асуудлууд дээр бид бас нэлээн онцгой анхаарах ёстой.

19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Түүнтэй холбоотой 20 онд Үндсэн хуулийн нэмэлтэд нийцүүлж олон хууль тогтоомж батлах ёстой. 20 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль бид нар баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүд 8 хөтөлбөр батлах ёстой. Түүнээс 7 нь батлагдаагүй байгаа. Засгийн газар Их Хуралд оруулж ирэх ёстой. Одоо болтол оруулж ирээгүй байна. Мөн саяын ярьж байгаа асуудал гэх мэтийн юмнууд дээр ингээд хууль биелүүлдэггүй асуудлууд дээр бид онцгой анхаарч ажиллана. Тамгын газар яг энэ асуудлуудын нэгдсэн мэдээлэл гаргаж өг. Тэгээд тэрнийх нь дагуу яг ямар ямар хуулиуд, ямар ямар тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн байна, биелсэн, биелээгүй хэрэгжилтийн талаар товч танилцуулга бэлдэж өгье. Энийг гишүүддээ бас тараагаад цаашдаа бид бас шийдэх бодлогоо тодорхойлъё.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Үг хэлж, асуулт асууна. Би тэнд, дэг байгаа юм байна. нэмэлт 1 минут Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Тэгээд би тэгээд прокурортой холбоотой асуудал ярьж байсан дундуур нь зөндөө юм яриад ингээд юу яачихлаа.

Прокурорын хувьд ч гэсэн бас ачаалал ихэссэнээсээ болоод хэргийг бас нарийн харж чадахгүй сору, past-аад явдаг ч юм асууж байна. Тэгэхээр тэр

сургалтыг сайн хийх ажлаас гадна түрүүний хэлсэн энэ системийн доголдлыг бид нар засахгүй бол прокурор улс төрөөс хараат байдал, ялангуяа сүүлийн үед ажиглагдаж байгаа зүйл ямар нэгэн улс төртэй холбоотой асуудал дээр аль ч шатын прокурор, Ерөнхий прокурорын заавар чиглэл байхгүйгээр хөдөлж чадахаа байж байгаа ийм далд асуудлууд ч гараад байна.

Тэгэхээр бид нар энэ прокурор өөрөө яг хуульд заасан чиг үүргийнхээ дагуу бие даасан байдлаар ажиллаж чадаж байна уу үгүй юү гэдэг дээр маш сайн дүгнэлт хийж ийшээ цаашаагаа явахгүй бол энэ нөгөө хяналт тавьдаг, эрүүдэн шүүх асуудал гараад байгаа юман дээрээ системийн өөрчлөлт бас хийж чадахгүй шүү. Энэ дээр бид нар Улсын Их Хурал ч гэсэн анхаарах ёстой. Энэ чиглэлээр үүрэг, даалгавар өгч байгаа Засгийн газар ч гэсэн адилхан анхаарах ёстой гэдгийг хэлмээр байна.

С.Бямбацогт: Баярлалаа Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Би өөрөө бас ажлын хэсэгт ажилласан учраас Засгийн газарт хандаж, дээрээс нь энэ тогтоолын хэрэгжилтийг бид нар дахиж 1 жилийн дараа бид нар энэ тогтоолын хэрэгжилтийг шаардана. Тэгээд түүнтэй холбоотойгоор үг хэлье.

Энэ тогтоол бол бас зөвхөн Их Хурлын гишүүд ажиллаад гаргасан юм биш энэ үүний цаана 30 гаруй гэр, иргэдийн амь, амьдрал, тэдний гэр бүлийн үнэ цэнээр олдсон ийм тогтоол гэж бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Тийм учраас Засгийн газраас хариуцлагатай энэ дээр ажиллаад тайлагнах ёстой.

Гэхдээ дээрээс нь манай Их Хурал Дэгийн тухай хууль болоод Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульдаа зарим зүйлийг анхаарч хармаар байна. Сая өнгөрсөн 7 хоногт манай Хууль зүйн байнгын хороо өөр бусад бас Байнгын хороонууд ч гэсэндээ Улсын Их Хурлаас Засгийн газарт өгсөн энэ үүрэг чиглэл, тогтоолын биелэлтийн тайланг бид нар бүх Байнгын хороонуудад сонссон. Энэ яаж явж байна вэ гэвэл үндсэндээ тухайн хууль дээр заасан журмыг Засгийн газар баталсан байна уу үгүй юү гэдгийг л тоолоод тэр журам нь батлагдсан бол энэ биелэлт нь бол хангалттай байна гэж үнэлээд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ ерөөсөө бид нарын бие биеийгээ үнэлээд байгаа, бие биеийгээ хянаад байгаа ялангуяа Их Хурал Засгийн газрын үйл ажил ажиллагааг хянаж байгаа энэ процесс өөрөө яг бодит амьдрал дээр, хүний амьдралд өөрчлөлт гаргахуйц байдлаар бид нар энэ үнэлгээ, хяналтаа хийж чадахгүй байна гэсэн үг.

Тэгэхээр шинээр томилогдсон манай Их Хурлын дарга бас энэ дээр амбицтай бас байгаад одоо Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахдаа энэ тогтоол, биелэлтийг Засгийн газрын тогтоолын биелэлтийг энэ хянадаг энэ механизм, дүрэм, журмаа өөрчлөлт тэгэхгүй бол болохгүй нь. Бид нар 3 удаа энэ Засгийн газрын биелэлтийг сонслоо. Тэгээд энэ өөрөө ямар ч үр дүнгүй байлаа гэдгийг бол өнгөрсөн 3 удаагийн сонсгол бол бас харуулсан байх.

Тэгэхээр бид нар яг иргэний амьдралд ямар өөрчлөлт гарч байна гэдгээр л хэмждэг болмоор байна. Тэрнээс Засгийн газрынхан журмаа баталсан уу, бичиг нь

явсан уу, ажлын хэсэг байгуулагдсан уу, тэдэн удаа хуралдсан уу гэдгээр Засгийн газрын ажлыг дүгнэхгүй. Тэгэхээр энэ тогтоол бол манай Хүний эрхийн дэд хороо ч гэсэндээ бас энэ дээр онцгой анхаарал тавьж ажиллана. Эрдэнэболд даргын эхлүүлсэн ажлыг бид нар үргэлжлүүлээд үр дүн рүү чиглүүлэх тал дээр бол анхаарч ажиллана гэдгээ бас хэлье.

Тэгээд анх удаагаа системийн шинжтэй хүний эрхийн зөрчил гэдэг үг, үсэг бас энэ тогтоол дээр тусаж байгаа юм. Тэгэхээр энэ бол өөрөө хэрэгжилтийн маш өндөр ач холбогдолтой. Тэгэхээр энэ асуудал дээр бид нар анхаарч, дараагийн удаа бол бид нар яг энэ тогтоолын хэрэгжилтийг шаардах шалгуур үзүүлэлтүүдээ, үр дүнгүүдээ хэрхэн шаардах вэ гэдэг дээр Их Хурлын хяналт шалгалтын ажлын хариуцсан нэгжтэй энийг бүүр тухайлан ярьж ажилламаар байгаа ийм тогтоол байгаа юм. Тэрнээс биш тогтоол баталсан гэдэг нь ажил хийсэн гэж ерөөсөө бид нар хаах ёсгүй. Энэ тогтоол батлагдсанаар тэр 30 гаруй хүний амьдралд, тэдний гэр бүлд өөрчлөлт гарсан уу.../минут дуусав./

С.Бямбацогт: Баасанжаргал гишүүнд 1 минут.

Х.Баасанжаргал: Тэр иргэдийн эрх сэргэсэн үү, иргэдийн эрх сэргэх итгэл, найдвар ассан уу, жоохон ч гэсэн энэ механизм хөдөлгөөнд орсон уу, дахиж ийм эрүү шүүлт гаргахгүй байхын төлөө энэ Засгийн газрын үйл ажиллагааг чиглэсэн үү, системээрээ ажилласан уу гэдгийг л манай Их Хурал хянана. Тэгэхээр тэн дээр ид хэдүүлээ илүү манай Их Хурал ч гэсэндээ өөрсдөө хариуцлагатай ажиллаж, Засгийн газраас ирж байгаа тайлан шаардлага хангахгүй бол зарим тохиолдолд буцаадаг баймаар байна.

Тэгэхгүй хугацаа нь тулчихсан юм чинь хэлэлцээд л өнгөрөе гэдэг ийм байдлаар бид нар дахиж дараагийн удаа энэ чиг үүргийг шалгаж байгаа энэ сонсохдоо бид нар ийм байдлаар сонсохгүй шүү гэдгийг бас хэлэх гэсэн юм. Холбогдох Засгийн газрын бас хяналт хэрэгжүүлэх газар нь бас анхаарах байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Бас чухал асуудал ярьж байна. Тэгээд Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад бас өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа. Хяналт шалгалтын тухай хуульд. Энэ дээрээ хэрэгжихгүй байгаа тогтоол, энэ дээр нэлээн хариуцлагын заалтууд бас анхаарах ёстой шүү. Манай Тамгын газрынхан бас анхааралдаа аваадхаарай. Тийм, буцаадаг байх, биелэлтээ биелэгдэхгүй бол хариуцлага тооцдог байх Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульдаа иймэрхүү бас заалтууд, зүйл, заалтууд бас оруулъя.

Байнгын хорооны гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалт танхимд хангалттай биш байна. Тийм учраас санал хураалтыг 13 цаг болгож хойшлууллаа.

10.42 цаг

Өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлуудын санал хураалтыг 13 цагаас 12 цаг аа тэр болтол чинь 2, 3 асуудал байна шүү дээ хэлэлцэх. Өнөөдөр төлөвлөсөн асуудлуудаа шахаад дуусгачихъя л гэж байгаа. 13 цагт л дуусгачих гээд оролджё. Дараагийн асуудалдаа орьё. 13 цагаас санал хураалттай тул гишүүд 13 цагт санал хураалтдаа анхаарах ёстой шүү. Саяын асуудал Ардчилсан намын бүлгийн саналаар урагшаагаа орсон. Одоо өмнө нь төлөвлөсөн дарааллыг нь дагаад асуудлаа хэлэлцэнэ. Дараагийн асуудалдаа орьё.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх хэсгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут танилцуулна. Таныг индэрт урьж байна. Батлут сайд яасан бэ?

Д.Батлут: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 74-д Улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасныг хэрэгжүүлэх хүрээнд Улсын төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-д заасны дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг ханган Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын нисэхийн тухай хууль нь 2003 онд анх батлагдаж улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн бөгөөд цаг үеийн шаардлагаар 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ удаагийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүд оруулсан байна.

Тухайлбал, улсын нисэхийн асуудал удирдан чиглүүлэх хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон. Хуулийн үйлчлэлд хамаарах зэвсэгт хүчин Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар зэрэг байгууллагууд шинээр агаарын хөлөгтэй болж байгаатай холбогдуулан тэдгээрийн нэгдсэн бодлого, удирдлагаар хангахтай холбогдсон харилцааны асуудлыг, улсын агаарын хөлгийн бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг, улсын нисэхийн багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан зааж, улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх харилцааг боловсронгуй болгох зэрэг эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгасан нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиас онцлогтой болсон гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд болон олон нийтийн оролцоог хангах зорилгоор

Батлан хамгаалах яамны цахим хуудаст байршуулж хуулийн төслийн хэлэлцүүлгээ хийж, төрийн бус байгууллагуудаас санал авахад бүгд дэмжсэн бөгөөд хуулийн төсөлд ирүүлсэн саналыг хүлээн авч тусгаснаар хуулийн төсөл нь 9 бүлэг, 25 зүйл, 68 хэсэг, 91 заалттайгаар эцэслэн боловсруулагдсан болно.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал шаардахгүй бөгөөд улсын нисэхийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, хяналт, зохицуулалт тодорхой болж, нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин сайжирч, түүнийг дагалдан хуулийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн баримт бичгүүд боловсронгуй болох ач холбогдолтой юм.

Хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Батлут сайдад баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшингийн урилгаар Завхан аймгийн Цэцэн-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 92 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монголд 92 тэмцээндээ Завхан аймгаас ирж оролцоод Төрийн ордонтойгоо танилцаж байгаа юм байна. Бас 92 оны төгсөгчдөдөө Монгол Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай төгсөгч. Би бас 92 оны төгсөгч байгаа. Манай Түвшин гишүүн ч бас 92 оных билүү? Тэр дээр бас дотор нь орчихсон явж байна манай хүн. Түвшин гишүүн ажлаа сайн хийж байгаа шүү гэж хэлж өгөөрэй гэж байна. Хэлээд өглөө шүү.

Одоо төслүүдийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Түвшин гишүүн ээ миний мэндийг сайн дамжуулаад бас миний өмнөөс зураг авхуулчхаарай.

Ч.Анар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар бас 2026 оны 4 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ төслийн хамт төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч улсын агаарын хөлөг шинээр авч ашиглах, нэмэгдэж байгаатай холбогдуулан улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, тэдгээрийн чиг үүргийг хуулиар тодорхойлох, улсын нисэх багц дүрмээр зохицуулах харилцааг нарийвчлан заах, улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох,

гадаадын иргэн гэрээгээр үүрэг гүйцэтгэх болон улсын нисэхийн аюулгүй байдал, нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn-д цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Хуулийн төсөлд улсын нисэхийн асуудлыг удирдан чиглүүлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага болон улсын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар дрон буюу хөнгөн агаарын хөлөг ашиглалтын талаар болон цэргийн зориулалттай дроныг ангилах, ашиглахтай холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвсүрэнгийн Наранбаяр хуулийн төсөлд нэр томъёоны тайлбар хийх нь хуулийг зөв ойлгож хэрэглэхэд өндөр ач холбогдолтой тул зарим нэр томъёог нарийвчлан тодорхойлох талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хуулийн төсөлд Монгол Улсын бодлогын баримт бичиг болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын нисэхийн тухай хууль хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 55.6 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зэвсэгт хүчний тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Анар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Улсын Нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсэг Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Дашцэдэнгийн Баасандамба Батлан хамгаалахын дэд сайд, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч, генерал, Эрхэмбаярын Гансүх тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвдоржийн Идэр Тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн дарга, Гомбосүрэнгийн Энхболд

тус яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх, Зэвсэгт хүчний Жанжин штабаас Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал, Бямбасүрэнгийн Мөнх-Ирээдүй Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч, бригадын генерал ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдөр улс орон даяар бас цэрэг татлага болж байгаа. Улаанбаатар хотод бас өнөөдөр цэрэг татлага эхэлж байгаа тийм үү? Ийм бас батлан хамгаалах салбарт бас онцгой уламжлалт бас явагддаг томоохон арга хэмжээний үеэр манай батлан хамгаалах салбарынхан маань Улсын нисэхийн тухай хуулийг Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр оруулж ирсэн. Хэлэлцэх эсэх явагдаж байна гэдгийг бас онцолж хэлье.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Хуулийн төслийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Бас тодорхой түвшинд бас эргэж харах зайлшгүй шаардлага байх шиг байна. Хоёрдугаарт, энэ төрийн цэргийн байгууллагуудын дунд байгаа энэ нисэх хүчин гэж ярих уу, энэ зүйлүүд нэг хэсэг байхгүй болсон. Буцаад жоохон сэргэж байгаа талууд байгаа. Хил хамгаалах ерөнхий газар ч гэсэн бас тодорхой энэ чиглэлийн үйл ажиллагаа сэргээж байна. Батлан хамгаалахын яам маань угаасаа байгаа. Тэгэхдээ энэ чиглэлийн юмыг жоохон Батлан хамгаалах яамнаас бусад яг цэргийн байгууллагад байгаа гэдэг юм уу онцгой байдлыг бас ярьж байгаа шүү. Энэ чиглэлийн юмнууд зүгээр энэ хуулиар зохицуулагдах уу, эсвэл ер нь Иргэний нисэхийн хуулиар илүү явах талдаа байна уу?

Хоёрдугаарт, тодорхой түвшинд хосолмол байдлаар мэдээж батлан хамгаалах чиглэлийнхээ үйл ажиллагаанд анхаарч бэлэн байдалтай байхаасаа гадна зарим энэ зүйлүүд дээр нөгөө commercial талдаа ажиллах буюу арилжааны нислэг эсвэл, тэр гал түймрийг унтраах байдаг юм уу, эсвэл хортон шавж устгах байдаг юм уу гэх зэрэг ийм бас энэ байгаа нөөц бололцоонуудыг ашиглах бид нарт бас хэрэгцээ, шаардлагууд бас байгаад байгаа юм.

Тэгэхээр уг асуудал бас энэ Улсын нисэхийн тухай хуультайгаа ер нь яаж уялдаж зохицуулагдах ёстой юм бэ? Ер нь энэ хуулиар уг асуудал хөндөгдөж байгаа юу үгүй юү? Энэ дээр бас тодорхой зүгээр иргэд олон нийтэд бас мэдээлэл өгөөч. Бид хэд бол нөгөө энэ нисэх хүчний гэдэг юм уу, энэ агаарын орон зай дээр байгаа энэ техник, технологи чинь хэвтүүлээд байж юм уу, зогсоогоод байж болдоггүй юм байна лээ шүү дээ.

Ер нь бол ашиглалтыг л сайн хийж байх ёстой. Ингэж байж нөгөө үр ашиг байдаг. Энийг дагасан даатгал гэдэг чинь бас их асар өндөртэй байдаг. Тэгэхээр энийг нөгөө төрд татвар төлөгчдөд бас нөгөө дарамт учруулахгүй байдлаар энэ менежментийг хийх бололцоо энэ хуулиар олгогдох уу үгүй юү? Энэ дээр бас манай яг мэргэжлийн хүмүүс хэлж өгөөч гэж санаа байгаа шүү.

Хоёрдугаарт, энэ тэр нисэх онгоц гэхээсээ илүүтэй сүүлийн үед ийм дрон, хөнгөн нисэх төхөөрөмжүүд нэлээн байна. Энэ бас батлан хамгаалах салбарт бол ашиглагдана. Тэгэхээр ер нь уг асуудлыг ер нь цаашдаа яах ёстой юм бэ? Бусад оронд бол энэ дроны асуудлыг бол цэргийн болоод иргэний зориулалтаар ашиглах бололцоотой гээд хоёрдмол зориулалттай техник, тоног төхөөрөмжөө гэж үзээд яг энэ хүчин чадал болон зориулалтаас нь шалтгаалаад бүртгэлжүүлж байна. Үүний нөгөө аюулгүй ажиллагаа, нислэгийн горим энэ тэрийг бас нэлээн шийдэж өгөөд байна.

Гэтэл манайд бол бас энэ асуудал энэ Улсын нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулийн дунд ингээд хаягдаад бас бүрэн зохицуулалт байхгүй байна. Тэгэхээр энийг бас ер нь зүгээр цаашдаа яаж уялдуулж харж байгаа вэ? Хил орчимд бол их тийм бас энэ асуудал яригдахгүй гэхээсээ илүүтэйгээр бас сүүлийн үед бол бас хууль бус үйл ажиллагаануудын дроныг ашиглах энэ байдал бол бас нэлээн байгаа гэж сонсогдоод байгаа шүү дээ. Хил орчмын энэ контрбанд энэ тэр дээр бас гарсан, ганц кэйсүүд бол гарсан.

Тэгэхээр энэ зүйлүүдийг яаж ер нь уялдуулж харж байгаа вэ? Энэ хуулиар явах ёстой юу? Ер нь цаашдаа дроны асуудлыг стратегийн гэдэг юм уу, хоёрдмол зориулалттай тоног төхөөрөмж гэж үзээд тусдаа бие даасан хууль байх ёстой юу? Энэ дээр Зам, тээврийн яам ч гэдэг юм уу, Хууль зүйн яам, Батлан хамгаалах яам ер нь ямар бодлого, шийдвэр барьж байгаа вэ гэсэн ийм ерөнхий 2 асуулт асуугаадахъя.

С.Бямбацогт: Батлут сайд хариулъя.

Д.Батлут: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энэ Улсын нисэхийн тухай хуулиар бид бүхэн батлан хамгаалах салбараас гадна Онцгой байдал, Хил хамгаалах ерөнхий газар гээд цаашлаад гүйцэтгэх үүргийн чиг үүргээс хамаарсан төрийн байгууллагуудтай холбоотой нисэхийн үйл ажиллагаа эрхлэх энэ байгууллагуудын хүрээнд энэ хууль зохицуулагдаж явах ёстой гэж үзэж байгаа.

Одоогийн байдлаар бол Батлан хамгаалах яамнаас гадна Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрууд нисэх онгоцтой болж, түүгээрээ дамжуулж тодорхой чиг үүргүүдээ гүйцэтгэж явдаг. Энэ чиг үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагуудын аюулгүй байдал, нисэхийн аюулгүй байдалтай холбоотой, бусад чиглэлийн чиг үүргүүдийг тодорхой болгож өгсөн ийм онцлогтой хууль болж байгаа гэдгийг танд хэлье.

Нисгэгчгүй нисдэг төхөөрөмжтэй холбоотой асуудлыг бид бүхэн бас энэ хуулиар тодорхой хэмжээгээр зохицуулна. Гэхдээ энэ бол зөвхөн батлан хамгаалах салбартай холбоотой байлдааны зориулалттай нисгэгчгүй нисдэг төхөөрөмж болоод түүнтэй холбоотой зохицуулалтуудыг энэ хуулийн хүрээнд үйлчлэх 11 дүрэм байгаа. Тэр дүрмийн хүрээнд зохицуулаад явах боломжтой болж байгаа.

Харин өнөө цаг үед хугацаанд нисгэгчгүй нисдэг төхөөрөмж дроны хэрэглээ нэлээн өндөр болсон учраас Цахим хөгжлийн яамнаас энэ дрон болоод нисгэгчгүй нисдэг төхөөрөмжтэй холбоотой анхдагч хуулийн төслийг санаачлан

боловсруулаад явж байгаа гэж ойлгож байгаа. Тэр хүрээнд бас бусад хэлбэрийн үйл ажиллагаа явуулж байгаа дронтой холбоотой асуудлууд зохицуулагдаад тэр хуулийн хүрээнд зохицуулагдаад явах боломжтой болох байх гэж ойлгож байна аа. Манайхнаас нэмэлт хариулт байвал хариулж болно.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 номерын микрофон дэслэгч генерал Ганбямба хариулъя.

С.Ганбямба: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энэ хуулиар сая Батлан хамгаалахын сайдын хэлсэнчлэн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын нисэх хэрэгслүүдийн уялдаа холбоог, мөн хэрэглэх, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна. Мөн хэдэн төрлийн нислэг байгаа. Таны хэлсэн арилжааны нислэг гэж бол байхгүй. Гэхдээ бид захиалгат нислэг байхаар энэ хуульдаа тусгаж өгсөн байгаа. Тэгээд онцгой үүргийн болон тусгай үүргийн, захиалгат нислэгийн захиалсан байгууллага нь тухайн нислэгийнхээ зардлыг даах энэ харилцааг бас энэ хуульдаа тусгаж өгсөн байгаа.

Дрон, нисгэгчгүй нисэх хэрэгслийн хувьд энэ хуульд заасны дагуу журмаар зохицуулахаар тусгасан байгаа. Өнөөдөр яах вэ яг бодитой хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй Зэвсэгт хүчний Жанжин штаб бол нисгэгчгүй нисэх ... тэмцэх болон нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах дүрмийг бол боловсруулаад өнөөдөр ашиглаж байгаа гэдгийг илтгэе.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Энэ хууль гарвал ажлын хэсэг мэдээж гарах байх. Тэгэхээр аль болохоор бас дүрэм, журам гэдэг зүйлүүдийг бас багтаад л гарахыг хичээгээрэй дээ. Яг энэ тодорхой энэ уялдаа холбоонуудын суурь зохицуулалтууд хууль дээр орж өгөх ёстой шүү. Би зүгээр арилжааны гээд хэлчхэж. Ер нь захиалгат буюу магадгүй бас төрийн зарим харилцан туслалцааны хүрээнд энэ салбарын юмнуудыг бас гал унтраах байдаг юм уу, ойр хээрийн түймэртэй тэмцэх, эргээд энэ эрүүл мэндийн чиглэлийн байгууллагатай хамтарч ажиллах. Тэгэхгүй яг энэ чиглэлийн юмнууд нь жоохон ингээд бага болчихоор нөгөө хууль зөрчих гээд байгаа ч юм шийдвэр гарч өгдөггүй. Тэгээд ингээд тухайн байгууллагууд маань бас өөр өөрсдийн ийм зүйлүүдийг давхардуулж бий болгох гэдэг юм уу ингээд бас татвар төлөгчдийн мөнгө үргүй явах ийм чиглэлтэй байна.

Дроны асуудлыг бол онцгой анхаараасай гэж хүсэж байна. Би ч гэсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр энэ юу гэдэг юм кибер гэдэг юм уу, энэ цахим спортын асуудлыг дэмжээд байгаа. Ер нь бусад орнууд чинь энэ цахим спортыг дэмжих хүрээндээ цаашдаа нисгэгчгүй энэ тоног төхөөрөмжүүдийнхээ.../минут дуусав./

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя. 1 минут Сайнзориг гишүүнд .

П.Сайнзориг: Энэ нисгэгчгүй тоног төхөөрөмж бол их дроны нисгэгч гэдэг зүйл чинь угаасаа л хүн удирдаж байгаа. Тэгэхээр энийг удирддаг ойлголт мэдээллийг бол үндсэндээ ингээд бусад орнууд бол ерөөсөө 10 жилийн боловсролоос нь олгоод байгаа юм. Энэтэй яаж зөв боловсон харьцах вэ аюулгүй ажиллагаа нь юу байдаг юм гээд. Ер нь тэр Европын орнуудын, Нордек орнуудын

боловсролын системд бол ингээд цахим спортын асуудал ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Яг эцсийн дүндээ спорт гээд байгаа боловч энэ чинь цэрэг, батлан хамгаалах салбарын цаашдын чиг хандлагадаа тохируулаад залуу боловсон хүчнүүдтэй энэ техник технологитой харьцах энэ үйл ажиллагааны суурийг тавиад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас би бол бас ингээд ийм хуулийн төсөл яагаад тэгээд бас Их Хурлын дарга бас хэлэлцүүлэх асуудлыг нь анхаарч өгөөд ер нь цаашдаа бид хэд бас аль болохоор залуу үеэ энэ техниктэй, технологитой зөв харьцах, тэрнээс биш дэлгэц ширтэж байна гэдэг агуулгыг нь бас хэтийг өргөж яриад байгаа. Ер нь зүгээр энэний зохистой хэрэглээд аюулгүй ажиллагааны талаас нь бас анхаарч бас ойлгуулах хэрэгцээ бол байгаа шүү гэдэг зүйлийг хэлмээр байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хуулийн төсөлд улсын агаарын тээврийн хөлгийн засвар, үйлчилгээг зөвхөн цэргийн байгууллага хийнэ. Улсын нисэхийн нисгэгчийг зөвхөн цэргийн байгууллагын бүтцэд бэлтгэнэ гэж заасан байна л даа. Зүгээр олон улсын туршлагаар харахад бол энийг бас тодорхой жишээлбэл засвар, үйлчилгээний бол тодорхой хэсгүүдийг нь хувийн хэвшлээр ч юм уу Батлан хамгаалах яаманд зөвшөөрөл гэрээ хийсний үндсэн дээр ингээд шилжүүлж болдог. Сургалт дээр ч гэсэн бас яг энэ сургалтын модулиудыг хувийн компаниуд дээр бас ингээд байдаг.

Тэгэхээр энэ талаар ер нь энэ хувийн зарим энэ бүх юмыг өөр дээрээ авчихаар төрийн зардал бас нэмэгдэх эрсдэл бас байгаа учраас энэ талаар зүгээр энэ хууль дээр ийм тодорхой хэсгийг нь жишээлбэл үйлчилгээний хэсгийг нь Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн байгууллагатай гэрээ хийсний үндсэн дээр хувийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэдэг ч юм уу иймэрхүү зохицуулалт оруулах орон зай хэр байдаг юм? Энэ талаар асуулт.

Хоёрдугаарт, манай улсын хувьд бол бас энэ нутаг дэвсгэр өргөн тэгээд тодорхой бас эдийн засгийн салбарууд аялал жуулчлал жишээлбэл Монголд ирж байгаа жуулчид бол 17-14 хоногийн хугацаатай л ирдэг. Машинаар тэр хол газар олон давхиж чаддаггүй. Энэ нисэхийн энэ аэро дромтой холбоотой дэд бүтцүүд хангалтгүй байдаг. Улсын энэ нисэх дээр энэ хуулиар зохицуулагдаж байгаа энэ аэро дромуудыг иргэний болон энэ аялал жуулчлалын зорилгоор ашиглах энэ бололцоо, боломжуудыг нээх, хамтарч ажиллах тийм орон зай хэр байдаг юм?

Нөгөө талаасаа бас улсын энэ нисэхийн зориулалтаар хувийн бий болчихсон аэро дромуудыг бас ашиглавал заавал жишээлбэл өөрсдөө аэродром бариад байх шаардлагагүйгээр бас иймэрхүү зохицуулалтын илүү өргөн болох бололцоо боломж байдаг уу гэдэг асуулт байна.

Дээр нь энэ аэродромтой холбоотой асуудал дээр яг энэ хууль дээр болохоор зөвхөн аэродром л гэсэн ойлголт байна лээ. Тэрнээс гадна жижигхэн энэ нисдэг тэргүүд /helicopter/, нисдэг тэргүүдийн буух талбай, энэ буудалтай холбоотой аэродромоос арай бага шаардлагатай ийм талбайнуудын талаар, буух талбай гэх үү зурвас гэх үү энэ талаар бас яг хууль дээр нэр томъёо тодорхой

заасан юм байхгүй байна лээ. Энэ талаар ямаршуу бодолтой байгаа юм? Зөвхөн аэродром л байна гэсэн бодолтой байгаа юу? Ийм асуултууд байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Дамбын Батлут сайд хариулъя. Ажлын хэсэг.

Д.Батлут: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ хуулиараа төрийн цэргийн болоод хууль сахиулах байгууллагад ашиглагдаж байгаа энэ нисдэг тэрэгнүүдтэй холбоотой, тэдний аюулгүй нислэг, техникийн үйлчилгээ гээд бусад зүйлийг энэ хуулийн хүрээнд зохицуулж байгаа. Яг үнэндээ бас бид нар хувийн хэвшилтэй хамтран ажиллахад асуудал бий. Энэ батлан хамгаалах салбар өөрөө онцгой салбар учраас зарим нэг зүйл бас хаалттай явдгийг та бүхэн, та бас ойлгож байгаа байх гэж бодож байна.

Тийм учраас бид бүхэн илүүтэй хувийн хэвшилтэй хамтрах гэхээсээ илүүтэй өөрсдийн хэмжээнд засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлуудыг зохион байгуулах ийм боломжууд дээр анхаарч ажиллах ёстой гэж үзэж байгаа. Тэр чиглэлээр ч гэсэн манайд бас мэргэшсэн хүмүүс байгаа. Бас мэргэшсэн хүмүүсийг цааш нь давтан сургах, сургалтад хамрах боломжууд бас байгаа гэдгээ хэлэх нь зүйтэй байх.

Хоёрдугаарт нь аялал жуулчлалтай холбоотой аэродромтой холбоотой асуудлууд яригдлаа. Мэдээж энэ нисдэг тэрэгтэй холбоотой асуудлууд бол газар орны нөхцөл байдал харгалзахгүйгээр буудаг. Харьцангуй тийм ашиглах өргөн боломжтой зүйл. Тийм учраас бид бүхэн бол тухайн нислэгийн шинж чанараас, захиалгаас хамаарсан байдлаар бас буух талбайнуудаа ашиглах, урьдчилан бэлтгэж зохион байгуулах ийм боломжтой байдаг.

Манайд ашиглагдаж байгаа аэродромтой холбоотой асуудлыг бас хувийн хэвшилтэй хамтран ашиглах боломж бол бас хомс. Яг үнэндээ тусгай зориулалтын ийм аэродромууд байгаа учраас бид бүхэн тэрийг өөрсдийн дотоод зохион байгуулалтдаа ашигладаг гэдгийг танд бас хэлэхийг хүсэж байна.

Манай нислэгийн хувьд бол дараах чиглэлээр ангилж байгаа. Байлдааны үүргийн нислэг, онцгой үүргийн нислэг, тусгай үүргийн нислэг, захиалгат нислэг, сургууль, байлдааны нислэг, шалгалт, туршилтын нислэг, сургууль, дадлагын нислэг, олон улсын нислэг гээд. Тэгэхээр энэ хүрээнд жишээлбэл аялал жуулчлалтай холбоотой өргөн дэлгэр газар нутагтай учраас нисдэг тэргүүдийг ашиглах боломжууд бий. Энэ хүрээнд бол тухайн аялагч маань мөнгө төгрөгөө төлөөд захиалгат нислэгт хамрагдах боломжууд байгаа гэдгээ хэлье. Баярлалаа. Манайхан нэмэлт хариулт хэлж болно.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Асуулт асуугаад тэгээд тодруулъя. Энэ хууль бол бас цаг үеийн шаардлага нь бол хугацааны хувьд болсон гэж үзэж байгаа. Улсын нисэх болон нэгд нь иргэний нисэхийн зохицуулалт нь нөхцөлдсөн үед байгууллагын шийдвэр аль байгууллагынх нь шийдвэр илүү давуу үйлчлэх юм? Улсын агаарын хөлөг, иргэний зориулалтын нислэг энэ захиалгад эсвэл аэродром гээд хамтран ашиглах үед зөвшөөрөл, хариуцлагын эцсийн эзэн нь хэн байх вэ? Эрх мэдлийн

давхардлаас шалтгаалаад осол гарсан тохиолдолд хэн хариулах вэ гэдэг асуудлыг анхаармаар байна.

Улсын нисэхийн аюулгүй байдлыг хангах, нислэгийн зөвшөөрөл олгох, осол зөрчлийг шалгах чиг үүргүүд нь нэг салбар дотор хэт төвлөрөхөөр өөрөө өөрийгөө шалгах нөхцөл үүсэхгүй юу? Ослын шинжилгээний хараат бус байдлыг хангах тусгай баталгаа энэ төсөлд хангалттай туссан гэж үзэж байна уу? 23, 24 дүгээр зүйл дээр энийг тусгайлан нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

Гуравд нь улсын агаарын хөлийн бүртгэл тусдаа байх нь зөв боловч аюулгүй ажиллагаа, техникийн үзлэг, осол зөрчлийн мэдээлэл, аэродромын ашиглалт зэрэг мэдээлэл иргэний нисэхийн мэдээллийн сантай ямар түвшинд солилцогдох бэ? Нэгдсэн мэдээлэлгүй бол нислэгийн аюулгүй байдалд эрсдэл үүсэхгүй юу? Тэгэхээр энэ 12 дугаар зүйл дээр мэдээлэл солилцох журмаа тусгах шаардлагатай юм байна гэж харж байна.

Одоо жил бүр нөгөө мэргэжлийн хүний гэрчилгээ энийгээ жил бүр сунгаж баталгаажуулна гэж байна. Тэгээд энэ нь зүгээр бичиг баримтын шалгалт хийх юм уу, эсвэл нөгөө симулятор ч байдаг юм уу, нислэгийн цаг, онцгой нөхцөл, эрүүл мэнд, энэ сэтгэл зүй эд нар талынхаа асуултууд дээр үндэслэх юм уу гэдгийгээ бас тодорхойлохгүй бол бүрхэг байна. Үүн дээрээ анхаарах уу? Хамтарсан аэродром дээр осол зөрчил, саатал, аюулгүй байдлын доголдол гарвал иргэний нисэхийн байгууллага нь хариуцах юм уу, эсвэл улсын нислэгийн байгууллага хариуцах юм уу? Хамтран ажиллах аэродром чинь нэг удирдлага, нэг стандарт, нэг хариуцлага гэдэг зарчим энэ хуульдаа хангалттай туссан уу? Нэгдсэн удирдлага, онцгой байдлын төлөвлөгөө хариуцлагынхаа матрицыг журамлах заалт нэмэх шаардлагатай байна гэж хараад байгаа.

Орон нутгийн байгууллагууд нь ингээд тэр 20.3-д байгаа үүрэгтэй яваад байхаар сургалт тоног төхөөрөмж, холбоо мэдээллийн бэлэн байдал санхүүжилтийгээ хэн хариуцах юм бэ? Үүрэг өгсөн хэр нь чадавхжуулж өгөхгүй бол энэ заалт хэрэгжих боломж байгаа юу? Аюулгүй байдлын сангийн зарцуулалт, тайлагнал хаана байна вэ? Мэдээллийн сан нь эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, давтан зөрчлийн дүн шинжилгээ хийнэ байна гэж тодруулж ингэж оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ саналыг хүлээж авахад бэлэн үү?

25 дугаар зүйлд байгаа тэр нислэгийн аюулгүй байдал, агаарын хөлгийн бүртгэл, нисэх багийн гэрчилгээ, аэродром ингээд ослын газрын хамгаалалт зэрэг зөрчлүүдэд тусгай хариуцлагын механизм байхгүй бол энэ ер нь хэрэгжих тэр хүч нь сулрахгүй юу хууль нь? 25 дугаар зүйл дээрээ энэ зүйлээ тусгах боломжтой байна уу гэж асууж байна. Тэгээд энэ хуулийнхаа төсөлд ингээд улсын нисэхийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах, осол, зөрчлийг шалгах чиг үүргүүд нэг салбар дотор төвлөрчихсөн байж байгаа. Нислэгийн аюулгүй байдлын гол зарчим бол хараат бус хяналт, хараат бус ослын шинжилгээг ямар заалтуудаар бодитойгоор баталгаажуулж байгаа вэ? Хэрэв тусгай баталгаа байхгүй бол 22-оос 24, тийм 22-оос 24 дүгээр зүйлд хараат бус байдлын шалгуур нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

Тэгээд энэ хуулийн төсөл бол хэлсэн цаг үеийн шаардлагатай үед орж ирж байна. Улсын нисэхийн үйл ажиллагаа, хяналт, осол, зөрчлийн шинжилгээг нэг

тогтолцоонд төвлөрөхөөс сэргийлж хараат бус хяналтын баталгааг.../минут дуусав./

С.Бямбацогт: Батлут сайд асуултад хариултаа бэлдэж байгаарай.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшингийн урилгаар Завхан аймгийн Улиастай хотын 2 дугаар сургуулийн 1976 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай Түвшин гишүүн байна уу? Түвшин гишүүн бол баруун бүсээс Говь-Алтай, Завхан, Увс, Ховд гэсэн аймгуудаас сонгогдсон гишүүн байгаа. Тэгээд бас Завхан аймагтаа бид нэлээн олон томоохон бүтээн байгуулалт замуудын ажлыг бас их хамтдаа эхлүүлсэн байгаа шүү гэдгийг та бүхэнд бас хэлье. Ингээд та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

40 жилийнхээ ой тэмдэглэж байгаа юм байна тийм ээ. 10 дугаар анги төгссөнийх 40 жилийн ой тэмдэглэж байгаа. 50 жилийнхээ ой тэмдэглэж байгаа тийм. Мундаг байна. Бас баяр хүргэе бүгдэд нь. Түвшин гишүүн ажлаа сайн хийж байгаа шүү гэж Даваагийн Цогтбаатар гишүүнд дамжуулаарай гэж байна. Дамжууллаа.

Батлут сайд хариулъя.

Д.Батлут: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Манайхан бас нэмэлт хариулт бэлдэж байгаарай. Энэ Улсын нисэхийн тухай хууль бол тусдаа хууль. Иргэний нисэх бол Иргэний нисэхийн тухай хууль болон олон улсын хууль тэр хууль, эрх зүйн орчноороо зохион байгуулалт мөрдөгдөөд явж байгаа. Мэдээж энэ дотор бас бидний хувьд Улсын нисэхийн хуультайгаа дүйцүүлэх хэмжээний зохицуулалтууд бас байгаа.

Тэгэхдээ Иргэний нисэхийн тухай хуулийн дагуу иргэний хэсэгтэй холбоотой асуудлууд зохицуулагдаж байна. Энэ бол улсын нисэх буюу өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай холбоотой, тэнд ашиглагдаж байгаа нисдэг тэрэгтэй холбоотой асуудлуудыг энэ хууль эрх зүйн хүрээнд зохицуулж явж байгаа юм.

Энэ одоогийн байдлаар бол Онцгой байдал, Хилийн цэрэг, манай Зэвсэгт хүчин гээд өөр өөрсдөө нисэхийнхээ үйл ажиллагааг хариуцаад ажиллаж байна. Энийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, техникийн хяналт болоод аюулгүй ажиллагаатай холбоотой бүхий л зохицуулалтуудыг нэгдсэн удирдлагаар хангах боломжийг энэ хууль, эрх зүйн хүрээнд бүрдүүлж өгөх гэж байгаа гэдгийг танд бас хэлэхийг хүсэж байна. Манайхан нэмэлтээр хариулчих уу?

С.Бямбацогт: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя. Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Нэмэлт хариулт дээр ажлын хэсгийнхэн хэлэхгүй бол их товчхон хариулт явчихлаа. Би уг нь нэлээн олон асуулт асуусан. Тэгээд энэ хуулийн төсөл дээр би бол батлуулах нь зүйтэй гэж үзээд байгаа шүү дээ. Гэхдээ

иргэний нисэх, улсын нисэх тусдаа хуультай гэдгийг бол мэдэж байгаа. Батлан хамгаалах, иргэний нисэх, онцгой байдал, орон нутгийн байгууллага, аюулгүй байдлын мэдээллийн сан осол зөрчлийн шинжилгээ зэрэг ийм олон байгууллагуудын огтлолцол дээр энэ хууль хэрэгжихээр төсөл дээрээс нь харагдаад байгаа юм.

Дээрээс нь дэлхий даяар үүсэж байгаа нөхцөл байдлууд, одоо энд тэндгүй галын бүс үүсэж байгаа нөхцөл байдлуудад бол иргэний барилга байгууламж руу цохилт өгөхгүй, цэргийн барилга байгууламж руу цохилт өгнө гэсэн ийм концепц явж байдаг. Хэрвээ иргэний аэродромыг ашиглаад эхэлбэл энэ чинь өөрөө цэргийн байгууламж гэдэг юу руугаа яваад эхэлнэ. Дээрээс нь энэ олон байгууллагын энэ огтлолцол дээр.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Дэслэгч генерал Ганбямба 4 дүгээр микрофон.

С.Ганбямба: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ иргэний нисэхийн, олон улсын иргэний нисэхийн байгууллагын дүрэм гэж байдаг. Тэгээд энэ дүрмийн 13 дугаар хавсралт дээр Осол зөрчлийг хянан шалгах алба гэж алба ажилладаг. Энэ Зам, тээврийн сайдын тушаалаар баталгаажсан ийм алба ажиллагаа энэ.

Улсын нисэхийн тухайд бол Батлан хамгаалах яаман дээр Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын алба гэж байгаа. Тэгээд энэ хуулийн дагуу тэр ажлын албан дээр хараат бус шинжээчийн бүлэг ажиллана гэдгийг бас илэрхийлье. Энэ бол өөрийгөө шалгах биш энэ Зэвсэгт хүчний Жанжин штаб, Агаарын цэргийн командал, Хил хамгаалах ерөнхий газар энэ агентлагуудад ашиглагдаж байгаа улсын нисэхийн хэрэгслийн осол, зөрчил, аюулгүй байдлыг Батлан хамгаалах яам, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээр ажиллаж байгаа энэ Улсын нисэхийн хэлтэс, мөн Батлан хамгаалах ерөнхий хянан шалгагчийн ажлын албанд байгаа шинжээчийн бүлэг ажиллана гэдгийг танд илэрхийлье.

С.Бямбацогт: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Батбаатар сайдын асуултад бүрэн хариулсан юм уу? Нэлээн л юм асуугаад байх шиг байсан.

Энэ Улсын нисэхийн тухай хууль улсын агаарын хөлөг эзэмшигч энэ төрийн байгууллагын үйл ажиллагааг нэг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах, хяналт тавих чиг үүргийг л зохицуулах гээд л орж ирж байгаа хууль гэж ойлгож байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх шаардлага үүссэн гээд энэ хуулийн үндэслэл, шаардлага дээр бичсэн байгаа юм. Тэгээд би энэ хуулийг нь хараад байхлаар энэ дээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулсан дагалдах хууль дээр ерөөсөө юм байхгүй юм. Тэгээд энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн яг ямар заалтад өөрчлөлт оруулсан юм? Би юм олж харсангүй.

Хоёр дахь нь Зэвсэгт хүчний агаарын цэрэг, Хил хамгаалах ерөнхий газар, энэ Онцгой байдал эд нар 20 оноос хойш нэлээн парк шинэчлэл хийсэн бололтой юм. Бид нарт энэ өгсөн мэдээлэл дээр бол агаарын хөлгийн тоо байна л даа. 20 он оноос өмнөх нь ер нь хэд байсан юм бол? Энэ дээр хэлж болдог юм уу үгүй юм уу? Бас нууцад орох юм уу?

Гурав дахь нь тэр тусгай болон онцгой үүргийн нислэгт ашиглах агаарын хөлгүүдийг ашиглах бөгөөд энэ одоогоор энийг ашиглахад даатгал болон эрх зүйн зохицуулалт байхгүй гээд бичсэн байна. Тэгээд одоо энэ үнэтэй агаарын хөлгүүдийг ашиглаж байгаа юу? Ашиглаж байгаа бол огт даатгалгүй ашиглаж байгаа юм уу? Эрх зүйн зохицуулалт нь хэзээ бэлэн болох юм, Улсын Их Хуралд хэзээ өргөн барих юм энэ чиглэлийн мэдээллүүдийг эхлээд авмаар байна.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Дамбын Батлут сайд хариулъя.

Д.Батлут: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 74-д Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 25 онд хуулийн төслийг улсын, боловсруулж өргөн мэдүүлэхтэй холбоотой асуудал зохицуулагдсан байгаа. Үүний хүрээнд Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна гэдгээ танд хэлье.

Агаарын хүлгийн тоо гээд бусад мэдээллүүдийг манай ажлын хэсгээс хариулчихъя.

С.Бямбацогт: Сүнрэвийн Ганбямба, 4 дүгээр микрофон.

С.Ганбямба: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Нисэх хэрэгслийн тоо баримтын хувьд бол бас энэ нээлттэй хуралдаан учраас бас ярих боломж алга. Гэхдээ парк шинэчлэл хийж байгаа. Хамгийн сүүлд бид нар агаарын цэрэгтэй 2024 онд “Эйрбас” компанийн “Эйч 145 ди 3” гэдэг нисдэг тэрэг авсан байгаа. Одоо ашиглаж байна.

Даатгалын хувьд бол байлдааны зориулалттай нисэх онгоц, сөнөөгч онгоц, байлдааны зориулалттай нисдэг тэрэг бол даатгалгүй. Олон зориулалттай тээврийн нисдэг тэрэг ялангуяа сая бид нарын сүүлд авсан тэр “Эйрбас” компанийн “Эйч 145” бол даатгал хийгээд явж байгаа. Дууслаа.

С.Бямбацогт: Би яах вэ нэмээд хариулчихъя. Төрийн цэргийн байгууллагууд бол сүүлийн жилүүдэд нэлээн парк шинэчлэл ялангуяа онгоцны парк шинэчлэл хийгдсэн. Онцгой байдал 4, 5-н онгоцтой болсон. Хилийн цэрэг бас 2 онгоцтой болсон. Батлан хамгаалах салбар МиГ 170 том нисдэг тэрэгнээс их засвар хийсэн гэх мэтийн ажлууд хийгдсэн.

Мөн бас миний хувьд бас Батлан хамгаалахын сайд байхдаа хөрөнгө оруулалтыг 4 дахин нэмэгдүүлж, бүх цэргийн ангиуд бүх батлан хамгаалахын харьяа байгууллагуудын унаа, машиныг бас шинэчилсэн. Гэхдээ тэнд тэр тансаг зэрэглэлийн машин биш туулах чадвар сайтай тэр нөгөө Jimmy, Nissan Navara

маркийн бага зардлаар бага өртөгтэй машинаар бас шинэчлэлт хийсэн байгаа гэдгийг бас хэлье.

Тодруулж асууя. Гомбын Ганбаатар гишүүн. Сая Батбаатар гишүүн гээд хэлчихлээ. Гомбын Ганбаатар гишүүн асуултаа тодруулъя.

Г.Ганбаатар: Энэ өргөн барьсан хууль дээр чинь харин тэгээд Улсын нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох нөгөө дагалдах хууль нь Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай байна л даа. Тэгээд хуулийн төсөл нөгөө хуулийн үндэслэл дээр үүнтэй холбоотойгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх шаардлага гарсан гэж бичсэн байх юм. Ямар заалтад нь нийцүүлэх гээд байгаа юм гэж асуугаад байна л даа би.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Дэд сайд ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Д.Баасандамба: Батбаатар гишүүнд баярлалаа. Энэ хуулийн үйлчлэх бүрэн эрхийг тогтоохдоо Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэхийн тулд өмнө нь зохицуулагдаагүй байсан улсын нисэхийг хөгжүүлэхтэй холбоотой төрийн бодлогыг батлах эрх үүргийг Их Хуралд, улсын нисэхийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэн эрхийг Засгийн газарт зохицуулахаар тусгах замаар төрөөс улсын нисэхийн талаар эрх зүйн болон хөгжил, төсөл, санхүүжилттэй холбоотой заалт нэмэгдэж орсон.

Мөн түрүүний асуулт дээрээс нь даатгалтай холбоотой бол Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10.1.5 дээр улсын нисэх хөлгийг эзэмшигч байгууллага нь улсынхаа, өөрийн бүртгэлд байгаа нисэх хөлөг, нисэх багийг заавал даатгуулсан байх гэсэн зохицуулалтыг нэмж тусгасан байгаа. Хариулж дууслаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургуулийн 8^Г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай Мөнхбаясгалан гишүүн бол байгаль орчныг хамгаалах чиглэлээр ялангуяа говийг усжуулах чиглэлээр бас томоохон санал, санаачилга гаргаж ажиллаж байгаа гишүүдийн нэг гэдгээ бас онцолж хэлье. Ингээд нийт хүүхэд, багачууддаа, сурагчдадаа сурлагын өндөр амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Аав, ээж, багш нарынхаа үгэнд орж бас онц сураарай гэж та бүхнээс бас хүсье.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. Би энэ нэршлийн талаар эхлээд тодруулаад асуугаадахъя. Улсын нисэхийн тухай хууль гэж ойлгохоор иргэнийхээ нисэхтэйгээ хэр уялдаж байгаа юм бэ? Ялангуяа иргэний нислэг гэдэг бол арилжааны чиглэлээр тогтмол олон улсын хуваарьтай олон стандартууд мөрдөгддөг. Харин цэргийн нислэг бол нууцлал, шуурхай үйл ажиллагаа, онцгой горим гээд бас тусдаа хэм хэмжээнүүд явагддаг. Тэгээд улсын гээд энэ хуулийн

гол зорилго нь болохоор ингээд улсын гэгчээр чинь зэрэг арилжааныхан ч ороод, төрийнхөн ч ороод ингээд нийт ингээд улсын нислэгийг л хяналтдаа авах гээд байна гэж ойлгож байгаа нь миний зөв үү гэдгийг маш тодорхой тайлбарлаад өгөөрэй.

Тэгээд хууль зүйн хувьд энэ хууль бичсэн хүмүүс дээр нэлээн хэд хэдэн энэ хууль зүйн алдаанууд байгаад байх юм. Жишээгээр нислэг, нисэхийн үйл ажиллагааг зохицуулах журмыг эрх бүхий байгууллага тогтооно. Тэгээд журмаар тогтооно гээд аягүй их хэрэглэгдсэн байна л даа. Тэгээд хэрвээ иргэний асуудал оролцож байгаа бол иргэний хуулийг ингэж журмаар, хэм хэмжээ тогтоох нь хууль зүйн хувьд би бол зөрчил гэж харж байна. Энийгээ тайлбарлаач ээ.

Дараагийнх нь зүйлд ийм тодорхойгүй аюулгүй байдлыг хангах, зохицуулах, нэгдсэн бодлого гэдэг яг хэмжих нэгжгүй тэгээд шалгуур үзүүлэлт байхгүй ийм ерөнхий ийм заалтуудыг тусгасан байна. Энийгээ тайлбарлаж өгөөч. Яагаад тодорхой болгож өгөөгүй юм бэ? Хяналтын хувьд жишээлбэл хяналт тавих чиг үүргийг заасан боловч зөрчил гаргавал ямар хариуцлага ноогдуулахыг нарийвчилж заагаагүй байгаа юм. Тэгэхээр үүрэг байгаа боловч хариуцлага нь тодорхойгүй ийм хуулийн төсөл орж ирсэн байна. Тэгээд энэ 2003 оны хуулийг хүчингүй болгоод шинэ хуулиа ингээд мөрдүүлээд ажиллах нь байна. Энэ яг шилжилтээ ямар үе шаттайгаар хийх нь бас энэ хуулийн төсөл дээр тодорхойгүй байна. Танилцуулга дээр тодорхойгүй байна. Эдгээрийг тайлбарлуулаад тэгээд хариулт авъя. Тодруулна.

С.Бямбацогт: Дамбын Батлут сайд хариулъя.

Д.Батлут: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Мэдээж энэ Улсын нисэхийн тухай хууль маань 2003 онд анх батлагдсан байгаа. Түүнээс хойш 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Түүний 5 нь тодорхой хуулийн өөрчлөлттэй холбоотой дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон асуудлууд байна. Энэ удаад бид бүхэн бол Улсын нисэхийн тухай хууль дээр өнөө цаг үеийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан нэмэлт, өөрчлөлтийг оруулаад явж байгаа. Нэршлийн хувьд бол Улсын нисэхийн тухай хууль гэж явж байгаа хэдий ч энэ Иргэний нисэхийн хуультай бас тодорхой хэмжээгээр уялдаж, холбогдож харилцан зохицуулалтууд хийгдсэн байгаа гэж ойлгож болно.

Улсын нисэхийн тухай хуулийн хүрээнд бол зөвхөн батлан хамгаалах салбар болоод, төрийн цэргийн байгууллага болоод хууль тогтоох байгууллагуудад ашиглагдаж байгаа, цаашлаад төрийн байгууллагуудад ашиглагдаж болох тийм нисэх, нисдэг тэрэгтэй холбоотой, түүнтэй нислэгийн болоод аюулгүй байдал бусад харилцаатай холбоотой асуудлыг л зохицуулах ийм зохион байгуулалт хийгдэх ёстой юм гэдгийг танд хэлье.

Стандарт мөрдөгдөх ёстой. Тодорхой журмуудаар бас зохицуулах дүрмүүдээр зохицуулах зүйлүүд байна. Батлан хамгаалах сайдын бүрэн эрхийн хүрээнд батлагдсан 7 дүрэм бий. Улсын нэгдсэн санд бүртгэлтэй дүрэм байгаа. Одоо энэ хууль батлагдсанаараа 11 дүрэм болж өөрчлөгдөж байгаа. Энэ дээр нэмэлт зохицуулалтуудыг энэ хийгээд явах боломжтой, нэмэлт зохицуулалтууд энэ дүрмээр хийгдээд явах юм. гэдгээ танд хэлье.

Зөрчил гаргавал яах вэ гэж. Хуулийн төслийн 25 дугаар зүйл дээр байгаа. Мэдээж тухайн хууль зөрчсөн албан тушаалтан гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухайн хууль болон Цэргийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Мэдээж гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээгээд явах ийм нөхцөл байдал үүснэ гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Тодруулъя Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Ингээд байгаа юм л даа энэ хуулийн төсөл дээр нислэг эрхлэх агаарын хөлөг ашиглахад зөвшөөрөл авна. Шаардлага хангаагүй тохиолдолд үйл ажиллагааг зогсооно гээд. Энэ шаардлага гэдгийг яг юу гэж ойлгох вэ? Тэгээд энэ арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нисэхийн үйл ажиллагаанд Батлан хамгаалах яам төр оролцоод, эхлээд, тэгээд журмаар зохицуулаад, тэгээд эсвэл өөрсдийнхөө энэ үйл ажиллагаанд нь хүнд суртал, төрийн дарамтыг үүсгээд эхэлбэл яах вэ гэдэг энэ зохицуулалт байхгүй байгаад байна л даа. Тэгэхээр энэ захиргааны байгууллага дур мэдэн шийдвэр гаргах эрсдэл аягүй өндөр ийм хуулийн төсөл орж ирж байна. Энийг яг та бүхэн маань сайн тайлбарлах нь зүйтэй байх.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ Батлут сайд.

Д.Батлут: Энд бол иргэний нисэхийн асуудал хамааралгүй. Улсын нисэхийн тухай хуульд. Зөвхөн төрийн цэргийн болоод хууль сахиулах байгууллагуудад ашиглагдаж байгаа энэ нисдэг тэрэг, бусад онгоцтой холбоотой асуудал энэ хууль, эрх зүйн хүрээнд зохицуулагдаж байгаа юм. Тэгээд улсын нисэхийн гэдэг утгаараа тэгж ойлгогдож болно гэж ойлгож байгаа. 2003 онд батлагдсан хууль нэмэлт, өөрчлөлт ороод явж байгаа. Нэршлийн хувьд та тодорхой саналаа хэлж болно. Тэн дээр бас ярилцаад явах боломжууд бас гарах байх гэж бодож байна.

Мэдээж энэ нислэг гэдэг бол өөрөө аюулгүй байдал, техникийн бэлэн байдал, нисгэгчийн асуудлууд гээд асар олон зохицуулалтууд байх ёстой. Жишээлбэл заавал багш нисгэгч байж байж нислэг үйлддэг байх ёстой гэдэг ч юм уу. Дээрээс нь техникийн бэлэн байдал, аюулгүй байдалтай холбоотой олон харилцааг энэ хуулиар зохицуулах учраас заавал энэ хууль дээр мэдээж.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Хариултаа дуусгачихъя.

Д.Батлут: Заавал энэ хууль дээр эрх зүйн зохицуулалттай холбоотой тухайн зөвшөөрлийг олгодог эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбоотой эрх болоод хариуцлагын асуудлуудыг зохицуулж өгсөн байгаа гэдгийг тодотгож хэлье.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд. Асуултууд ерөнхийдөө давхардчихлаа. Хувийн хэвшлийн оролцоо, өрсөлдөөнийг дэмжих тэр чиглэлийн агуулгуудыг бас нэлээн асууя гэж бодож байлаа. Ерөнхийдөө бас Иргэний нисэхийн хуулиараа зохицуулаад явна гэдэг ийм хариулт өгч байх шиг байна. Мөн дээрээс нь бас

зорчигчийн эрхийг хамгаалах тухай асуудлууд бас энэ дээр байх уу гэдэг ийм асуулт бас байсан юм.

Нарийвчлаад бас 1 асуулт асууя. Орон нутгийн, ер нь түвшинд ер нь нисэх буудлууд тэнд бас байгаа ажилтан албан хаагчид болон чиг үүргүүдийн хувьд бас тодорхой зохицуулсан асуудлууд энэ хууль дээр байна уу? Хуулийн төслийн 14 дүгээр зүйл дээр улсын агаарын хөлгийн нислэгийн ангиллуудыг оруулж ирсэн байна. Энэ дунд сургууль, байлдааны нислэг, мөн дадлагын нислэг гээд сургалт, үйл ажиллагаатай холбогдолтой бас хэсгүүдийг дурдсан байна.

Тэгэхээр энийг нэлээн нарийвчилсан өөр заалтууд бол байхгүй байна л даа. Миний санаа бол Хэнтий аймгийн Дадал сумд бид бас аялал жуулчлалын зориулалтаар нисэх буудлыг бас шинээр барьж байгуулаад ашиглаад явж байгаа. Аялал жуулчлалын бус цаг хугацаанд бас тодорхой хэмжээнд сургалт, дадлагын үйл ажиллагаа бас явуулах ийм бас бололцоонуудыг бас бид бүхэн бас судалж байгаа.

Тэгэхээр энэ төрлийн үйл ажиллагааг бас зохицуулсан зохицуулалт энэ хууль дээр бас байна уу? Цаашдаа бас энэ орон нутагт байгаа нисэх буудлуудын үйл ажиллагааг олон төрлийн хэлбэрээр бас зохион байгуулах ийм санаа, зорилгууд бас байна. Тэгэхээр энэтэй бас уялдаж байгаа зүйлүүд байна уу? Энийг бас сайдын хувьд бас та анхааралдаа авч ажиллаач гэдэг энэ саналыг бас дэвшүүлж байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? Дэд сайд хариулах уу? Баасандамба Дэд сайд хариулъя. 4 дүгээр микрофон.

Д.Баасандамба: Асуултад хариулъя. Орон нутгийн нисэх буудлуудыг ашиглах асуудал бол Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах нэгдсэн журам, олон улсын нисэхийн дүрмээр зохицуулагддаг. Орон нутгийн нисэх буудлыг улсын агаарын хөлөгт ашиглах асуудал маань энэ өөрөө Улсын болон цэргийн дайчилгааны хууль тогтоомжоор тусгайлан зохицуулагддаг.

Орон нутгийн нисэх буудал аэродромыг ашигласан нөхцөлд бид нар Монгол Улсад хүргэж байгаа агаарын нэгдсэн навигацийн дүрэм журмаараа нисэх буух цаг, минутаараа зохицуулагддаг ийм журмын зохицуулалттай асуудал.

Орон нутагт байгуулагдах нисэх буудлуудыг өөрөөр хэлбэл орон нутгийн болон хувийн хэвшлийн буудлуудыг бол бид нар улсын нисэхэд шаардлагатай үед ашиг зохицуулалтаар гэрээ байгуулах, бүртгэлжүүлэх тийм зохицуулалттай. Энэ удаа хууль бол ерөөсөө Зэвсэгт хүчин, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар цаашдаа бий болгох ёстой цагдаагийн эрэн хайх агаарын ангиудад зориулсан ийм нислэгийн зохицуулалттай холбоотой хууль учраас хувийн өмчийн нислэгийн компаниуд, Иргэний нисэхийн ерөнхий газар, “Хүннү эйр”, Монголын иргэний агаарын тээвэр, “Alpha Aurora” зэрэг хувийн нисэхийн байгууллагуудын үйл ажиллагаатай бол зөвхөн иргэний нисэх дээр бүр бүрдэж байгаа олон улсын нисэхийн дүрмийн дагуу агаарын зайг ашиглахтай холбоотой нэгдсэн удирдлага, мэдээллийн зохицуулалтаараа явагдана гэж хэлэх гэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Өнгөрсөн жил Монгол Улсад нисэх хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиосон. Тэгээд Монгол Улсын хувьд дэлхийн олон оронтой иргэний нисэхийн байгууллагаас гэхэд нислэг үйлддэг дэлхийн том хотуудтай нислэг үйлддэг ийм бас үүх түүхийг танай хамт олон ч гэсэндээ бас бичилцсэн. Би хэд хэдэн асуултыг асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, агаарын энэ хөлгийн, агаарын нислэгийн хөдөлгөөний удирдлагыг хэн хариуцах вэ? Энэ нь хуулийн дагуу л тодорхойгүй харагдаад байна. Одоогоор бол Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа энэ байгууллагаас зохион байгуулдаг. Тэгэхээр үргэлжлүүлээд танайх тусдаа ийм хөдөлгөөний албатай болно гэсэн үг үү, эс үгүй бол энэ хөдөлгөөний албанаас үргэлжлүүлэн хийнэ гэсэн үг үү? Ер нь Онцгой байдал, Хил хамгаалах гээд олон нисэхтэй болж байгаа. Монгол Улсын хувьд ч гэсэндээ хэрэгцээ шаардлага, техник тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага бол их байгаа. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албыг техник тоног төхөөрөмж сайжруулах дээр олон улсын жишигт нэмэгдүүлэх дээр та бүхэн ер нь хамтарч ажилладаг уу, дэмжлэг үзүүлдэг үү?

Дээрээс нь Дайчилгааны тухай хуулийн 10.2-оор нисэх онгоцыг өмчийн хэлбэр үл харгалзан бас дайчлах бас эрх бас байгаа байх. Ийм тохиолдолд бас энэ хуулийн зарим зохицуулалтууд орж явах уу? Ийм тохиолдолд бас яах ёстой вэ гэдэг. Одоо яагаад гэвэл хувийн хэвшил ч гэсэндээ, хувь хүн ч гэсэн, компаниуд ч гэсэндээ маш их онгоцтой болсон. Төрд байхгүй гоё гоё нисдэг тэрэгнүүдийг хувийн хэвшил тэр тусмаа уул уурхайн компаниуд бол авдаг болсон байна лээ. Тэгэхээр ийм тохиолдолд дайчилгааны хувьд бас яах ёстой вэ гэдэг талаар та бүхэн мэдээлэл өгч, эдгээр байгууллагуудтай бас хамтран ажилладаг уу гэдэг ийм хэдэн асуултыг асуух гэсэн юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Хэн хариулах вэ? Дэслэгч, генерал Ганбямба 4 дүгээр микрофон.

С.Ганбямба: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Агаарын удирдлагын хөдөлгөөний асуудлыг бол бид Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтын ажиллагааны журам байдаг юм. Хамтран ажиллах журам. Тэр журмын хүрээнд энэ удирдлага, зохицуулалтыг хийгээд явж байгаа.

Дайчилгааны тухайд бол тайван цагт Дайчилгааны тухай хуульд заасны дагуу нисэх хэрэгсэл, хэрэгслийг оногдуулан бүртгэсэн байдаг. Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад. Тэгээд үүнийхээ дагуу дайчилгаа зохион байгуулах үед дайчлан татна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу дайчлан татаад ажиллагаанд ашигласны дараагаар бол нөхөн олговор олгох тийм зохицуулалттай, тийм журамтай байгаа. Хариулж дууслаа.

С.Бямбацогт: Гишүүд хуулийн асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт

харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Гомбын Ганбаатар гишүүн?

Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулах ёстой санал хураалтыг 13 цагаас гэж зарласан байгаа. 13 цагт гишүүд санал хураалтдаа хариуцлагатай оролцоно уу. Бэлэн байгаарай. Дараагийн асуудалдаа орёё.

11.39 цаг

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Сая хуралдаанд оролцсон ажлын хэсэгт баярлалаа Батлан хамгаалах яам, Жанжин штабын удирдлагуудад баярлалаа.

Сайнзориг гишүүнийг хууль санаачлагч илтгэлийг танилцуулна уу хэмээн урьж байна индэрт.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилгыг тэргүүлэх чиглэл болгон тус хөтөлбөрийн 3.1.2.4-д төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийг багаар удирдуулж нээлттэй хувьцаат компани/ХК/ болон үр ашиг баялгийг тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ гэж.

Мөн хөтөлбөрийн 4.1.4.2-т төрийн болон орон нутгийн өмчит өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 21 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 6.4-д төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна гэж мөн заажээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2026 оны тоон мэдээллээс үзэхэд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 100 гаруй байгаагаас төрийн өмчит үйлдвэрийн газар 18 байна. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үүнээс 5 дахин их байгааг бас онцлон тэмдэглэе.

Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хангах нь чухал бөгөөд дээрх зарчим нь төрийн өмчийн үйлдвэрийн газарт үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна.

Нөгөөтээгүүр Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна гэж заасан нь мөн төрийн тодорхой компаниуд ч хамааралтай, тодорхой түр үйл ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд ч мөн хамааралтай зохицуулалт байна.

Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтуудад хийдэл үүсэх шалтгаан болж улмаар хуулийн хэрэгжилт янз бүрээр хэрэгжих, хууль тэгш бус үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу аж ахуйн шинжтэй үйл ажиллагааг явуулдаг аж ахуйн тооцоотой болон улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээдүүд байгуулагдаж үйл ажиллагаа явуулах болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй болох, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутагт үзэмжээрээ аж ахуй эрх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх буюу цаашид Иргэний хууль болон олон улсын жишигт нийцүүлэн компанийн хэлбэр болон бусад хуульд заасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Төсөлд эдгээр үйлдвэрийн газрыг ашгийн төлөө хуулийн этгээд компани хэлбэрт оруулж цаашид үйлдвэрийн газрын статустай хуулийн этгээдийг шинээр байгуулахгүй байхад чиглэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компани хариуцлага, эрх, үүргийн хувьд улс төрийн нөлөөллөөс ангид байх, хараат бус байх, үр ашигтай байх, хараат бус хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх, компани, төр болон орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчмыг хуульчлан бэхжүүлэх зүй ёсны шаардлага ч бид нарт байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх шаардлагын үүднээс 91 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Бүгд найрамдах Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төслийг хүчингүй болгох болон дагаж мөрдөх журмын тухай хуулийг дагалдуулан боловсруулж хэлэлцүүлж байна.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлал буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 8 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс уг хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үр ашигтай ажил, үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, олон улсын менежментийн багаар удирдуулах, нээлттэй хувьцаат компани болгох, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно гэж үзжээ.

Мөн хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлснээр хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үзэмжээр аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох сөрөг үр дагаврыг бууруулна гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат төрийн өмчит компанийн ажилчдад хувьцааных нь тодорхой хувийг олгодог гаднын туршлагыг судалж, энэ хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Мөнхсоёл нар тус хуулийн төслийг Нийтийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслүүдтэй давхардуулж хэлэлцэх шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статус ямар компаниуд багтаж байгаа талаар болон “Эрдэнэт” үйлдвэрийн хувь эзэмшлийн асуудал дээр өөрчлөн байгуулах процессыг ямар арга хэлбэрээр хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай компанийн хэлбэр өөрчлөгдөхөд аль хуулиар зохицуулах, үүнд шаардагдах зардлын тооцооллын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар гишүүд хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар байр сууриа илэрхийлэх үед Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал төрийн өмчит үйлдвэрийн газар гэсэн статуст төрийн өмчийн их, дээд сургуулиуд болон уул уурхайн компаниуд хамт багтаж байгаа ойлгомжгүй асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа энэ хуулийн төслийн төслийг Нийтийн өмчийн хууль шинэчилсэн найруулгын төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслүүдтэй нэгтгэн хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн хамт өргөн

мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн шатад байгаа БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төсөлтэй давхцаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Нийтийн өмчийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн томоохон төслүүдийг Улсын Их Хурал батлах, хэрэгжүүлэхэд тодорхой цаг хугацаа шаардлагатай тул эдгээр батлан үүсээд байгаа асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, нээлттэй хувьцаа эзэмшилтэй болгох механизмыг хуульд нарийвчилж тусгах шаардлагатай талаар тус тус саналаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мандхай, гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын санаачилсан 8 гишүүн Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга.

Ажлын хэсгийн гишүүд Их Хурлын чуулганы хуралдаанд бас үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй. Худлаа мэдээлэл өгөхийг хориглоно. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бас хүндэтгэлтэй хандахыг ийм дэгтэй шүү гэдгийг бас сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Болдын Уянга гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Ер нь бол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг энэ зохицуулалтыг сайжруулах, шинэчилсэн найруулгын хэмжээнд

сайжруулах өөрчлөх зайлшгүй шаардлага бол байгаа. Тэгээд Сайнзориг гишүүн яг энийг бас хүлээлгүйгээр энэ бас нэлээн эрт өргөн баригдсан юм шиг байна. Бэлдсэн юм шиг байна. Тэгээд хүлээлгүйгээр тодорхой зарим шийдлүүдийг нь бас хийгээд явъя гэдэг агуулгаар энэ хуулийн төслийг өргөн барьсан юм шиг байна.

Ер нь бол төрийн болон энэ яах вэ хуулийн агуулгаар харахад нэг нэр сольж байгаа юм шиг л харагдаад байгаа л ТӨҮГ гээд. ТӨҮГ нь бол яг компани ч биш ийм тодорхой зохицуулалт нь засаглалын хувьд ч ойлгомжгүй иймэрхүү бүтэц байгаа. Энийг өөрчлөх нь зөв байх. Агуулгын хувьд бол энэ цогцоор нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн энэ ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгэхээр энэнтэй уул нь уялдуулаад энэ өөрчлөлтүүдээ бас оруулаад явчихвал гэсэн тийм санаа байгаад байгаа юм. Тэгэхээр энийг Сайнзориг гишүүнээс бас энэ хуультай яаж уялдах юм, энэ хуулийн цаг хугацаануудын хоорондын уялдаа энэ түрүүлж энэ хууль батлагдсанаар ямар ач холбогдолтой вэ гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт нь болохоор энэ хуулийг дагалдуулж 1 хууль өргөн барьсан байгаа. Цэнгүүн гишүүний өргөн барьсан төсөлтэй яг адилхан агуулгат БЭТ томилох энэ Засгийн газарт, Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох тооцсугай гээд.

Тэгэхээр агуулгын хувьд харахаар өргөн барьсан хуультай бараг шууд уялдаагүй хуулийг дагалдуулж байгаа юм шиг ингэж харагдаад байна. Тэгэхээр энэ хуулийн өргөн барьсан хууль бол төрийн өмчит үйлдвэрийн газрыг энэ нэртэй холбоотой зохицуулалт голдуу байгаа. Тэгэхээр дагалдуулж өргөн барьж байгаа хууль нь болохоор БЭТ томилох, бүрэн эрхт төлөөлөгч томилохтой холбоотой ийм асуудал байгаад байна. Тэгэхээр энэ өргөн барьсан хуультай дагаж байгаа хууль нь яаж уялдаж байгаа талаар мэдээлэл өгөөч гэж ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн хууль санаачлагч хариулъя.

П.Сайнзориг: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сүүлийнхээс нь хариулъя. Ер нь та үзэл баримтлалыг харвал би нөгөө хуулийн этгээдийн засаглал талаасаа гажуудал үүсгээд байгаа, буруу жишиг тогтоогоод байгаа энэ хуулиудыг л засаж сайжруулъя гэдэг агуулгаар энэ удаагийн хуулийн төслийг өөрчлөлт оруулж байгаа юм.

Өнөөдөр Иргэний хууль 2002 онд батлагдсан. Үүн дээр бол ашгийн төлөө хуулийн этгээдийг компани, нөхөрлөл хэлбэрээр байгуулна. Энэ нь төрд ч гэсэн хамаатай шүү гэдэг зүйлийг маш тодорхой заагаад өгчхөөд байхад социалист эрх зүйн тогтолцооноос үлдсэн төрийн өмчит үйлдвэрийн газар нэртэй яг таны ярьж байгаа шиг засаглал нь ойлгомжгүй. Өнөөдөр компани хэлбэрээ дор хаяж байгуулахад их хэмжээний хэлцэл байгуулахыг ТУЗ-өөсөө зөвшөөрөл авч байж шийддэг байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр төрийн өмчит үйлдвэрийн газар дээр энэ жишээ нь зарчим үйлчлэх юм уу үгүй юү гэдэг нь маш ойлгомжгүй байна. Эргээд энэ ТУЗ-ийн хяналтууд бас хуулийн этгээдийн засаглал дээр орж ирдэг. Энэ хяналтууд нь ойлгомжгүй байна. Бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, энэний явцыг дүгнэж тодотгол хийх асуудал бас ингээд тодорхойгүй байх жишээний. Үүний цаана

магадгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалаасаа шалтгаалаад өмч үнэгүйдэх, эрсдэл үүрэх, алдагдал хүлээх ч гэдэг юм уу ер нь зүгээр цаашдаа бид нарын бас томоохон бодлогын бичиг баримтууд зөрчөөд байгаа олон нийтийн болох үйл ажиллагаа дээр бас ингээд цаг хугацаа л алдах ийм зүйлүүд байгаа юм.

Хоёрдугаарт, БЭТ-ийн хууль бол үндсэндээ бас нэг засаглалыг гажуудуулж байгаа нэг хууль л байсан 91 оны хууль. Би бол хувьдаа бас тэгж боддог. Тийм учраас уг асуудлыг энэ онц байдлын хуулиараа явах ёстой. Ер нь зүгээр цаашдаа төлбөр, санхүүгийн хувьд бас хүндрэлтэй болж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компаниуд төрийн болон орон нутгийн өмчит компаниуд дээр бол төлбөрийн чадваргүйдлийн буюу Дампуурлын хуулиараа л явах ёстой байхгүй юу. Дампуурлын хуулиараа тэр гүйцэтгэх захирлыг чөлөөлөөд эргээд шүүхийн оролцоотой байж болно. Эсвэл төрийн өмчит компани дээр арай урьдчилсан шийдвэрлэх горимоороо юу гэдэг юм уу хувьцаа эзэмшигчийг хэрэгжүүлэх байдлаараа ингээд захирлыг солиод ч гэдэг юм уу, бас тодорхой компанийг сэргээх, дахин төлөвлөх тийм үйл ажиллагаануудыг бас авч хэрэгжүүлэх боломж нь бол байгаад байгаа юм.

Тэгээд энэ ингээд яг бизнесийн зарчмаар явахгүй бол энэ олон зүйлүүд уялдаагүй үүний цаана улс төрөөс хараат бус байх ёстой ТӨК дээр хараат бус, хараат улс төрийн томилгоонууд явах эрсдэлүүдийг зөвхөн ганц захиралд үүрүүлэх ийм том нөхцөл байдал руу орох ч гэдэг юм уу ийм зүйлүүд явчхаад байгаа юм. Энийг л цаг хугацааны хувьд ч гэсэн 1 өдөр алдахгүйгээр засъя л гэдэг үүднээс байгаа.

Засгийн газраас өргөн барьсан төрийн өмчийн 2 хууль багц гэх юм уу тэр 2 хуулийг бол Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад явж байгаа. Зүгээр нэгтгээд хэл хэлэлцэж болох боловч зүгээр хэрэгжих цаг хугацааны хувьд өөр байж болох юм. л гэж бид нар үзэж байгаа. Мэдээж өргөн барьсан тэр хуулиудыг баталлаа гэхэд маргааш хэрэгжүүлэх боломжгүй буюу хэрэгжилтийг хангахад дор хаяж л хагас жилийн бэлтгэл ажил шаардлагатай болно. Тэгэхээр энэ хүрээндээ л энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд өөрчлөлт оруулах хуулийг цаг алдалгүй баталж, ердийн журмаар хэрэгжүүлээд явъя. Энэ хуулийн этгээдийн засаглалыг алдагдуулж байгаа энэ заалтуудыг.../минут дуусав./

С.Бямбацогт Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би танин мэдэхүйн шинжтэй бас зүгээр асуулт байгаа. Жишээлбэл үзэл баримтлал энэ хууль тогтоомжид дагалдуулж өргөн барьж байгаа хуулийн төслүүд дээр энэ яг Сайнаа гишүүн хариулах юм болов уу, өөр Их Хурлын Тамгын газраас ч юм уу дагалдуулж өргөн барьж байгаа хууль нэг үзэл баримтлалын хүрээнд нэг нь өргөн барьж байгаа хууль нь болоод дагалдах яг нэг ижил, би болохоор энэ БЭТ томилох энэ хууль болон энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 2 хууль маань нэг үзэл баримтлалын хүрээнд ижил агуулгатай ийм хуулиуд байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт нь нэгийг нь өргөн бариад нөгөөдхийг нь дагалдуулах иймэрхүү байдлаар ер нь явдаг юм бол би бас цаашаа бас хууль өргөн барихдаа энийг бас ойлгож тодруулъя гэж бодоод байгаа юм. Юм харахаар ингээд яг ийм дагалдуулж байгаа юм дагалдаж байгаа биш охин нь биш, бараг ингээд хүүхэд нь биш ийм яг ижилхэн ингээд ийм аав, ээжүүд зэрэг

яваад байхгүй байхгүй юу. Тэгэхээр энийг тайлбарлаж өгөөч. Юуг яг дагалдуулж болдог юм ингээд юуг дагалдуулж болдог юм?

С.Бямбацогт: БНМАУ-ын БЭТ томилох тухай хуулийг хүчингүй болгох хуулийг бол бие даасан хуулийн нэмэлт, өөрчлөлт байдлаар Цэнгүүн гишүүн өргөн барьсан. Сайнзориг гишүүн болохоор Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийг дагалдуулж өргөн барьсан. Ер нь бол аливаа хууль тогтоомжийг нэмэлт, өөрчлөлтүүд оруулахдаа бол нэг хуульд өөрчлөлт оруулахаар хууль санаачлагчтай хэдэн ч гишүүн хууль санаачлагч санаачилж болно. Энийг бол хэлэлцэх эсэхийг нь шийдэхдээ ингээд тус тусад нь хэлэлцээд, хэлэлцэх эсэх нь шийдэгдээд дэмжигдээд явсан тохиолдолд анхны хэлэлцүүлгийн үед нэгтгээд явдаг ийм дэгтэй. Тэр Татварын хуульд өөрчлөлт оруулна гээд олон гишүүн санаачилсан бол бүгдийг нь хэлэлцэхийг шийдчихээд нэгтгээд явчих.

Мөн бас дагалдсан болон үндсэн болгож өргөн барьсан ижил хууль учраас үүнийг хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа нэгтгээд явах ийм л зохицуулалтаар бас хуулийг хэлэлцүүлж явж байгаа. Тийм болохоор та бүхэн бас манай Энхтүвшин гишүүн цаашдаа хууль санаачлахдаа бол аль ч хууль дээр хууль санаачлагчийн бүрэн эрхийн хүрээндээ нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулга, анхдагч хуулийн төсөл санаачилж болно. Ижил төстэй үзэл баримтлалтай болон нэг хууль дээр байх юм бол саяынхаар явна л гээд ойлгочихъё. Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Энхтүвшин гишүүн бас зөв асуулт асуугаад байгаа юм. Нөгөө гуя дагуулж хүзүү гэдэг шиг юмнууд бас байчих бий гэдэг болгоомжлолын хүрээнд зүгээр асууж байна гэж ойлгож байгаа. Би бол энэ хууль дээрээ бол итгэлтэй байгаа.

Өөрөөр хэлэх юм бол яг хуулийн этгээдийн засаглалыг алдагдуулж байгаа асуудал бас 2 ийм зүйл байна гэдгийг л би тодотгож уялдаатайгаар нэгмөсөн засъя гэдэг уялдаатайгаар оруулж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хуулийн этгээдийн Иргэний хуульд байхгүй төрөл, хэлбэрээр хуулийн этгээдийг байгуулаад байна.

Дээрээс нь Онц байдал юм уу, Дампуурлын хуулиар зохицуулах ёстой тэр БЭТ юм уу эсвэл тухайн компанийн засаглал, эдийн засгийн нөхцөл, эдийн засгийн үзүүлэлттэй холбоотойгоор хүндрэл үүслээ гэхэд тодорхой арга хэмжээ авах хүрээнд зохицуулалтуудыг бас 91 оны хуулиар зохицуулаад байгаа нь буруу. Ингээд үндсэн санаа нь энэ хуулийн этгээдийг зөв засаглалтай болгоё гэсэн л, нээлттэй болгоё, хариуцлагатай болгоё гэсэн хүрээнд уялдуулж орж ирж байгаа гэдгийг та бас ойлгоод би бас энэнтэй хамааралтай учраас дагалд, нэг нь нэгийгээ дагаж орж ирж байгаа гэдэг зүйлийг хэлэх нь зөв байх. Хууль тогтоомжийн хуулиар хүчингүй.../минут дуусав./

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Би яг бас яг эргэлзээ гарсангүй. Яг миний бодлоор бол үзэл баримтлал адилхан байсан ч гэсэн энэ 2 тусдаа хууль өргөн барихаар юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд бүгд юу БЭТ-ийг нь тусад нь өргөн бариад

энэ Төрийн болон орон нутгийн өмчийг бас тусад нь өргөн барихаар, төрийн болон орон нутаг энэ ТӨҮГ гэдгийг өөрчилснөөр тэр БЭТ-ийг өөрчлөх үндэслэл жишээлбэл би Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсэг дээр ажиллаж байгаа. Тэгэхэд Зөвшөөрлийн хууль дээр өөрчлөлт орсонтой уялдуулж л бусад хуулиуд өөрчлөлт орж байгаа болохоос биш тэгээд яг ийм агуулгын хувьд бол зөвшөөрлийн харилцааг өөрчлөхийн тулд гээд тусдаа дахиж өөр хууль хөндөхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт одоо энэ сая өргөн барьж байгаа хуулийн дагалдаж байгааг нь болохоор зэрэг өргөн барих ёстой юм шиг л надаа харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг тэр эргэлзээ саяын хариултуудаас бас авч, гаргаж чадсангүй л дээ. Дахиад тодруулж өгөөч.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Ийм л байгаа юм Энхтүвшин гишүүн ээ ер нь бол төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг асуудлыг Иргэний хуулийнхаа концепцтой нийцүүлээд компани хэлбэрээр цаашдаа явъя гэж байгаа бол энэ компани хэлбэрт бас учраад байгаа яг энэ засаглалыг алдуулж байгаа хуулийг бас хамт засах ёстой байхгүй ю. Ерөөсөө л энэ. Энэ компани дээр тодорхой хэмжээний эдийн засгийн үзүүлэлт муу байна энийг бас асуудал байна гэвэл тухайн нюансыг кэйс болгоноор авч үзээд нэг бол Онц байдлын хуулиар тогтоох ёстой. Нэг бол Дампуурлын хуулиар шийдэх ёстой. Гэтэл гуравдагч хууль нь бас гарч ирээд байгаа.

Тэгэхээр энэ 2 чинь өөрөө уялдаатай асуудал учраас нэг талдаа хуулийн тоондоо бас олон хууль өргөн барих гэдэг шаардлагагүй шүү дээ. Уялдаатай асуудлыг нэг цогц байдлаар хэлэлцүүлээд шийдвэрээ гаргуулаад явъя гэсэн байдлаар уялдаж орж ирж байгаа. Тэрнээс биш огтоосоо ингээд бас 2 өөр асуудал бий гэж би үзэхгүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол компани болсонтой холбоотойгоор компанийн асуудлыг тодорхой зохицуулчихсан төрийн болон орон нутгийн өмч болон компанийн хуулиас давж дахиад компанийн засаглалыг эвдээд байгааг энэтэйгээ цэгцэлье л гэсэн зарчмыг хадгалж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Болдын Жавхлан, Далайн Батбаяр, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай хойд бүсээс сонгогдсон гишүүд, төвийн бүсээс сонгогдсон гишүүдийн урилгаар бас оролцож байгаа юм байна. Гишүүд маань энд сууж байна. Тэгээд та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Идэвхтэй сууж байна шүү манай гишүүд. Цогтбаатар гишүүн, Далайн Батбаяр гишүүнийг онцолж ажлаа сайн хийж байгаа шүү гэж байна шүү.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Энэ хуулийн төсөл, чиглэл нь бол ерөнхийдөө зөв зүг рүүгээ явж байгаа юм. Гэхдээ бас дутуу асуудлууд байна. Иргэний Зориг Ногоон намын даргын хувьд хэлэхэд бид нар бол бизнесийн салбар буюу ашгийн салбарт Засгийн газар иргэдтэйгээ өрсөлдөх ёсгүй гэж үздэг нам. Засгийн газар иргэдтэйгээ ашиг хуваалцахын төлөө зах зээлийг эзэлж ингээд бизнесийн үйл

ажиллагаа явуулах нь буруу гэж үздэг нам. Яах вэ энэ хуулийг би бол буруутгаж хэлэхгүй. Гэхдээ бол засах ёстой зүйл байгаа. Замын дунд дугуй хагарчихвал дугуйгаа хийлгээд явж байна гэдэгтэй л адилхан хийлгээд нөхөөд явж байгаа л ийм л байлаа.

Тийм болохоор бас Их Хурлын даргад энэ ажлын хэсгүүд дээр бас зарим зүйл дээр нь оролцох хэрэгтэй юм байна. Нөгөө засагт байсан учраас ажлын хэсэгт орж чадаагүй асуудлууд байгаад байдаг. Тэгээд хуулиас асуух зүйл байна. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг Төрийн өмчит компани болгох нь зөвхөн нэр томъёоны өөрчлөлт үү? Нөгөө засаглал, хариуцлага, ашигт ажиллагаа, өр төлбөр, ноогдол ашиг, ТУЗ-ийн хараат бус байдлыг бодитоор өөрчлөлт өгөх реформ нь хаана байна вэ? Хэрвээ бодит реформ гэж үзэж байгаа бол энэ төрийн өмчит компани болсон байгууллага бүрд заавал мөрдөх шалгуурууд, худалдан авалтын ил тод байдал, өрийн сахилга, хөрөнгийн өгөөж гэх мэтээр ингээд энэ хуульд яагаад тусгаж оруулах чиглэл яваагүй юм бэ гэдэг асуулт байна.

Хэрвээ бид нар энэ төрийн өмчит компанийг өөрчлөх биш цаашдаа ингээд явах юм бол Их Хурал, Засгийн газар болон олон нийтэд тайлагнадаг болгох хэлбэр рүү нь хөрөнгийн өгөөж, ашиг, алдагдал, өр төлбөр, худалдан авалт, ил тод байдал, ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ эд нарыг ингээд жил болгон тайлагнадаг чиглэл рүүгээ явмаар байгаа юм.

Сая яригдаад байгаа 91 оны хууль гээд БНМАУ-д гээд. Энийг өөрчил өөрчлөх нь бол ач холбогдолтой гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ дээрээ бас нэг зүйлийг дагуулж нэмэх шилжилтийн заалтаа нэмэхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Засгийн газарт эрх олгох тухай хуулийн үндсэн дээр гарсан хүчин төгөлдөр шийдвэр байгуулсан гэрээ, шилжүүлсэн хөрөнгө, үүссэн эрх, үүрэг нь энэ хуулиар хүчингүйд тооцогдохгүй гэдэг зүйлийг. Сүүлд ингээд эрх олгосон БЭТ-үүдийн хийгдсэн гэрээ, гаргасан шийдвэрүүд энэ хуулийг алга болгосноор тэд нарын гаргасан шийдвэрүүд ард нь нөгөө үр дагавар үлдэх, тэрийг хянах тогтолцоог байхгүй болгоод хуулиар хаагаад хаячих вий гэдэг ийм болгоомжлол бас давхар төрж байгаа юм. Баахан БЭТ-үүд томилчихсон баахан юм тэд нараараа хийлгэгчигхсэн Засгийн газар, дараа нь энэ хууль хүчингүй болсон гээд тэд нарынхаа үүрэг, хариуцлагынхаа асуудлуудыг ард нь зоож өгөхгүйгээр ингээд өргөн баригдаад байгаа нь бас хар.../минут дуусав./

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Батбаатар дарга 3 бас чухал асуулт асуулаа. Ер нь төр өөрөө энэ төсвийн бодлого болон яг төрийн болон орон нутгийн өмчит компанийн байгуулах замаараа ер нь бол эдийн засаг дахь оролцоо бол бас аймаар том тоонд хүрчхээд байгаа тоон үзүүлэлт талаасаа. Тэгэхээр энийг бас цаашдаа хумих гэдэг юм уу шаардлагатайгаас бусад хувийн хэвшил хийж болох энэ үйл ажиллагаа дээр төр орон нутаг оролцохгүй байх энэ асуудал бол чухал байгаа. Үүн дээр нэгдүгээрт бол энэ төрд байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг олон нийтийн хяналтад оруулах буюу биржээр бас тодорхой хувьцааг нь олон нийтэд санал болгох ёстой. Энэ ажиллагаанууд ер нь бас хангалтгүй хийгдэж байгаа. Сая банкны салбар явж байгаа боловч энэ Банкны хууль тогтоомжийг дагаж оруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хууль дээр тухайн төрийн өмчит компанийн

ерөөсөө 5 хувиас дээш хувьцааг 1 этгээд худалдаж авах боломжгүй болгосноороо энэ арилжаа үндсэндээ бас үнэ цэнгүй болчихоод байгаа юм.

Ер нь 5 хувийг аваад яг хяналтыг ч гэдэг юм уу тодорхой шийдвэр, үйл ажиллагаанд нь оролцож чадахгүй байж бол хувийн хэвшил бол хөрөнгө оруулна гэдэг бол худлаа байхгүй юу. Тэгээд ийм яах вэ банкны салбартай тохирч байж болно. Бусад ингээд юмнуудыг ингээд хаагаад хаячхаж байгаа юм. Тэгэхээр бид хэдийн нөгөө хууль батлахдаа үр дагавруудыг тооцдоггүй маш олон зүйлүүдийн нэг л жишээ нь энэ л дээ.

Дээрээс нь энэ төрийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудыг өнөөдөр байгуулах шалгуур үзүүлэлт болон энэнтэй холбоотой зүйлүүд нь ойлгомжгүй учраас өнөөдөр надад байгаа мэдээллээр 18 ширхэг төрийн өмчит үйлдвэрийн газар байна. 105 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байна. Тэгэхээр энэ асуудал чинь ингээд үзэмжээрээ дураараа яваад байгааг хумья. Ер нь цаашдаа компанийн засаглалд оруулъя. Компани гэдэг бол яг таны хэлж байгаа тэр хяналт, хариуцлага, төлөвлөлт, үр дүнг шаардаад эхэлнэ.

Өөрөөр хэлэх юм бол энэ нэр томъёо солих гээд байгаадаа биш. Энэ төр өөрөө үзэмжээрээ аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлээд байгаа төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулах эрх зүйн зохицуулалтыг энэ социалист эрх зүйн тогтолцооноос үлдсэн энийг халж байна гэдэг нь яг таны хэлж байгаа үзэл санаа буюу бизнесийн орчин дээрх төр бас зохистой хэмжээнд бизнес эрхлэх болон зарчмыг тогтоохоосоо гадна яг төрийн өмчийг үнэгүйдүүлэхгүй байх, энэ компанийн хяналт, хариуцлага энэ нь өөрөө төсвийн бодлоготойгоо уялдаж, ноогдол ашгийн бодлого нь төсвийн бодлоготойгоо уялдах зарчим тогтох ч гэдэг юм уу ийм олон эерэг үр дагаврууд цаашдаа гарна.

Дээрээс нь төрийн өмч компаниудыг яг бодитойгоор олон нийтийн болох, олон нийтийн хяналтад оруулах буюу тодорхой багц хувьцааг бас биржээр арилах нөхцөл байдал руу ч гэсэн алхам урагшилна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр ийм ач холбогдол байна.

Хоёрдугаарт, 91 оны хуулиар гарсан шийдвэрүүд бол дагаж мөрдөх журмын хуультай эсэхээсээ үл хамаараад тухайн цаг үедээ гарсан хууль ёсны шийдвэр учраас хүчин төгөлдөр хэвээрээ байна. Ер нь яах вэ 91 оны хуулийн асуудал бол цаашдаа тэр Онц байдлын хууль дээрээ тодотгодог юм уу эсвэл Дампуурлын хууль дээрээ л илүү бид хэд бас тодруулж өгөх, тэгээд энэ Засгийн газраас өргөн барьчихсан байж байгаа төрийн.../минут дуусав./

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Бид нар энэ төрийн гэдэг нэртэй уг нь Засгийн газрын өмчит л дөө. Төр гэдэг ойлголт дотор их олон зүйл ард түмний иргэд, сонгогчдын татварын мөнгө далд ороод идэж уудаг тийм зэвсэг болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ компани болгоод хэн эзнийх нь эрхийг хэрэгжүүлэх юм төрийн өмчит компани болсны дараа тээ? Өмчлөгчийн эрх, нэг бол салбарын яам нь бодлого барих юм уу, нэг бол нөгөө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эсвэл Засгийн газар шууд шийдвэр гаргах юм уу? Тэгээд энэ чинь өмчлөгч, зохицуулагч, захиалагч, хянагч гэсэн 4 үүрэг нь нэг эзэн дээр бий болчихоод байгаа. Энэ

үүргүүдээ бас заагламаар байгаа юм. ТУЗ-ийн хараат бус байдалгүй бол компанийн хэлбэр нь өөрөө үр дүнгүй болчихно. Ашигтай компанид л үйлчлэх үү, алдагдалтайд нь төсвийг нь хариуцаад ингээд яваад байх уу? Нийгмийн шинжтэй үүргүүдийг нь яаж санхүүжүүлэх юм? КОВИД-ын үеэр баахан зүйлийг төлж байсан.../минут дуусав./

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Эзэн гэдэг бол ерөнхийдөө өмчийн эзэн бол Улсын Их Хурал ард түмний өмнөөс энэ эрхийг бол Улсын Их Хурал хэрэгжүүлж байгаа. Энэ эрхийг тодорхой түвшинд шат шатанд нь төрийн байгууллагуудад шилжүүлж өгч байгаа. Идэвхтэйгээр Улсын Их Хурлын нэрийн өмнөөс бол Засгийн газар, түүний бүтцийн байгууллагууд энэ төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа. Энэнтэйгээ холбоотойгоор бас хангалттай, хангалтгүй асуудлууд бол байгаа. Үндсэндээ 6, 7 компаниас бусдууд нь бол бас дөнгөн данган эргээд нийт төрийн өмчит компанийн бараг 40 орчим хувь нь алдагдалтай ажиллаж байгаа гэсэн тоо статик үзүүлэлт байж байгаа. Энийг зайлшгүй засах энэ асуудлууд байна.

Мэдээж энэ төрийн өмчит компанийн менежмент талаасаа бол төвлөрүүлж удирдах буюу энэ уул уурхайн компаниудыг бол төвлөрүүлээд “Эрдэнэс Монгол” удирдаж байна. Тарифын зохицуулалттай буюу зах зээл дээр нь одоохондоо бас хувийн хэвшил оролцох боломжгүй. Татаас гэдэг юм уу тодорхой түвшинд явж байгаа компаниуд бас салбарын яамнууд бас идэвхтэй оролцоотой байгаа нь нууц биш. Энэ.../минут дуусав./

С.Бямбацогт: Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Заримаас хариултуудаа аваад байна. Тэгэхдээ энэ төрийн өмчит компаниудын зарим нь зах зээлийн ашиг бас нөгөө нийтийн үйлчилгээ, стратегийн чиг үүргүүдийг гүйцэтгээд байдаг шүү дээ. Тэгээд энэ ялгаагаа хууль тодорхой байлгахгүй бол нэг бол ашигтай ажил гэсэн шаардлагыг нийгмийн үүрэг гүйцэтгэх гэсэн энэ даалгавар 2 бол хоорондоо зөрчилдөнө. Тийм болохоор энэ төрийн даалгавар авбал зардлыг нь хэн нь өгөх юм? Төрийн даалгаврыг төсвөөс ил тод санхүүжүүлэх юм уу эсвэл компанийн алдагдал болгоод нуучих юм уу гэдэг асуудлыг ч бас хөндөх ёстой болж байгаа юм.

Тэгээд ТУЗ-ийн хараат бус байдал улс төрийн томилгооны хориг, ашигт ажиллагааны шалгуур, өр төлбөрийн асуудлууд, ноогдол ашгийн бодлого болон нийгмийн энэ шинжтэй төрийн даалгаврын санхүүжилтийг энэ хуульд оруулж ирэх шаардлагууд бол зайлшгүй тусаж байна гэж байгаа юм. Компани болгоно гэдэг улсын үйлдвэрээс компани болгоно гэдэг гол зорилго энэ дээр явж байгаа гэж би хараад байгаа юм.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Таны яг зарим хөндөгдөөд байгаа асуудлууд цогц байдлаараа Засгийн газраас өргөн барьсан байгаа Нийтийн өмчийн болон төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн засаглал, бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль дээр шийдэгдэнэ.

Ер нь бол олон улсын байгууллагуудаас өгч байгаа зөвлөмжөөр бол хараат бус гишүүнийг дор хаяж 3 байгаа. Ер нь танай энэ бол бас нөлөөлж чадахгүй байна. Энэ хараат бус гишүүн чинь өөрөө хараат болчихоод байна. Тайлан тавих механизм нь ерөөсөө ойлгомжгүй байна. Ийм учраас дор хаяж 5 гишүүнийг цаашдаа хараат бус гишүүнээр байлгах ёстой. ТУЗ-ийн 9 гишүүн чинь аль нэгийгээ ТУЗ-ийн дарга гэж бас өргөмжилж болохгүй. Бүгд ижил, тэнцүү хариуцлагаа хүлээгээд хуралдаан даргалагч байдлаараа тухайн үедээ шийдээд ингээд компанийн засаглалыг сайжруулах ёстой шүү гэдэг зөвлөмжийг өгч байгаа.

Нийгмийн шинжтэй буюу “Public Service Obligation” дээр ямар ямар компаниуд үлдэх вэ? Энэ ноогдол ашгийн бодлоготойгоо уялдах уу? Тарифын зохицуулалт, төсвөөс өгөх татаасны асуудал гээд энэ асуудлууд бол иж бүрнээрээ Засгийн газраас өргөн барьсан энэ хуулиуд дээр бид нар шийдэхээр ингээд бас Улсын Их Хурал дээр ажлын хэсэг бас л ажиллаад явж байгаа.

С.Бямбацогт: Улсын Их Хуралд Засгийн газраас Нийтийн өмчийн болон нийтийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч компанийн засаглалыг сайжруулах тухай хуулиуд өргөн барьчихсан байгаа. Ажлын хэсэг гарч ажиллаж байгаа манай Үүрийнтуяа гишүүн, Сайнзориг гишүүн, Номинчимэг гишүүд ахалж байгаа. Энэ хуулиудыг яаралтай хэлэлцэж батлах шаардлагатай байгаа. Яг өнөөдөр бас ингээд төрийн өмчит компаниудын засаглал гэдэг асуудал бол маш анхаарал татсан, иргэдийн бас бухимдал бий болгодог болсон. Үнэхээр төрд ямар компаниуд байх ёстой юм, тэр стратегийн ач холбогдол бүхий компаниуд дамжуулах шугамууд, эрчим хүчний дулааны эрчим хүчний станц, дээрээс нь төмөр зам, авто зам гээд эдгээр зайлшгүй төрд байх ёстой юмнуудыг ялгаж ангилах.

Дээрээс нь нийгмийн хариуцлага хүлээдэг зам засвар, ашиглалтын компани, орон нутгийн тохижилт үйлчилгээний компаниуд гээд зайлшгүй ард иргэдийг бас амгалан тайван, аюулгүй, эрүүл орчинд амьдрахад бас хувийн хэвшлийнхэн ордоггүй, сонирхдоггүй ийм ачааг бас төр үүрэх ёстой. Үүнийгээ бас ангилж ялгах, өрсөлдөөн зах зээл дээр хувийн хэвшилд өрсөлдөөд байгаа компаниудаа бас цэгцэлж цөөлөх энэ бодлогууд энэ хуулиудаар явах ёстой. Тэгээд энийгээ бас манай ажлын хэсгийн нэгэнт Их Хуралд өргөн бариад нэлээн удаж байгаа. Тийм болохоор ажлын хэсгийн ахлагч нар бас онцгой анхаарч хурдан бас хэлэлцүүлэгт, анхны хэлэлцүүлэгт оруулж ирэх тал дээр бас анхаараарай гэдгийг энд хэлье.

Улсын Их Хурлын гишүүн Заяабалын урилгаар Завхан аймгийн Алдархаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай Заяабал гишүүн сая энд байсан хаачив? Байна байна энд сууж байна. Бас манай баруун бүсээс сонгогдсон маш идэвхтэй санхүү, эдийн засгийн асуудлаар гол байр сууриа илэрхийлдэг гишүүдийн нэг шүү. Тэгээд бид бүхэн бас хамт тойргоос сонгогдсон. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье.

Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн өмчийн талаарх ер нь 3 хууль ер нь ойролцоодуу ороод ирчихлээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах гээд Сайнзориг гишүүний санаачилсан, Нийтийн өмчийн тухай хууль Засгийн газрын өргөн мэдүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гээд ингээд 3 хууль ойролцоо ороод ирж байгаа юм. Ер нь энэ бол давхардал харагдаад байгаа юм л даа. Тэгэхдээ хамгийн гол ер нь бол засаглалынхаа засаглалыг сайжруулах асуудал ер нь тэр болгон сайн орж ирэхгүй байна. Их тод орж ирэхгүй байна, зохицуулалтын хэлбэрүүд их бага суусан байна гэж ингэж харж байгаа. Тэгээд энэ төрийн өмчийн компанийг төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани болгоно гээд ингээд ерөнхийдөө л ийм жирийн ерөнхий л өөрчлөлтүүд орж ирээд байх шиг харагдаад байна.

Тэгэхлээр засаглалыг л бид нар өөрчлөх ёстой юм төрийн өмчийн компанийн хувьд. Засаглал гэхлээрээ ерөөсөө тэр төрийн өмчийн компанийг хэн удирдах вэ гэдэг л асуудал байхгүй юу. Өнөөдөр төрийн өмчийн компаниудыг улс төрөөс, төрөөс удирдлагыг нь томилж өгч байгаа. Тэр гэдэг бол бодлогоо гаргадаг, хяналтаа хэрэгжүүлдэг, хяналтаа тавьдаг ийм л байх ёстой.

Гэтэл манайх энэ төрөөс удирдлага нь тавигдаад байгаа учраас энэ төрийн өмчийн компаниуд Монголд тэр болгон ашигтай, амжилттай сайн ажиллахгүй байгаад байна. Олон улсын жишгээрээ бол энэ төрийн өмчийн компаниудыг удирддаг тусдаа институц, корпорацууд томилогдоод байгаа. Тэгээд тэд нар бүх тайлангаа ард иргэддээ нээлттэй, ил тод мэдээлж байдаг. Ард иргэд нь тэндээсээ ногдол ашиг хүртэх ийм бололцоотой бид нар болох хэрэгтэй байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад уул уурхайн компаниуд 30 орчим хувийн ашигтай ажиллаж болж байгаа. Манай энэ төрийн өмчит компанийн 122 стратегийн гол ач холбогдолтой компаниуд ихэвчлэн уул уурхайн компаниуд байгаа. Хамгийн өндөр л 10 орчим хувийн л ашигтай байгаа шүү дээ. 1, 2-хон компаниуд байна. Ихэнх нь алдагдалтай ажиллаж байгаа байхгүй юу. Энэ бол удирдлага, бүтэц буюу засаглалыг л өөрчлөх нэн шаардлагатай байгааг л илэрхийлээд байгаа юм.

Тэгэхлээр хэрвээ одоо энэ төрийн өмчийн компанийн энэ хууль ингээд хэлэлцэгдээд ингээд цаашаа яригдах бол засаглалын хувьд л бид нар өөрчлөлт хийх ёстой. Тэгж байж энэ төрийн өмчийн компани маань менежментийг хэн удирдаж авч явах вэ, ямар санхүүгийн институцийг хэрхэн сонгох вэ гэдэг энэ өөрчлөлтийг л бид нар энэ төрийн өмчийн компанийн удирдлага дээр л оруулж ирэх хэрэгтэй байгаа л гэж ингэж хэлээд байгаа юм.

Хэрвээ бид нар энэ ТӨК-ийн засаглалыг сайжруулчих юм бол төрийн өмчийн компаниуд ашигтай ажиллаж эхэлнэ. Ногдол ашиг ард иргэдэд өндөр ноогдож эхэлнэ. Төрийн өмчийн үргүй зардал буурна.../минут дуусав./

С.Бямбацогт: Асуултаа дуусгаад асуучихъя.

Б.Пунсалмаа: Тэр хэмжээгээрээ инфляц бол буурна. Тэгээд эдийн засгийн бүтэц бол зөв болж эхэлж байгаа зах зээлийнхээ бүтцээр зохицуулагдах ийм бололцоо байгаад байгаа юм. Тэгэхлээр бид нар засаглал дээрээ анхаарчих

хэрэгтэй. Тэгээд миний асуух гээд байгаа нь энэ 3 хуулиа бид нар нэгтгээд 1 хууль болгож болохгүй юм уу? Тэгээд энэ дээрээ засаглалынхаа талаар илүү түлхүү оруулж ирэх ямар бололцоо байна гэж асууя.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Пунсалмаа гишүүнтэй санал нэг байна. Угаасаа л бид хэд асуудлыг бол бүгд оношлоод мэдээд байгаа. Тэгэхдээ яг шийдвэр гаргалт гэдэг юм уу их удаан байгаа. Яг үнэндээ хэлэхэд Иргэний хуулийг бид нар олон улсын нийтлэг барьж байгаа жишиг сайн жишгүүд, дээрээс нь Ром-Германы эрх зүйн бүлгийн хууль зүйн системтэй орны хувьд нийцүүлээд 2002 онд баталсан боловч 24 жилийн хугацаанд яг энэ суурь Иргэний хуультай нийцүүлээд аж ахуй яаж эрхэлдэг, бизнес яаж хийдэг энэ Иргэний хуультайгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиасаа эхлээд Гэр бүлийн хууль, бусад Дампуурлын хууль ч байдаг юм уу нийцүүлээгүй явчихсан байхгүй юу. Энэ 24 жил энэ зөрчилдөж явж байгаа гэсэн үг.

Энэ зөрчлийг ашиглаад өнөөдөр компанийн засаглал хэрэгжиж болох энэ институцийгээ алгасангуутаа төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулаад яваад байгааг одоо бол зогсоочихъё л гэдэг байдлаар энэ хуулийн төслийг орж ирж байгаа юм. Яг үнэндээ хэлэхэд төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулаад 1 захирал томилогдоод бүх эрсдэлийг хүлээгээд байгаа байхгүй юу. Тэр хүнд ч хэцүү. Ядаж компанийн захирлаараа байх юм бол ТУЗ-тэй байна, бизнес төлөвлөгөөгөө батлуулна, их хэмжээний хэлцэл байгуулах энэ асуудлууд дээр ТУЗ-өөрөө орж зөвшөөрөл авна ч гэдэг юм уу маш олон зүйлүүд дээр бас хамтын менежментийг хэрэгжүүлэх бололцоо нь энэ жижиг өөрчлөлтөөр ч гэсэн гараад ирж байгаа юм. Тэгэхээр энийг бол яах вэ зүгээр нэгтгээд хэлэлцэж болно гишүүн ээ.

Тэгэхээр нөгөө хуулиуд маань би бас явах ажил бас итгэлтэй байна. Тэгэхдээ цаг хугацааны хувьд яаж бас хойшоо суух бол гэдэг дээр бас байгаа учраас энэ жижиг өөрчлөлтийг ч гэсэн санал болгоод засъя. л гэдэг ийм байдлаар орж ирсэн юм. Тэгээд яах вэ би зөвхөн бид нарын 8 гишүүн нэгтгэе гээд шийдэхгүй байх Засгийн газартайгаа бас ярилцана хууль санаачлагчийн хувьд Тэгээд асуудлуудыг бас хэлэлцэх эсэхээ шийдсэн тохиолдолд бас ярилцаад явъя гэдэг асуудал байгаа.

Энийг дагаад яах вэ зүгээр Цэнгүүн гишүүн дангаар нь өргөн барьчихсан байгаа нэг ...-тай давхцаж байгаа. Ер нь зүгээр хуулийн этгээдийн засаглалыг ингэж өөр байдлаар оруулдаг улс төрийн хараат байдалтай болгож байгаа энэ зүйлүүдийг засъя гэдэг зорилго маань бол бид нар бол адилхан. Тэгээд энэ дээр бол аль түрүүлээд хэлэлцэгдээд явчих юм бол би заавал энийг батлуулах албагүй шүү дээ. Цэнгүүн гишүүнийг дангаараа хэлэлцэгдээд явчих юм бол энэ хууль угаасаа зогсчихно хэлэлцүүлэг нь ийм л учир жанцантай юм байгаа юм.

Ер нь энэ төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хэн удирдах буюу энэ компани болгосноороо яг таны хэлж байгаа зүйл рүү явна. Олон нийтийн болгох тэр бэлтгэл ажлыг хийж, биржээр арилжих. Энэ байдлаар яваад байвал энэ чинь үнэ цэний хувьд ч гэсэн ойлгомжгүй байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр ингээд компанийн хэлбэр рүү орно. Таны хэлж байгаа тэр олон нийтийн болгож

хувьцааг нь иргэд авах баялгаасаа шууд үр өгөөжийг нь хүртэх энэ боломжийг бас тодорхой уул уурхайн компаниуд дээр нээж өгөх ёстой.

Ялангуяа би бол хамгийн боломжит байдал бол Эрдэнэт үйлдвэрийг гэж боддог. Энийг бол зөвхөн гаднын компаниуд ч юм уу тийм зүйлүүдийг нь хязгаарлаад зөвхөн Монгол Улсын иргэдэд дотоодын аж ахуйн нэгж байгууллагууд хувьцааг нь авах энэ бололцоог нь бүрдүүлж өгвөл илүү их засаглал нь ч гэсэн сайжрах энэ уул уурхайн баялгаас үр өгөөжөөс бүс нутаг.../минут дуусав./

С.Бямбацогт: Жамбалын Ганбаатар гишүүн. Пунсалмаа гишүүн тодруулъя.

Б.Пунсалмаа: Засаглалын хувьд өөрчлөлт оруулж ирж байгаа гэдэг энэ үгийг сонсохоос таатай байна. Тэгээд энэ хууль санаачлагчдаас бас санал ирээд байна л даа. Жишээлбэл та бол энэ хуулийг бид нар түрүүлээд яаралтайгаар батлуулах хэрэгтэй байна, шаардлагатай байна гэдгийг хэлж байна. БНМАУ-ын тухай хууль хуулийг бас тухайлан бас оруулж ирэхгүй бол хэрэгцээ байна гэдэг энэ талаар хэлж байна. Тэгэхлээр энэ хуулиуд бол тус тусдаа орж ирж болно. Гол нь бид нар энэ засаглалынхаа энэ зүйл рүүгээ л чиглэж өөр өөрсдийнхөө хуулиудыг л чиглүүлж л гарах дээрээ л анхаараарай л гэж хууль санаачлагч нарт хэлж байгаа шүү. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Жамбалын Ганбат гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Монгол Улсын төсөв ер нь нэгдсэн биш 3-аас 4 хуваагдчихаад байгаа юм. Улсын Их Хурлын 126 гишүүн бол улсын төсөв гээд 3.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Гэтэл төрийн өмчийн үйлдвэрийн газрууд, төрийн өмчийн компаниуд нийлээд жилдээ 2024 онд 7 их наяд төгрөгийг бол хөрөнгөнөөсөө хасах шийдвэрийг гаргасан байна лээ. Ингээд төрийн өмчит үйлдвэрийн газар компаниудын авч байгаа өр төлбөр нь улсын өр төлбөрт ордоггүй ийм байдалтай байдаг.

Дээрээс нь бол нийслэл, орон нутгийн төсөв гээд бас тусдаа баахан төсөв батлаад илүү орлого бүрдүүлнэ гэж тооцоолоод түрүүгээрээ зардал гаргаад ингээд энэ нь улсын төсвийн зарлага дээр бас нөлөөлдөг ийм асуудлууд бол байгаад байгаа юм. Тэгэхээр одоо бид бол ялангуяа Монгол Улсын төсвийн тухай хуульд нэлээн сайн анхаарах шаардлагатай байгаа.

Сайнзориг гишүүний яриад байгаа энэ төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг нэрийг төрийн өмчийн компани болгоод тэгээд компанийн засаглалыг нь сайжруулахад шаардлагатай учраас оруулъя гэж байгаа энэ санааг нь бол дэмжиж байгаа. Гэтэл бол нөгөө талдаа Нийтийн өмчийн тухай хууль гээд тэгээд төрийн өмчийн компанийн бүтээмж, ил тод засаглалыг сайжруулах гээд ийм хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг ажиллаад байдаг. Тэгээд энэ ажлын хэсэг дээр чинь бас л адилхан засаглалын тухай асуудал яригдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг өнөөдөр энэ хэлэлцүүлэгт бэлдэж байгаа ажлын хэсэг дээр өөрөө Сайнзориг гишүүн маань ажиллаж байгаа. Тэгсэн мөртөө энэ хуулийг оруулж ирээд ингээд явж байгаа энэ 2 дээр яг ингээд харахаар зорилго нь хоёулаа

адилхан засаглалыг сайжруулна гээд. Нэг нь бол Компанийн тухай хуулиар засаглалыг сайжруулъя гээд байдаг. Нөгөөдөх нь дахиад Төрийн өмчийн бүтээмж, засаглалын тухай хууль гэдэг хуулиар засаглал сайжруулъя. Энэ хоёрын гол ялгаа нь юу байх гээд байгаа юм бэ гэдэг ийм асуулт байгаад байгаа юм.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Соронзонболд гишүүн бас үнэн ярьж байна. Ер нь бол улсын төсөв, улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг мэдээж орон нутгийн төсөв байгаа. Энэнтэй хэн ч маргахгүй. Энэ бол яг явдаг ном журмынх нь дагуу явж байгаа боловч төрийн өмчит үйлдвэрийн газар төрийн өмчит компанийг дагасан маш их хэмжээний хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаанууд ч явж байгаа. Бараг улсын төсөвтэй дүйх ч хэмжээнд. Жилд бараг нэлээн улсын төсөвтэйгөө дүйж очих зүйлүүд байгаа.

Дээрээс нь энэ төрийн өмчит энэ компаниудын засаглалыг шийдэхгүй яваад байхаар улс төрийн шийдвэр гаргаад ТУЗ-өөрөө гэдэг юм уу компанийн дүрэмд заасан, эсвэл энэ үйл ажиллагаа явуулахаасаа илүүтэйгээр төмөр зам бариулж байна. Эргээд бас би зүгээр ойрын жишээнүүдийг ярья л даа бас Эрдэнэт үйлдвэр гээд бас аргагүй л бас Монголын ард түмэнд бас нэлээн тус дэм болдог энэ үйлдвэр байдаг. Яах вэ тэгээд КОВИД-ын хүнд цаг байсан ч гэсэн КОВИД-ын баахан хүндрэлийн үеийн санхүүжилтийг өгсөн. Энэ сургууль, цэцэрлэгүүдийн нойлуудыг сайжруулах, модон жорлонгоос салах үйл ажиллагааг санхүүжүүл гээд л шийдвэр гаргаад өгчхөж байгаа юм.

Дээрээс нь бараг Эрдэнэт үйлдвэрээр МИАТ-ийг бас хүндрэлтэй үед бас санхүүжилт олгож байх жишээтэй. Зээл бүр хадгаламж, зээлийн хоршоо шиг, банк бус санхүү шиг л ажиллаж байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь бол ийм байдлыг байж гаргаж болохгүй юм байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Эрдэнэт үйлдвэр ингээд үнэхээр ашигтай ажиллах юм бол ноогдол ашгийн зарчмаараа улсын төсөв дээр тодорхой орлогыг бүрдүүлээд энэ улсын төсвөөрөө буцаагаад ер нь Монгол Улсын иргэдийн нийтлэг эрх ашгийг шийдэх, тэр бүтээн байгуулалт руу байдаг юм уу, эсвэл багш, эмч нарын цалинг нэмэх байдаг юм уу, ахмадын тэтгэврийг нэмэх байдаг юм уу ийм үйл ажиллагаанд зарцуулах ёстой юм. Энэ компанийн засаглалыг алдагдуулах байдлаараа шууд тухайлан төслийг санхүүжүүл гээд дүрмийн бус үйл ажиллагаанууд руу шууд хамааруулаад ордог. Энэ компанийг дагасан энэ хөрөнгө оруулалт байдаг юм уу энэ шийдвэрүүд бол өнгөрсөн хугацаанд олон гарсан. Тэгэхээр энийг бол цаашдаа багц байдлаар нь бол засах ёстой гэдэг Соронзонболд гишүүний хэлээд байгаа энэ углуургыг бол ойлгож байна.

Тэгэхдээ тэр хуулиуд маань дөнгөж хэлэлцүүлэгт бэлтгэгдээд явж байна. Мэдээж бас тодорхой цаг хугацаа орно. Батлах эсэх асуудал бол Улсын Их Хурлын 126 гишүүнээс хамааралтай. Тэгээд батлагдсан ч гэсэн том хэмжээний зөвхөн энэ компанийн засаглалаасаа гадна нэлээн өргөн хэмжээний Монгол Улсын нийт өмчийн менежментийн асуудал хүртэл энэтэй уялдаж яригдаж байгаа учраас хэрэгжих хугацаа дор хаяж л бэлтгэл ажил 6 сар болно ч гэдэг юм уу энэ зүйлүүд хойш тавигдаад байгаа юм.

Тийм учраас яг энэ цаашдаа өнөөдөр Иргэний хуулийнхаа суурь концепцтой 24 зөрчилдөж яваа энэ хуулийн этгээдийн хэлбэрийг хасчихъя. Тэгээд компанийн хэлбэр рүүгээ, засаглал руугаа ороод бас энэ компанийг цаашдаа олон нийтийн болох гэдэг юм уу үр өгөөжийг нь сайжруулах энэ үйл ажиллагааг яг ном журмын дагуу хийж явъя л гэсэн ийм л зүйл байгаа.

Тэгээд ер нь зүгээр яг ядаж компанийн засаг руугаа орвол мэргэжлийн баг хамт олон удирдах энэ бололцоо ч бүрдэнэ. Жишээ нь Эрдэнэс Тавантолгойг бол үндсэндээ өнгөрсөн жилүүд сорчлоод л ашиглачихсан шүү дээ. Одоо тэгээд хэн ч л.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакирын урилгаар Сэлэнгэ аймгийн Цагаан нуур сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, сум дундын ойн анги орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя. Алга байна. Саруул. Уучлаарай Шагай гишүүн асуултаа асууя.

Н.Алтаншагай: Сайнзориг нарын гишүүдийн өргөн барьсан энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа юм. Тэгээд хэдэн тодруулах зүйлүүд байгаа юм. Өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрууд яг бодит байдал дээрээ төрийн байгууллага төрийн захиргааны байгууллага шиг болчихсон бүх томилгоо нь яг тэр нам нь дагаж, улс төр дагаж улс төрийн албан тушаалтан дагаж хийгддэг болсон. Энэ хууль одоо яг өргөн баригдаж шийдэгдсэнээрээ энэ дээр яг бодит шийдвэрүүд гаргаж чадах уу? Сая олон гишүүд давтагдаж асуугдаж байна. Энэ засаглалын гээд. Энэ засаглалын менежментийг сайжруулах энэ засаглалыг сайжруулах, ТУЗ байна, хараат бус гээд байж байна. Эд нарыг яг сонгон шалгаруулах тэр оруулж ирэх системийг нь маш сайн хуульчилж яг тийм системтэй болгохгүй бол ерөнхийдөө найран дундаа л явж байсан гэсэн ийм л дүр зураг харагдаад байгаа юм.

Тэгээд ямар нэгэн улс төрийн сонгуулийн дараагаараа энэ систем нэлээн донсолдог бүх салбартаа ингээд халаа солилоо хийгдээд ирдэг. Би өмнө нь ч гэсэн хэлж байсан. Тэр дарга, тэр сайд, тэр эрх бүхий албан тушаалтан энэ албан тушаал дээр өөрийнхөө хүнийг зүтгүүлээд байна л гээд байдаг. Яг тэр хэлэмжээр нь явсаар байгаад л нөгөө нөхөр нь сонгогдоод л гараад ирдэг. Тэгэхээр энэнээс бид бүхэн бас энийгээ хараат болгох нь зүйтэй байгаа юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хүн байх шиг байна. Нэг зүйл тодруулъя. Өнөөдрийн байдлаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд яг хэд байгаа юм бэ Монгол Улсын хэмжээнд? Сүүлийн 4 жилд хэдэн төрийн өмчит болон энэ оролцоотой нэгжүүдийг хувьчилсан бэ?

Дараачийнх нь асуулт энэ “Өргөө” зочид буудал гэж үлгэр домог шиг юм яригдаж 2, 3 ч хүнээс болж ял авсан. Одоо энэ “Өргөө” зочид буудлын бүртгэл яг хаана байна аа? Нийслэл дээрээ бүртгэлтэй байна уу төрийн өмчийн хороон дээрээ бүртгэлтэй байгаа юу? Энэний маргаан хэрхэн шийдвэрлэгдэх вэ? Дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулчихъя эхлээд дараад нь хууль санаачлагч хариулъя. Индрийн 3 дугаар микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга Баяр-Эрдэнэ.

Өнөөдөр ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар төрийн өмчит хуулийн этгээд гэдэг ийм ерөнхий нэршил байгаа. Үүн дотор бол төрийн байгууллагын албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компани, мөн орон нутаг ороод явж байгаа. Тэгээд мэргэшсэн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сургууль, боловсролын байгууллагууд гэсэн ерөнхий ийм ангилал байгаа.

Өнөөдөр бол нийт улсын хэмжээнд 6 мянга гаруй ийм төрийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд бол аж ахуйн байгууллагуудаас авхуулаад сумын төвд байгаа клуб, номын сангийн бие даасан ийм төрийн өмчит хуулийн этгээдүүд байгаа юм.

Энэ дотроо бол төрийн өмчит, орон нутгийн өмчит энэ үйлдвэрийн газар гэдэг тусдаа ангилал байгаа. Энэ ангилал бол дотроо улсын төсөвт ба аж ахуйн тооцоот гэсэн ийм 2 ангилалтай. Өнөөдөр төрийн өмчит улсын тооцоот үйлдвэрийн газар бол 44 үйлдвэрийн газар байна улсын төсөвт. Энэ улсын төсөвт үйлдвэрийн газрууд бол их, дээд сургуулиуд, шинжлэх ухааны чиглэлийн байгууллагууд байгаа.

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар бол 18 байгаа. Энэ дотор Эрдэнэт үйлдвэр, МОНРОС, Авто тээврийн үндэсний төв, Геологийн судалгаа-шинжилгээний төв, Зам, тээврийн хөгжлийн төв эд нар гээд ингээд ийм төртэй гэрээлэх замаар ажил, үйлчилгээ явуулж байгаа ийм байгууллагууд байгаа.

Улсын төсөвт үйлдвэрийн газрууд бол төсвийн эх үүсвэртэй явж байгаа гэдгийг бол онцолж хэлье. Тэгээд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын тооцоот үйлдвэрийн газар хоёр хоёулаа нийлээд энэ төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг ийм ангилалд орно.

“Өргөө” зочид буудлын асуудал бол нийслэлийн цэвэр өмчийн газрын асуудал. 1999 онд төрөөс орон нутаг руу шилжүүлсэн нэлээдгүй их хөрөнгө дотор жижиг Тавантолгой компанийн хувьцаанаас өгсүүлээд олон хөрөнгө дотор бол энэ “Өргөө” зочид буудлын асуудал бол нийслэл рүү шилжсэн байдаг юм байна лээ. Тэгээд энэ бол нийслэлийн өмчийн газрын мэдэлд байгаа. Энэ талаар яг тодорхой бол бас мэдээлэл алга.

С.Бямбацогт: Тодруулж асууя. Дараад нь хууль санаачлагч хариулъя. Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Ер нь бол нөгөө онолын бөгөөд хууль зүйн талаасаа ч тэр бусад улсуудын сайн жишгээс ч ярихад төрийн нийтийн эрх зүйн этгээд гэж байдаг. Энд үндсэндээ ингээд яам, Тамгын газар, агентлагаасаа эхлээд энэ ажлын албатай байгууллагууд бол хамаарч байгаа.

Төрийн хувийн эрх зүй этгээд гэдэг энд нь бол үндсэндээ компани, нөхөрлөл байх боломжтой. Гэтэл өнөөдөр төрийн өмчит үйлдвэрийн газар гээд ийм ангилал байгаа энэ нь ороод ирдэг энэ нь бас дотроо төсөвт болон бас өөр өөрийгөө аж ахуйн тооцоот үйлдвэрийн байдлаар ингээд зохицуулаад явж байгаа. Ингээд засаглалын хувьд ойлгомжгүй ийм байна.

Одоогийн байдлаар бол ингээд Монгол-Кувейтийн Байгаль хамгаалах төв, Аялал жуулчлалын хөгжлийн төв, Геологийн судалгаа-шинжилгээний төв, Монгол кино нэгтгэл, Барилгын хөгжлийн төв, Автотээврийн Үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Эрдэнэт үйлдвэр, E-Mongolia академи зэрэг ингээд төрийн өмчит үйлдвэрийн газрууд ингээд байж байгаа. Энийг цаашдаа ер нь хуулийн этгээдийн засаглал талаасаа бол нэг компанийн хэлбэр ч нөгөө талдаа.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Тэргүүлэгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай зүүн бүсээс сонгогдсон гишүүн Отгонбаяр гишүүн, Соронзонболд гишүүн, Ганхүлэг гишүүд бас зочидтойгоо хамт бас Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэндээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Цоглог бүсгүйчүүд харагдаж байна манай бүсгүйчүүд.

Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Тайлбаруудыг авлаа. Тэгээд энэ төрийн өмчтэй холбоотой бас түрүүн ч гишүүд ярьж байна 2, 3-н хууль давхцаж орж ирж байгаа юм. Гол концепшн бол энэ төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй гэсэн энэ бодлого яг энэ 3-н хууль дотор нэгтгээд орж ирээсэй гэж хууль санаачлагчаас хүсэж байна.

Дараагийнх нь энэ төрд нөлөө бүхий этгээдүүд гээд байгаа юм төрд ажиллачхаад тэгээд нөгөө албатай юм шиг баахан юм руу хуруу дүрж хувьчилж авдаг, хулгай хийдэг энэ байдлыг яаж таслан зогсоох ёстой юм? Ёс зүйн хувьд энэ хаанаа энэ хууль дээрээ орших ёстой юм. Тэр хувь хүнтэй л холбоотой асуудал байгаа. Тэгээд ийм хэдэн жил дамнасан шүүх, хуулийн байгууллага маргаан үүсгэчихсэн. Тэгээд төр нь буцаагаад 3-н шатны шүүхийн шийдвэр гараад өмчөө буцааж авах гэхээр өгдөггүй, өгөхгүй гээд улалзаад байдаг энэ заваан юмыг энэ Төрийн өмчийн хороо ч гэсэн бас нэхэмжлэл гаргаж төр.../минут дуусав./

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариу хэлье.

П.Сайнзориг: Тийм, Алтаншагай гишүүнтэй санал байна. Тэгээд түрүүн бас нэг хариултыг хэлье гэж бодсон. Манай энэ хуулийн этгээдийн засаглал хэлбэр

талаас алдагдуулаад байгаа юмнуудыг бас өмнө нь бол энэ бүртгэлийн багц хуулийг батлахдаа үйл ажиллагааны чиглэлүүд буюу боловсролын үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйл ажиллагааны чиглэлийг аваачаад хуулийн этгээдийн хэлбэр гэж хуульчлаад баахан компаниуд төрийн байгууллагуудын засаглалыг алдуулсан.

Тэгээд энийг 18 онд бас Бямбацогт даргыг сайд байх үеийн бас хууль буюу Бүртгэлийн багц хуулийг боловсруулж бас зассан л даа. Тэгээд л одоо хүртэл гажиг нь ингээд л үлдчихээд л яваад байгаа юм.

Ер нь зүгээр цаашдаа энэ өмч хувьчлалыг ингэж үнэгүйдүүлж биш тодорхой эсвэл өмчийг авсан тохиолдолд бас энэ хуулийн дагуу байх энэ асуудлыг бас шийдэхийн тулд энэ төрийн өмчийн багц хууль явж байгаа. Ер нь зүгээр бас илт шударгаар юм уу ер нь зүгээр төрийн өмчит компанийн хувьцааг олон нийтэд биржээр санал болгох байдлаар л энэ өмч хувьчлалууд ер нь цаашдаа зөв зохистой явах ёстой юм. Манай бусад хөдлөх хөрөнгүүдийн асуудлыг ч гэсэн одоо манай Номинчимэг гишүүний асуудал дээр.../минут дуусав./

С.Бямбацогт: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр 2025 оны 12 сарын 30-ны өдөр БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгохоор миний бие бол өргөн барьсан байгаа. Тэгээд хаврын чуулган эхэлсний дараагаас бол энэ маань Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдээд тэгээд нэгдсэн чуулганаар бас хэлэлцэх эсэх нь бол дэмжигдчихсэн явж байгаа ийм хууль байгаа. Энэний дараа болохоороо Сайнзориг гишүүн маань 4 сарын 9-нд Төрийн болон орон нутгийн өмчит тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийг өргөн барихдаа дагалдах хуулиар бас мөн адил энэ БЭТ-ийн тухай хуулийг хүчингүй болгохоор өргөн барьсан. Ингээд үүсэж байгаа зүйл маань бол одоо бол тухайн ажлын хэсгийг нэгтгэсэн байдлаар явуулья гэдэг саналуудыг бол бас зарим гишүүд бас гаргаад байгаа юм. Энэ дээр би бол санал нэгдэхгүй байгаа.

Яагаад вэ гээд тэгэхээр өргөн барьсан он, сар хугацаагаа ч тэр хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн он сараараа ч тэр энэ БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн үзэл баримтлалынхаа хүрээнд тусдаа хэлэлцүүлэгдэх нь зүйтэй юм гэдэг байр суурьтай байгаа юм. Яагаад вэ гээд тэгэхээр ер нь үндсэндээ энэ БЭТ томилдог байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийг зөрччихсөн энэ хуулийг амьд байлгаад байх ямар ч шаардлага байхгүй байгаа.

Тэгэхээр энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль маань өөрөө маш том концепцыг дагуулж байгаа юм. Дээрээс нь Нийтийн өмчийн тухай хууль гээд ахиад тэр хуультайгаа нэгдэж хэлэлцүүлэгдэх ёстой гээд яригдаад байгаа. Ингээд ирэхээр ажлын хэсгийг нь нэгтгээд явна гэдэг маань тухайн БЭТ-ийн хуулийг хүчингүй болгох ажил маань бас гацалтад орох вий гэдэг болгоомжлол бол надад байгаад байна. Тэр утгаараа үндсэндээ бол ажлын хэсгээ тусдаа салгаад явчихъя гэдэг саналыг бас Сайнзориг гишүүнд бас тавимаар байгаа юм. Би бас хариултууд өгч байхдаа ч гэсэн энэ нь адилхан зорилготой байгаа учраас тухайн ажлын хэсэг нь тусдаа салж явсан нь зүйтэй юм гэдгийг бас байр сууриа хоёулаа нэгтгээд явсан нь дээр юм болов уу гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр таны саналыг сонсьё.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би Цэнгүүн гишүүний саналыг бол хүндэтгэж байна. Яах вэ энэ ингээд агуулга ижилхэн байна, зорилго адилхан байна, та хэд нэгтгээд яв гээд бас гишүүд хэлээд байгаа боловч цаг хугацааны хувьд бас бодолцоод үзэх юм бол Цэнгүүн гишүүний хуулийг ч гэсэн хэлэлцээд баталчих хэрэгтэй. Би бас 8 гишүүнтэй санал өргөчхөөд байгаа. Ариунзаяа гишүүн, Баасанжаргал, Баярбаатар, Болормаа, Саранчулуун, Номин, Номинчимэг, Энхцэцэг гээд бидний бас энэ хууль ч гэсэн Цэнгүүн гишүүний тэр давхцалаас бусдууд нь бол бас уг нь бол цаг хугацаа хүлээхгүйгээр энэ удаадаа бас Иргэний хуулийнхаа концепцтой ч гэсэн нийцүүлээд шийдвэр гаргачхаж болохоор л юм байгаа юм.

Ингэсэн тохиолдолд Засгийн газар бас энэ төрийн өмчит болон үйлдвэрийн газруудыг компанийн хэлбэрт оруулаад цаашдаа энийг олон нийтийн болгох уу, эсвэл менежментийг нь яаж сайжруулах вэ гэдэг бэлтгэл ажлаа хийгээд, орон нутгийн түвшинд баахан бас төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдчихаад байгааг бас жоохон засах, хумих энэ ажлыг ч гэсэн цаг алдалгүй хийж байх нь зөв юм болов уу гэж би хувьдаа бодож байгаа юм.

Тэгэхдээ яах вэ энийг хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа бол Засгийн газрынхаа төлөөлөл буюу Энхбаяр сайдтай л ярилцах байх Хэрэг эрхлэх газрын дарга. Би бас ярилцаж үзье. Ер нь бол Цэнгүүн гишүүнийхтэй бол заавал нэгтгэе энэ тэр ч гэдэг юм уу хувь бус санаа гишүүнийхээ хувьд бол тийм зүйл байхгүй. Зүгээр гишүүд бол саналаа хэлж байх шиг байна Цэнгүүн гишүүн ээ. Тийм учраас аль аль хуулийн төслүүдээ журмынх нь дагуу, горимын дагуу хэлэлцүүлээд явъя гэдэг дээр бол тантай адилхан санал нэг байна.

С.Бямбацогт: Тэгээд хууль санаачлагчид маань хоёулаа бас зөвшилцөөд илэн далангүй бас ярилцаад тус тусад нь хэлэлцье гэж байгаа юм байна. Тийм болохоор хууль санаачилж нэгтгэе гэсэн тохиолдолд нэгтгэж болдог нэгтгэж ажлын хэсэг байгуулж. Нэгтгэхгүй тусад нь хэлэлцье гэж байгаа тохиолдолд бол тус тусад нь хэлэлцээд явна. Тийм болохоор Цэнгүүн гишүүн салгаад ингээд хэлэлцээд явна гээд ойлгочхоорой. Сайнзориг гишүүн ч зөвшөөрч байна тийм ээ? Тамгын газрыг ийм байдлаар бэлтгэл хангая.

Сархадын Зулпхар гишүүн асуултаа асуулъя.

С.Зулпхар: Та бүхний өдрийн амрыг амар амгаланг айлтгая. Их чухал асуудал. Өнгөрсөн ер нь 3-н долоо хоногт л энэ асуудалтай холбоотой их олон хэлэлцүүлгүүд боллоо. Судалгааны үр дүнгүүд ч танилцлаа. Заримыг нь бид бол бас сонсохоор зэрэг бас л санаа зовох зүйлүүд их байна л даа. Юу гэхлээр зэрэг энэ төрийн өмчийн засаглалтай холбоотой асуудал дээр бид маш их будилчихсан явж байгаа юм байна. Тэр будилаан ер нь санаатай юм уу, санамсаргүй юм уу, мэдэж хийж байгаа юм уу, мэдэхгүйгээсээ хийсэн юм уу гэдэг ийм асуултын хариултыг л бид нар шаардаад байна лээ. Үнэнийг хэлэхэд бол. 99 төрийн өмчит компаниуд дээр аудит хийгээд тэгээд тэндээс бол үндсэндээ 43 нь жишээ нь ашиггүй ажилласан, алдагдалтай ажилласан. Тэгээд тэр алдагдал нь бол 156 тэрбум төрөл байгаа байхгүй юу. Тэгэхлээр зэрэг ийм түвшний юмыг бол бидэнд танилцуулж байна. Мэдээж хэрэг бүх компаниуд ижил бол биш компанийн

засаглалаа, эс үгүй бол компанийнх нь гүйцэтгэх удирдлага нь сайн байх юм бол үр дүнгүүд гарч байгаа юмнууд бол байна л даа.

Тэгэхлээр энэ үүднээс нь аваад үзэх юм бол Сайнзориг гишүүний сүүлийн жишээ нь бараг хагас жил ярьж байгаа энэ төрийн өмчийн асуудлын засаглалыг сайжруулъя гэдэг зүйл бол бидэнд бол тулсан том сорилт. Энийг заавал бид хамтдаа шийдэх ёстой гэж ойлгож байгаа юм. Энийг шийдэхгүйгээр бид бол болохгүй юм байна. Гаднын сайн жишгүүд байна. Тэгээд тэр жишгээс бид нар заавал буруугаар өөрөөр яваад байдаг ийм өөрсдөө ийм сонирхолтой улсууд юм байна. Тэр сонирхлоосоо ер нь татгалзах ёстой юм байна гэдэг ийм л хариулт өгч байна лээ.

Би зүгээр тодорхой асуулт байна Баяр-Эрдэнэ даргаас. Баяр-Эрдэнэ даргаа энэ компанийн ТУЗ-д төрийн албан хаагч нар танайхаас ч гэсэн ордог юм байна лээ шүү дээ. Ер нь энэ ордог жишгээс цаашдаа та бүхэн яах тийм бодлогын санал гаргаж байгаа вэ? Татгалзах юм уу, эс үгүй бол төрийн албан хаагчид тэр төрийн өмчит компанийн ТУЗ-д байх энэ жишиг рүүгээ явсаар байх юм уу? Энэ дээрээс та бүхэн ямар бодлоготой байна? Нэгдүгээр асуудал.

Хоёр дахь асуудал бол энэ төрийн өмчит компаниудын чинь гүйцэтгэх удирдлага нь буюу СЕО нь бол цэвэр мэргэжлийн хүн байх ёстой юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ мэргэжлийн улсуудыг сонгон шалгаруулж тэнд томилдог тэгээд тэрэнтэй холбоотой үр дүн гаргах энэ бодлого л чухал юм байна лээ. Энэ чиглэлээр бас манай Бодлого, зохицуулалтын газар маань ямар бодолтой байна гэдэг ийм асуулт байна.

Миний гурав дахь асуулт бол хууль санаачлагчаас. Угаасаа өөрөө энэний араас маш тодорхой явж байгаа учраас бид энэ хуулийн маш тодорхой зохицуулалт орууллаа. Тэгэхдээ энүүгээр жишээ нь бүх зүйл хязгаарлагдах уу үгүй юү гэдэг асуудал дээр таны нөгөө бас бариад явж байгаа хууль байж байгаа шүү дээ тийм ээ тэрний хүрээнд энэ 2 хууль хоорондоо хэр уялдах вэ? Ингэж байж төрийн өмчит компаниудын засаглалыг, үр ашгийг, эдийн засагт оруулах жишээ нь үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээрх үр дүн гарах чиглэлээр та ямар байр суурьтай байна вэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Зулпхар гишүүн маань бас их энэ уг асуудлыг бас сууриар нь ойлгоод бас ажлын хэсэг ч гэсэн идэвхтэй ажиллаж байгаад, бас дэмжиж ажиллаж байгаад бас талархалтай байгаа юм. Ер нь энэ нэр томъёог солиод явчхаж байна л гэдэг зүйл бас зүгээр зарим гишүүд ч бас асууж байсан. Тэгэхээр энэ нэр томъёоны цаана бас агуулга яригдаад байгаа юм. Наад захын компанийн засаглал руугаа орчих юм бол бид нар компанийн байх ёстой бүтцүүд буюу ТУЗ-дөө байх мэргэжлийн этгээдүүд томилох, сонгон шалгаруулалтын асуудлыг шийдэх ч гэдэг юм уу байгаа. Тэгэхдээ сонгон шалгаруулалт дээр мэдээж эргэлзээтэй зүйлүүд байна. Хараат байгаа, улс төрөөс хамааралтай байна. Ер нь бол юу гэдэг юм энэ компанийн сайн засаглалтай холбоотой энэ асуудлуудыг манайхан бол ойлгодог олон жил ч ярьдаг.

Төрийн өмчийн бодлого зохицуулалт болон Санхүүгийн зохицуулах хорооноос гаргаж тавьсан удирдамж, дүрэм, журмууд байдаг. Энэ дүрэм, журмыг үндсэндээ барихгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг л цаашдаа бодлогын түвшинд хууль болгож хуульчлах ёстой юм байна гэдэг л үүднээс Засгийн газар бас хуулийн төслийг өргөн барьсан. Хууль маань бол өмнө нь удаа буюу 21 онд Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газрын үед Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд байж байхдаа барьсан. Дараа нь Занданшатар Ерөнхий сайдын үед, Учрал, өнөөдрийн Ерөнхий сайд Учрал дарга Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа дахин өргөн бариад ингээд улс төрийн хувьд бол хүсэл зориг илэрхийлээд байгаа. Тэгэхдээ энэ яриад байгаа асуудлуудыг эцэслэж яг бодлогын гэдэг юм уу хууль, эрх зүйн тодорхой зохицуулалт болгож гаргах ажил маань жоохон ингээд хойшлоод яваад байгаа. Тэгээд энэ удаа Үүрийнтуяа даргаар ахлуулсан энэ 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг бол энэ асуудлыг бол шийдээд явна.

Миний энэ хууль бол ямар ч байсан 2002 оныхоо Иргэний хуулийн суурь концепцтой нийцүүлээд хуулийн этгээдийнхээ ангилал, төрөл, хэлбэр рүү оруулчихад бас жижиг гэлтгүй олон зүйлүүд бол засагдах юм байна гэсэн энэ үзэл байгаа.

ТУЗ-ийн энэ асуудал дээр ч гэсэн яах вэ зүгээр нэмээд хариулчихъя. Яг энийг бол бүтэн цагаар хийх ажил юм байгаа юм. ТУЗ-ийн гишүүн гэдэг бол. Гэтэл төрийн албан хаагчид бол бараг албан тушаал.../минут дуусав./

С.Бямбацогт: Баяр-Эрдэнэ дарга 3 дугаар микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Ер нь бол өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоороо бол хувьцаа эзэмшигчийг төлөөлж төрийн жинхэнэ захиргааны албан хаагч бол төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр томилогдох ийм хуулийн зохицуулалттай байгаа. Улс төрийн албан тушаалтан бол болохгүй. Зөвхөн төрийн захиргааны албан тушаалтан. Яг үндсэндээ бол захиргааны албан тушаалтан албан тушаалаар томилогдож ирсэн энэ тогтолцоог 2022 оноос хойш бол халаад Засгийн газраас нь 84 дүгээр тогтоолоор төлөөлөл хэрэгжүүлэх журам батлагдсан. Тэн дээр бол сонгон шалгаруулалт явуулаад салбар дундын яам, яамны ирүүлсэн нэрсээс хамгийн шаардлага хангасан хүнийг төрийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдээр томилох ийм концепц хэрэгжээд явж байгаа.

Гэхдээ учир дутагдалтай зүйлүүд бий. Энийг бол энэ Төрийн болон орон нутгийн өмчит, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуульд бол нэлээн сайн тусгаж өгсөн байгаа. Ер нь бол төрийн өмчит компанийн ТУЗ-ийн гишүүнийг томилох асуудал бол манай Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан засаглалын кодексоор.../минут дуусав./

С.Бямбацогт: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Би энэ төрийн өмчийн компаниудтай холбоотойгоор бас гишүүдийн өргөн барьж байгаа хуультай холбогдуулаад хэд хэдэн зарчмын байр суурийг бол хэлье гэж бодож байгаа юм. Тэгэхдээ хууль санаачлагчтай бол холбоотой асуудал биш. Мэдээж хууль санаачлагчид одоогийн байгаа болохгүй, бүтэхгүй байгаа энэ төрийн өмчийн компаниудын асуудлыг бас цэгцлэх гээд орж

ирж байгаа нь бол сайшаалтай асуудал. Үндсэндээ манай Монгол Улс ч нийтдээ 560 орчим төрийн өмчийн компаниуд байна гэж байгаа юм. 129 төрийн өмчийн компани, 429 орон нутгийн өмчит компани, ингээд үндсэндээ бараг 30 орчим мянган хүн төрийн өмчийн компанид ажиллаж байна гэж явж байгаа юм.

Тэгээд уг нь энэ компаниудыг нь судлаад аваад үзэхээр үндсэндээ тэнд хяналт, хариуцлага байхгүй, засаглал, компанийн засаглал гэдэг зүйл байхгүй, улс төрийн нөлөө асар өндөртэй, авлигын өндөр эрсдэлтэй. Ингээд зүгээр хувийн өмчийн компани байсан бол өдийд бол бараг дампуурсан. Дампуурсан мөртөө дампуурдаггүй ийм компаниуд болчихоод байгаа юм. Тэгээд тэр алдагдал, өр зээл гэдэг зүйлээ компани хоорондынхоо юу гэдэг юм өр зээлээрээ авлагаараа хоорондоо шилжүүлээд, татвар төлөгчдийн мөнгөөр алдагдлаа нөхөөд явдаг ийм гажуу жишиг бол бидэнд бий болчихсон байна. Гажуу жишиг бий болчихсон байна.

Уг нь бол төр бол өөрөө юу яах ёстой юм бэ гэхээр сайн засаглал гэдэг бол өөрөө бага засаглал л гэж байгаа юм. Бид нар энэ эдийн засаг дахь энэ төрийн оролцоог нь хязгаарлах, иргэд болоод энэ эдийн засгийн эрх чөлөөг илүү чөлөөтэй байлгах хувийн хэвшилд орон зайг нь бий болгох зайлшгүй шаардлага байгаад байдаг.

Гэтэл үндсэндээ бид бүхний энэ төрийн өмчийн компани гэдэг энэ Монгол стандартын төрийн өмчийн компаниуд чинь үндсэндээ олон улсын нийтлэг стандарттай засаглалаас гажсан зүйлийг бид нар бий болгох гэж 20, 30 жил боллоо. Болохгүй зүйлийг байлгах шаардлага байгаа юм уу? Би бол асуух гээд байгаа зүйл энэ Төрийн өмчийн хорооноос асуух гээд байгаа юм. Энэ төрийн өмчийн хороо хариуцсан, төрийн өмчийн компаниуд хариуцсан сайд нар нь яагаад энд бас суухгүй байгаад байгаа юм? Энэ компаниудаас санаа нь зовохгүй байгаад байгаа юм уу? Шударгаар хэлэхэд үндсэндээ одоо бид нар бол энэ хайрцгаасаа гарч сэтгэх гэж ярих гэхээсээ илүүтэй бүүр хайрцаггүй юм шиг сэтгэгчтэй болчихоод байгаа байхгүй юу. Заавал ч үгүй тэр хайрцаг байх ёстой юм шиг төрийн өмчийн компаниуд Монголын төрд байх ёстой юм шиг тэрийг нь юу гэдэг юм заавал ч үгүй ингэж хий хоосон хувийн хэвшлийн орон зайг нь эзэлж байлгаж байх ёстой юм шиг энэнээсээ илүү өөрөөр бодмоор байгаад байгаа юм.

Уг нь компани бол бусад хувийн хэвшлийн компаниудтай яг л адилхан засаглалтай, тэр стандарт, дүрэм журмаа мөрддөг компанийн засаглалтай. Магадгүй Монголын энэ компанийн тухай хуулиар энэ 100, 200 мянган компаниудтай адил жишгээр л явах ёстой болчихоод байгаа юм. Гэтэл тусад нь магадгүй хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөөд ингээд явах гээд байх шаардлага байгаа юм уу? Аваад үзэхээр нь төрийн өмчийн компаниудын өр зээлийг нь, өр төлбөрүүд нь хэд байгааг нь тооцдог зүйл байхгүй. Өнөөдөр магадгүй нийт төрийн өмчит болоод орон нутгийн өмчит компаниудын нийт өр нь 22.8 их наяд гэсэн дүнг аудит хийсэн байгаад байгаа юм. Энэ үнэн юм уу?

С.Бямбацогт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хариульъя. 3 дугаар микрофон. Индэр дээр ирж байгаарай.

Зочин танилцуульъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Орчлон” сургуулийн 12^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Удахгүй болох элсэлтийн ерөнхий шалгалтдаа сайн бэлдээд хүссэн мэргэжлээрээ хүссэн сургуульдаа элсэж орж, мэргэжил эзэмшээд улс эх орондоо дэлхийд бас данстай, нэртэй иргэн болж төлөвшихийг та бүхэндээ хүсэн ерөөе. Аав, ээжийнхээ, багш нарынхаа үгэнд бас сайн орж байгаарай гэж бас хүсье. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс сурлагад нь өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баяр Эрдэнэ гишүүн хариулчихъя.

Ц.Баяр-Эрдэнэ: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь бол 1900, 2012 оноос хойш энэ төрийн өмчийн компаниудын аж ахуйн байгууллагуудын засаглалын тогтолцоо бол үндсэндээ төвлөрсөн бус хэлбэрт шилжсэн. Өнөөдөр бол энэ 100 гаруй төрийн өмчит компаниудыг 11 байгууллага тус тусдаа бие даасан байдлаар удирдан зохион байгуулж байгаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр бол нэгдсэн тооллого, дүн бан жилийн эцсийн аудитлагдсан тайлангуудыг нэгтгэж гарга гэж байгаа. Удирдлагын хувьд бол ийм засаглалын олон талт ийм хэлбэрээр явж байгааг би онцолж хэлье.

2024 оных нь үзүүлэлтийг 2025 оны аудитлагдсан тайлангаар бол үндсэндээ 23 их наядын өр төлбөр байсан. Энэ бол үнэн. Тэгээд энэ өр төлбөр төрийн өмчит компаниудын өөр хооронд нэлээн ийм бий болсон шинжтэй байгаа.

2025 оны аудитлагдсан тайлан үндсэндээ нэгтгэгдэж байна. Бидний урьдчилж нэгтгэж байгаа байдлаар бол ер нь 30 гаруй их наядын ийм өр төлбөр компаниудын хооронд бий болсон ийм дүр зураг харагдаж байгаа. 25 оны үр дүнгээр бол 24 их наяд орчим төгрөгийн борлуулалтын орлого олоод улс орон нутгийн төсөвт 6 их наяд орчим төгрөгийн татвар хураамж төвлөрүүлээд 5 их наяд орчим төгрөгийн ийм ашигтай харагдаж байгаа.

Гэхдээ компаниудын маань дийлэнх ашиг, орлого бол төрийн өмчит 3-4 томоохон компани дээр төвлөрч явж байгаа гэдгийг онцолж бас хэлье.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн нэмээд хариулчихъя.

П.Сайнзориг: Би яагаад бас нэмэлтээр хариулт өгөх юм гэхээр Тэмүүлэн гишүүний асуудалтай санал нэг байна. Ярьсан бүх зүйлүүд дээр бол 90 хувийн саналтай байна, санал нэгдэж байна. 10 хувь дээр нь би юу хэлэх гэж байна гэхээр төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал засаглалыг сайжруулах бол зайлшгүй байгаад байгаа юм. Төр өөрөө эргээд энэ хувьцаа эзэмшихийг хэрэгжүүлэх гэдэг юм уу энэ ТУЗ-ийн гишүүдийг томилох, эсвэл гүйцэтгэх удирдлагад томилох энэ харилцаа өөрөө захиргааны эрх зүй талдаа болчихоод байгаа юм. Энэ томилогдсоноос хойш цэвэр Компанийн хууль цаашдаа үйлчлээд явна. Гүйцэтгэх захирал болон ТУЗ-д.

Тэгэхээр энийг бусад улс орнууд бол ерөнхийдөө энэ пост коммунист орнууд болон бусын дэлхийн бусад орнууд бол яг энэ асуудлыг ингээд 2 хуулиудаар ерөнхийдөө уялдаатайгаар зохицуулж байгаа. Тэгээд бусад таны хэлж байгаа асуудлууд бол 100 хувь санал нэг байна. Энэ бид нарт бас мэдээж авуштай амьдралын үзлүүд, зарчмууд байдаг боловч яг энэ төрийн өмчит

компанийн засаглал, энэ төрийн өмч дээр бол энэ Монгол стандарт гаргаж ирэх гээд ийм зүйл ерөөсөө болих хэрэгтэй. Тэгээд ерөөсөө ингээд урвуу.../минут дуусав./

С.Бямбацогт: Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Би дахиад бас асуух гээд байгаа зүйл нь Төрийн өмчийн хорооноос үндсэндээ ингээд төрийн өмчийн гээд байгаа энэ 560 орчим компаниуд чинь бүгдээрээ 23, 4 их наядын өр зээлтэй болчихоод байдаг, бүгд алдагдал гаргадаг, эргээд компани хоорондынх нь өр зээл, авлагын асуудлуудыг нь та хэд ингэхэд бүртгэж чадаж байгаа юм уу? Бид нар 2023 онд уг нь Цогтбаатар гишүүн санаачлаад энэ төрийн өмчийн болоод орон нутгийн өмчит компаниудыг байгуулахыг хориглосон хууль гаргасан.

Тэгтэл тэрнээс чинь хойш сүүлийн 3 жилийн хугацаанд бас дахиад нэмээд хэдэн 10 компани гарчихлаа. Хөдөө орон нутаг ч тэр байна, энэ төрийн, энэ хот суурин газар Улаанбаатар хотноо ч гэсэн энэ охин компаниуд нэртэй олон компаниуд гарчихлаа. Яг хэд гарсан, яагаад та нар ямар хуулийн үндэслэлийн хүрээнд энэ компани байгуулаад яваад байгаа юм бэ?

Дээрээс нь энэ Хөгжлийн банкин дээр байгаа чанаргүй зээл болоод өр, авлагын чинь төрийн өмчийн компанид хамааралтай нь хэд байгаад байгаа юм? Би буруу аваагүй бол 1.2 их наядын өр зээлийн 450 тэрбум нь бол төрийн өмчийн компанитай холбоотой байна гэж байгаа юм. Хөгжил.../минут дуусав./

С.Бямбацогт: Баяр-Эрдэнэ дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Ц.Баяр-Эрдэнэ: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар төрийн өмч Улсын Их Хурал, Засгийн газар орон нутгийн өмч бол тухайн шатын иргэдийн төлөөлөгчийн Хурал, Засаг дарга хэрэгжүүлээд явж байгаа.

Орон нутаг болгон өөр өөрсдийнхөө хэрэгцээ шаардлагад нийцүүлээд аж ахуйн үйл ажиллагаанд оролцоод явдаг. Бид өнгөрсөн онд орон нутагт байгуулагдсан аж ахуйн нэгж, татан байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн тоог бас гаргаж байсан. Энэ жил бол 20 орчим, нэгдсэн дүнгээр 20 орчим ийм үйлдвэрийн газар, хуулийн этгээд орон нутагт 21 аймаг, 9 дүүрэг, зарим нэг сумдад оролцуулаад 20 гаруй аж ахуйн нэгж байгуулагдсан ийм дүн мэдээ гарч байгаа.

Ер нь бол шинээр хуулийн этгээд аж ахуйн байгууллага байгуулах асуудлыг бол төрийн өмч дээр бол Засгийн газар шийдээд явдаг. Засгийн газар дээр бол харин татан буулгах, нэгтгэх, өөрчлөх ийм ажлууд зохион байгуул.../минут дуусав./

С.Бямбацогт: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн. Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Би эцэст бараг санал маягтай бас хэлье дээ. Энэ ер нь хүссэн, хүсээгүй бид нар эд эрүүл эдийн засгийн бүтцийг бий болгоё гэж бодож байгаа бол хувийн хэвшлээ хөгжүүлэх хэрэгтэй байгаад байгаа. Хувийн хэвшлээ дэмжих хэрэгтэй болчихоод байгаа юм. Чөлөөт зах зээлээ дэмжих хэрэгтэй болчихоод

байгаа юм. Энэ дампуурсан мөртөө дампуурдаггүй төрийн өмчийн энэ компаниудаа бол хувьчлах бодлогоо бол барих ёстой байна. Тэгэхгүй бол 560 орчим энэ төрийн өмчийн компаниуд, дээрээс нь 23, 4 их наядын өр зээлтэй ийм юу гэдэг юм дэлхийн стандартаас зөрсөн энэ дэлхийгээс гажсан шинэ дугуй зохиогоод байх гээд байгаа бол шаардлага байхгүй. Цаашдаа бол бид нар илүү юу гэдэг юм би түрүүн хэлээд байгаа хайрцагтай байх ёстой юм шиг сэтгээд байдаг, хайрцагаасаа гаръя гэж сэтгээд байдаг. Тэгэхгүйгээр өшөө бүр би хайрцаггүй юм шиг сэтгэж бодох хэрэгтэй болж байгаа. Тэгэхээр бид нарт үндсэндээ төрийн өмчийн компани байх шаардлага байхгүй гэдэг нь харагдаад байхад бол үндсэндээ бодит үнэн нөхцөл байдалтайгаа бол нөхцөл байдлаа ойлгож энэ дүн шинжилгээ хийгээд зоригтой шийдлүүдийг бол гаргаад явах шаа.../минут дуусав./

С.Бямбацогт: Үг хэллээ. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Ерөнхийдөө чиглэлийг нь бол дэмжиж байгаа юм энэ Сайнзориг гишүүний санаачилж байгаа. Гэхдээ ийм тодорхойгүй нөхцөл байдлууд аягүй ихээр бий болж байна гэж харж байна. Хувийн хэвшлийнхэн ялангуяа энэ компаниуд зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш 30 гаруй жил компаниуд өөрсдийнхөө хүний нөөцийг бэлдээд бас тодорхой туршлага хуримтлуулаад бөөн дарамт доор үйл ажиллагаагаа явуулж байгаа. Маш олон компани нэгжүүд дампуурдаг. Маш олон компани нэгжүүд шинээр үүсгэн байгуулагдаж, өргөжиж, тэлэхийн төлөө хичээдэг. Гэтэл энэ төрийн өмчит үйлдвэрийн газар гэдгийг компани болгочихоор яваандаа энэ аймаг, нийслэл, сум, дүүрэг, компани байгуулаад эхэлье, нөгөө хувийнхантайгаа өрсөлдөөд эхлэх ийм эрсдэл бий болох вий гэдгийг та бүхэнд хэлмээр байна. Энийг яаж хамгаалж байна вэ гэдгийг асуумаар байна нэгдүгээрт.

Ялангуяа энэ нэр томъёоны асуудал дээр жишээгээр энэ компани байгууллаа гэхэд татварын, компани гэхээр зэрэг татвар дээр бүртгэгдэнэ. Улсын бүртгэл дээр болохоор үйлдвэрийн газар гэдэг статусаараа байна. Тэгэнгүүт энэ маргаан үүсвэл шүүх дээр ёстой аягүй олон энэ тодорхойгүй нөхцөл байдал үүсэх магадлалтай байна гэж харж байна. Энийг аягүй тодорхой тайлбарлаад өгөөч ээ.

Тэгээд энэ төрийн өмчит компани болчихоор ТУЗ-ийг нь улс төр томилно тийм үү? Одоо миний мэдэж байгаагаар Монгол Ардын нам дийлэнх компаниудынхаа ТУЗ-ийг улс төрийн ийм томилгоонууд хийгээд явчхаж байгаа юм. Захирлуудыг нь бас нам томилоод явчхаж байгаа юм. Тэгээд компани болчихдог. Арай гэж зах зээл дээр хөлөө олох гэж байгаа компаниудтай нөгөө энэ төрийн бий болгосон энэ зохиомол компаниуд өрсөлдөөд нам томилдог ийм захиралтай компаниуд бий болох уу? Энийг яаж та нар эрсдэлээс нь хамгаалж байгаа юм бэ? Тэгээд яаж IPO гаргах юм, ямар аудит хянах юм? Төрийн аудит хянах юм уу? Эсвэл хувийн аудитын компаниуд, олон улсын аудитын компаниуд хянах юм уу? Энэ хяналтын системээ аягүй тодорхой тайлбарлаад өгөөч ээ.

Дээрээс нь компани болчихсоны дараа компанийн хувьцааг зарах, борлуулах асуудал үүсвэл яах вэ? Төрийн өмчийн аягүй өндөр өртөгтэй компанийг тодорхой хувийг нь аваачаад гадаадын хөрөнгө оруулалтаар ч юм уу ингээд хувьчлах ийм эрх шилжүүлэх асуудал үүсвэл энийгээ яаж хамгаалж байгаа юм бэ? Мэдээлэл авчхаад тодруулж асууя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Одоо ч л компани байгуулах асуудал замбараагүй явж байна. Сүүлдээ ингээд компани гэдэг бол бас тодорхой хяналтын бүтэцтэй. Өнөөдөр тэгээд ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг улс төрөөс хараат байдлаар сонгогчоод байна гэдэг хардалтууд ч байгаа. Зарим дээрээ бодит байдалтай ч тийм байгаа. Тэгэхдээ энд бас хяналт ажиллаад байгаа байхгүй юу. Гэтэл төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг чинь бас л улс төрөөс бөгөөд бүүр ямар ч хяналтгүй болчихоод байгаа юм. Ядаж их хэмжээний хэлцэл байгуулахад ТУЗ-өөр ордог байхгүй юу. Гэтэл төрийн өмчит үйлдвэрийн газар дээр энэ чинь 1 хүн шийдвэр гаргаад яваад байна шүү дээ. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт мөн ялгаа байхгүй. Тэгээд хамгийн үнэ цэнтэй Эрдэнэтээс эхлээд ч гэдэг юм уу “МОНРОС” гэдэг юм уу ингээд л төрийн өмчит үйлдвэрийн газар статустай л байж байна. Тэгэхдээ ер нь яах вэ зүгээр энэ асуудлуудыг цаашдаа компанийн хэлбэрт оруулаад илүү их л үйл ажиллагааг нь үр дүнтэй сайжруулаад явах чиглэл рүү орёе гэж байгаа юм.

Түрүүн Тэмүүлэн дарга ч бас ярьж л байлаа л даа бас Цогтбаатар нарын гишүүд энэ төрийн өмчит компанийг байгуулахыг хязгаарласан шийдвэр гаргасан гээд Улсын Их Хурлын тогтоол юм хязгаарлаж болохгүй л дээ. Тэгэхдээ ер нь зүгээр аль ч либерал эдийн засагтай оронд угаасаа төрийн өмчит компани байгаа. Харин байгаа юмнуудыг зохистой яаж хувийн хэвшилтэйгээ шударгаар өрсөлддөг байх вэ, илүү их давуу тал төрийн гэдэг юм уу, орон нутгийн гэдэг тодотголоосоо болж давуу байдал эдлэхгүй байх вэ, эргээд бас тодорхой хэмжээнд нь олон нийтийн болох ажлыг биржээрээ дамжуулаад яаж хийх вэ ийм байдлаараа бид нар уялдуулж байгаа.

Дээрээс нь яг энэ бусад орны жишгээр бол дандаа төсвийн бодлоготойгоо уялдуулж байгаа байхгүй юу. Тэрнээс биш нэг шийдвэр гаргаад чи энийг санхүүжүүл гээд юм тулгадаггүй. Ноогдол ашгийг чи тэдний их наядын гэдэг юм уу тэдэн тэрбумын ноогдол ашгийг улсын төсөвт оруулах ёстой. Энийг нь бид нар буцаагаад төсвийн бодлогоороо хуваарилдаг ийм зарчим руу л явах нь зөв байгаад байгаа юм.

Шүүх дээр янз бүрийн асуудлууд бол гарахгүй. Өнөөдөр төрийн өмчит үйлдвэрийн газрын статустай 18 байна. Орон нутгийн статустай бодлого Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлж байгаа 105 орчим байгаа. Эд нар цаашдаа уг нь зарим нь бараг компани хэлбэрээрээ ч явж байсан. Тэгэхээр энийг л цаашдаа Иргэний хууль болон

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя. Алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. Чинбаатарын Анар гишүүн асуултаа асууя. Алга байна. Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Энэ 60 хоног гээд бас ийм хугацаа тавьсан байна. Тэгээд 60 хоногт багтаана гэхээр зэрэг миний энэ тооцоогоор харахаар үнэлгээ хийлгэнэ, тэгээд аудит оруулна энэ ингээд шилжилтийн процесс чинь амжихгүй болох юм биш үү? Ийм хоногоор хязгаар тавьчихсан тэр хугацаанд компани болж юм нь өөрчлөгдөнө өө гэж байгаа юм. Тэгээд жишээлбэл төрийн өмчийг энэ Төрийн сан дээр данстай байсан компани арилжааны банкин дээр данстай болох уу, үнэлгээ

нь яаж явах юм, дүрмийг нь батлах асуудал бас бараг сар болно, тэгээд аудитын асуудлууд явна. Ингээд явахаар зэрэг энэ хугацаан дээрээ та бүхэн маань ер нь яаж тооцсон юм бэ?

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Тийм, дагаж мөрдөх журмын зохицуулалтыг асууж байх шиг байна. Ер нь бол энэ хууль батлагдаад хүчин төгөлдөр болсон тохиолдолд төрийн өмчит компаниудыг 45 хоногийн дотор бас энэ хуулийн засаглалыг компани хэлбэр рүү оруулаач гэж байгаа юм. Энэ компани хэлбэр рүү оруулаад явахаар үндсэн дүрмийн үйл ажиллагаа энэ тэр дээр бол өөрчлөлт орохгүй шүү дээ ихэнх компаниуд дээр. Энэ нөхцөл байдлууд дээр таны хэлж байгаа хүндрэлүүд үүсэхгүй. Ер нь бол энэ дээр мэдээж шилжилтийн зохицуулалтууд гарна. Тэр компани дээр наад захын хяналтын механизм буюу ТУЗ-үүд нь томилогдохоос эхлээд энэ үйл ажиллагаа, бизнес төлөвлөгөөгөө хамтраад баталдаг, энийг нь гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлээд явах ингээд горим энэ тэр рүүгээ ороод явах энэ нөхцөл байдал цаашдаа хуулийн дагуу ороод ирнэ.

Орон нутаг дээр бол 60 хоног тавьж өгсөн юм. Энэ дээр бол хэлэлцүүлгийн явцад бас энэ хугацаануудыг бас эргэж харж болно. Тэгээд энэ дээр бол нээлттэй байгаа. Ер нь зүгээр энэ хуулийн этгээдийг хэлбэр талаас нь өөрчилж байгаа учраас энэ дээр бол бас тодорхой хэмжээний энэ хугацаа боломжтой гэж харсан. Ер нь Улсын Их Хурал ч гэсэн.../минут дуусав./

С.Бямбацогт: 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд 13 цаг болсон байна танхимдаа хүрэлцэн ирнэ үү? Гишүүдийг урьж байна. Үг дээр их олон хүн байхгүй байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Баярлалаа. Би бас энэ юу хууль санаачилсан гишүүний нэг. Гэхдээ энэ дээр бас нөгөө ийм жоохон тодруулж хэлэхгүй бол нэлээн гишүүд маань ч бас олон нийт ч гэсэн энэ гадаа байгаа сэтгүүлчид ч гэсэн төөрөгдөлд ороод байх шиг байна. Тэгээд яагаад энэ хуулийг ингээд санаачилж орж ирсэн юм бэ? Засгийн газраас 2 ч том суурь хуулийн шинэчилсэн найруулга ороод ирчихсэн байгаа гэдэг юм яригдаж байгаа. Тэгээд энэ хуулийг анх бол бүүр өмнөх оны 10, 11 сарын үед энэ 2 Засгийн газраас орж ирсэн хууль маань Улсын Их Хурал дээр орж ирчхээд ажлын хэсэг байгуулагдсан боловч тэн дээр ямар нэгэн ажиллагаа хийгдэхгүй нэлээн удчихсан юм. Тэгээд 10, 11 сар болчихоод тэгээд энийг ер нь төрийн өмчийн компанийг жоохон янзлах ёстой гэдэг юмыг жоохон түлхэц болох үүднээс энэний жижиг хэмжээний засвар болгож Сайнзориг гишүүн санаачлаад бид бас ингээд нэгдсэн, миний бол гол нэгдсэн асуудал бол тэр БЭТ-ийг хүчингүй болгох асуудал бол байсан.

Тэгтэл түүнээс 2 сарын дараа ингээд 12 сарын 31-нд Улсын Их Хурлын даргын захирамжаар Засгийн газрын 2 том хуулийн ажлын хэсэг бол гарсан. Үүрийнтуяа гишүүнээр ахлуулаад, дэд ахлагчаар нийтийн өмчийг нь би, төрийн өмчийн компанийн бүтээмжийг бол Сайнзориг гишүүн өөрөө ингээд ахалж байгаа. Тэгээд энэ дээр толгой нь эргэхгүй үүднээс яг цаг хугацааны хувьд бол ийм юм болчихсон шүү гэдгийг хэлмээр байгаа.

Хоёрдугаарт, тэр нөгөө БЭТ-ийн хууль Цэнгүүн гишүүн оруулаад ирчихсэн түрүүний 7 хоногт хэлэлцэх эсэхийн нь хийчихсэн. Тэгээд энэ бол зүгээр хүчингүй болгох хууль учраас нэг их ажлын хэсэг байгуулах шаардлагагүй зүгээр л хүчингүй болгох заалттай юм чинь явчих боломжтой. Нэгдэх гэсэн асуудал байхгүй гэж бодож байгаа юм.

Энэ хууль дээр бол үндсэн тэр Төрийн өмчийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгааг нь бол Нийтийн өмчийн хуульдаа нэгтгээд нэгтгээд явчихсан нь зөв болов уу гэсэн би бол байр суурьтай байгаа.

Яагаад вэ гэхээр яах вэ энэ хуулиар бол зөвхөн ТӨҮГ буюу үйлдвэрийн газар гэдгийг компани болгоё, засаглалыг нь сайжруулъя гэдэг энэ л өөрчлөлт орж ирж байгаа. Гэхдээ ингэлээ гээд яг нөгөө бид нарын хүссэн үр дүн бол гарахад хэцүү. Яагаад гэвэл юу гэдэг юм “Эрдэнэт” ТӨҮГ-ыг бид нар “Эрдэнэт” ХХК болголоо гээд үнэхээр засаглал, бүтээмж нь сайжрах уу гэдэг дээр би бол үгүй гэж бодож байгаа. “Эрдэнэс Тавантолгой” ХХК байгаад үнэхээр засаглал нь сайн байна уу гэвэл үгүй байгаа.

Тэгэхээр одоо яг бидний ажиллаж байгаа тэр Нийтийн өмчийн хууль буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулга дээр энэ өмчийнхөө ангиллыг яах юм, Эрдэнэтийн үйлдвэрийн төрийн өмчийн хувьцааг бид нар яаж ангилах юм, орон нутагт байгаа тэр үйлдвэрийн газрын өмчийг нь тэгвэл яаж ангилах юм гэдгээсээ авхуулаад удирдлага, зохион байгуулалт нь хэн хариуцах юм, хэн тэр хариуцлага хүлээх юм гэдэг энэ бүх л системээр нь харж байгаа юм. Ингэж байж жоохон менежмент, засаглал нь сайжирна.

Мөн Сайнзориг гишүүний өөрийнх нь бас ахалж байгаа энэ Төрийн өмчийн компанийн хууль дээр компани болголоо гэхэд удирдлага нь, засаглал нь ил тод байхын тулд мэргэжлийн менежменттэй байх энэ асуудлууд нь байгаа учраас энэнтэйгээ нийлүүлээд явчихад бол илүү цогцоор нь бас харах байх гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгэхээр энэ бол би санаачлагч учраас үг хэлж байгаа, байр сууриа илэрхийлж байгаа гэдгийг бас хүлээн авна уу. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуултаа асууя.

Ш.Бямбасүрэн: Энэ хууль санаачлагчаас хэдэн асуулт байна. Энэ төрийн өмчийн, Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг бол оруулж ирж байна. Тэгээд үзэл санаа хуулийн үзэл санаа болон энэ хэрэгцээ шаардлагыг нь харахаар ингээд аягүй гоё гоё юм биччихсэн. Тэгээд ингээд яг өөрчлөлтийг нь ингээд харахаар яг ийм бодитой өөрчлөлт харагдахгүй байгаад байгаа юм. Зүгээр ингээд нэршил өөрчилж байгаагаар л харагдаж байна гэж хараад байна.

Жишээлбэл, энэ хуулийн 78 дугаар зүйл дээр Засаг даргын бүрэн эрх гэж байгаа. Тэгээд энэ Засаг даргын бүрэн эрх дээр болохоор энэ орон нутгийн өмчийн 78.2.2 дээр бас байгаад байгаа юм л даа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох гээд. Тэгээд энэ засаглал сайжруулахтай холбоотой ерөөсөө юм юу ч байхгүй. Яг энэ бодитой орж ирж байгаа нь. Зүгээр компани болгосноороо энэ заалт нь хэвээрээ байх юм бол энэ засаглал ерөөсөө өөрчлөгдөхгүй, улс төрийн томилгоо л орно энэ дээр.

Өмчийн хэлбэрээс үл хамаараад Компанийн тухай хуулиараа явчих юм бол уг нь бол аягүй ойлгомжтой. Компанийн тухай хууль чинь харьцангуй сайн хууль шүү дээ. Засаглалыг бол аягүй сайн тодорхой заачихсан тийм хууль байгаа байхгүй юу. Тэгэнгүүт Компанийн тухай хуультай зөрчилддөг энэ заалт бол байгаад байгаа юм. Тэгээд энэ орон нутагт бол болдог хамгийн их түгээмэл юм нь бол энэ. Нэг хэсэг нь Компанийн тухай хуулиараа ТУЗ-өө байгуулъя. ТУЗ-өөрөө дамжуулаад хяналтаа тавья. Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр жил болгон ТУЗ-ийн тайланг нь сонсдог болъё. ТУЗ-ийн гишүүдээ үнэлдэг болъё. Тэгээд ТУЗ нь өөрсдөө ингээд гүйцэтгэх удирдлагадаа, удирдлагын багтаа хяналт тавиад явъя гэдэг асуудлыг тавья гэхээр Засаг даргын бүрэн эрх гэнгүүтээ ерөөсөө Засаг дарга ерөөсөө 100 хувь 1 хүнийг томилдог тэнд ерөөсөө шийдвэр гаргадаг ийм зөрчилдөөнтэй хууль байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт энэ заалтыг авч хаяхгүйгээр энэ засаглал сайжрахгүй байхгүй юу төрийн өмчийн. Зүгээр ийм компани болгочоод энэ заалт байгаа тохиолдолд бол энэ орон нутгийн өмчид бол хэзээ ч сайжрахгүй гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь ямар бодолтойгоор оруулж ирсэн бэ? Миний хувьд бодлоор бол энэ нэгэнт энэ Сайнзориг гишүүн энэ үндсэн том төслийнхөө ажлын хэсгийг ахлаад явж байгаа бол энийгээ татаж аваад ингээд цогцоор нь оруулаад ирээч ээ. Бид нар өнөөдөр энэ хуулийг ингээд ийм чанар ярихгүйгээр зүгээр ийм тоо яриад тэд хэдэн хууль хэлэлцсэн, баталсан гэдэг байдлаар бас ингээд Улсын Их Хурлын чуулганыг бас ингэж авбал бас ямар байдаг юм бэ? Энийг ер нь цогцоор нь аваад оруулж ирвэл ер нь бид нар энийг зайлшгүй шийдэх ёстой хууль л гэж харж байгаа юм. Тэгээд энэ дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Бямбасүрэн гишүүнд бас баярлалаа. Яг таны ярьж байгааг л хийчихье гэж байгаа юм. Үнэхээр бас төр, орон нутгийн түвшинд аж ахуй эрхлэх шаардлагатай байна гэж өнөөдөртөө үзэж байгаа бол ядаж компанийн хэлбэрээр байгуулаад Компанийн хуулиа дагаж мөрдөөч гэдэг заалтыг л үүгээр оруулаад байгаа байхгүй юу.

Гэтэл тэр сонголт угаасаа нөгөө сонгож хэрэглэж байгаа учраас компани байгуулахгүйгээр төрийн өмчит үйлдвэрийн газар юм уу орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, эсвэл улсын тооцоот үйлдвэрийн газар нэртэйгээр байгуулаад яг таны энэ 78 дугаар зүйлийг ашиглаад л явчхаж байгаа юм. Тэгэхээр ер нь том зургаараа мэдээж Засгийн газраас өргөн барьчихсан байгаа тэр хуулиудыг явна. Сая бас Номинчимэг гишүүн маань хэллээ. Тэр хууль 21 онд өргөн баригдсан бөгөөд хэлэлцэгдээгүй 4 жил, 5 жил дарагдсан байхгүй юу. Одоо ч гэсэн ингээд байгаад байгаа.

Харин сүүлийн 2, 3 сар нэлээн идэвхжүүлэх тал руугаа орж байгаа. Энэ хуулийн төсөл бол цаг хугацааны хувьд бас наана нь батлаад явчхаж ч гэсэн энэ хуулийн этгээдийн засаглалын хувьд ойлгомжгүй байгаа энэ юмнуудыг чинь ядаж компани хэлбэрт оруулаад таны наад ярьж байгаа шаардлагуудыг чинь мөрдүүлж эхлээч гэдэг зүйлийг л бид нар шахаж байгаа байхгүй юу. Тэгээд үнэхээр бид хэдийн Үүрийнтуяа даргаар ахлуулсан 25 хүний бүрэлдэхүүнтэй энэ ажлын хэсэг эрчимтэй ажиллаж чадвал би заавал энийг давхцуулж батлуулах гээд байгаа зүйл биш.

Тэгэхээр энэ зүйлүүд чинь ингээд бүгд энэ хуулийг реформыг хийх ёстой гэж ярьдаг мөртөө бас тодорхой хэмжээний “action” гэдэг юм уу бодит байдал болгохдоо бид нар бас хойрго хандаад байгаа. Энэ дээрээ л бас шахалт, түлхэц үзүүлэх энэ байдалдаа оруулж ирж байгаа юм гэдэг зүйлийг нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, онолын түвшиндээ Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар чинь нөгөө төр байгуулж болох нийтийн эрх зүйн этгээдүүд бүгд ч хуулийн этгээдэд орж байгаа хувийн эрх зүйн этгээд болох компани ч орж байгаа учраас наад таны заалтыг чинь ашиглаад шууд хүчингүй болгочхож бас болохгүй байгаа. Мэдээж тэр нийтийн эрх зүйн этгээдийнх нь дарга, удирдлагуудыг хуульд заасан журмын дагуу Засаг дарга шат шатдаа томилж байгаа. Тэгэхээр энэ удаад бас Засгийн газраас боловсруулсан тэр хуулийн концепц ч гэсэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн асуудлыг тусдаа хуулиар нь зохицуулаад тэрийг нь залгуулаад Компанийн хууль араас нь шууд үйлчлэх байдлаар оруулж ирж байгаа байхгүй юу. Би энэ хуулийг өөрөө анхнаасаа бичсэн.

С.Бямбацогт: Бямбасүрэн гишүүн тодруулж асууя.

Ш.Бямбасүрэн: Энэ яах вэ та ингээд яг энэ орж ирж байгаа юм аа ингээд 78 дугаар зүйл ер нь бол байхгүй болгохгүй л бол ямар ч өөрчлөлт ирэхгүй. Ямар ч мэргэжлийн баг, удирдлагад очих тийм боломжгүй нөхцөл байдал байгаад байгаа байхгүй юу. Энэ дандаа ерөөсөө улс төрийн томилгоо явдаг, намын томилгоо явдаг. Тэгээд сум, аймгийн хэмжээнд нэгжийн хуулиар сумын хэрэгжүүлэх чиг үүрэг, аймгийн хэрэгжүүлэх чиг үүрэг гээд байгаа шүү дээ. Тэрнийхээ дагуу бол орон нутгийн өмчит компани байгаа. Үйлдвэрийн газар ч гээгүй орон нутгийн компанид ч гэсэн байгаа.

Гэтэл яг энэ 78 дугаар зүйлийн энэ Засаг даргын бүрэн эрх гэдгээрээ л ерөөсөө бүх юм хяналтаас гадуур явчхаад байгаа байхгүй юу. Яг энэ улс төрийн. Тэгэхээр таны энэ оруулж ирж байгаа бүх хэлээд байгаа санаа чинь үндсэндээ энэ заалттайгаа холбоотойгоор уначих гээд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр та энэ заалтыг авч хаяхгүйгээр таны яриад байгаа бүх юм ямар ч хэрэгжих боломжгүй болох гээд байгаа юм л гэдгийг хэлэх гээд байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 4 гишүүн байна. Эндээс Алтангэрэл гишүүн байна. Жаргалан гишүүн алга байна. 3 гишүүн л үг хэлэхээр байна даа.

Мэндбаярын Мандхай гишүүн үгээ хэлье. 3 гишүүний дараа санал хураалт явах нь байна шүү гишүүд ээ. 10 минутын дараа гэсэн үг. Гишүүдийг танхимдаа санал хураалтдаа орж ирэхийг урьж байна. Мэндбаярын Мандхай гишүүн үгээ хэлье. Алга байна. Үүрийнтуяа гишүүн үгээ хэлье. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн 1 дүгээр микрофон индрийн.

Д.Үүрийнтуяа: Засгийн газраас төрийн өмчийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга Нийтийн өмчийн хууль нэртэйгээр 2025 оны 6 сарын 25-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Мөн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах анхдагч хуулийн төслийг 2025 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эдгээр хуулийн хэлэлцүүлгийг, хуулийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг тус тусдаа ажиллаж байгаад 25 оны 12 сарын 31-ний өдөр миний бие ажлын хэсгийг ахалж ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ 2 хуулийн дэд ажлын хэсэг болж хуулийг ахалж байгаа Сайнзориг, Номинчимэг гишүүд өнөөдрийн энэ хуулийн төслийг бас өргөн мэдүүлсэн байгаа юм. 2 үндэслэл байна.

Нэгдүгээрт, энэ хуулийн төсөл одоо явж байгаа Нийтийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулга энэ найруулгатай бол яв цав нийцэж байгаа. Тийм учраас хэрвээ энэ асуудал чуулганаар хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн нөхцөлд ажлын хэсгийг нэгтгээд явах ёстой гэсэн байр суурьтай байгаа. Хууль санаачлагчийн хэлж байгаа энэ хууль нь үндсэн нэмэлт, өөрчлөлт орж байгаа, шинэчилсэн найруулга орж байгаа энэ хуулиас түрүүлж явах ёстой юм гэдэгтэй бол би зарчмын хувьд санал нэгдэхгүй байгаа. Түрүүлж орлоо гээд энэ хуулийн үр дүн яг бүх өөрчлөлт орсон хэмжээнд гарахгүй гээд би гишүүдийн хэлж байгаатай бол санал нэгдэж байгаа юм.

Тийм ч учраас Эдийн засгийн байнгын хороон дээр миний бие хуулийн төслөө татаад авах саналыг хууль санаачлагчид бол тавьсан. Эдийн засгийн байнгын хороо бол хууль санаачлагчдын энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ажлын хэсгийг нэгтгэж байгуулаад явах боломжтой гэдэг үндэслэлээр хэлэлцэх эсэхийг нь бол дэмжсэн байгаа. Энд бол би Улсын Их Хурлын даргад бас санал хэлэх гэж байгаа юм. Засгийн газраас өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн тухай хуулийг Номинчимэг гишүүн дэд ажлын хэсгийг ахлаад явж байгаа. Энэ ажлын хэсэгтээ хэрвээ энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийн санал дэмжигдэх юм бол хамтад нь ажлын хэсгийг нэгтгээд явах нь зүйтэй. 2 тусдаа ажлын хэсэг байх шаардлагагүй гэж үзэж байгаа.

Дагаж орж ирсэн БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл 2025 оны 12 сарын 30-нд Цэнгүүн гишүүн Улсын Их Хуралд өргөн бариад сая 4 сарын 24-нд хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн. Энэ бол ямар нэгэн өөрчлөлтгүйгээр яг адилхан орж ирж байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороон дээр энэ хуулийг бол давхардаж байна, дэмжихгүй гэдэг байр суурьтай гарсан.

Тийм учраас өнөөдөр бол энэ хуулийг хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн нөхцөлд, хэрвээ дэмжигдсэн нөхцөлд 2 ажлын хэсэг дахиж гаргахгүйгээр одоо ахалж байгаа 2025 оны 12 сарын 31-ний өдөр байгуулагдсан 529 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтээ нэгтгэж гаргах нь зүйтэй шүү гэдэг саналыг илэрхийлж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дэмжигдсэн тохиолдолд болох байх аа. Оюунсайханы Алтангэрэл гишүүн үгээ хэлье. 2 дугаар микрофон индрийн.

О.Алтангэрэл: Хуулийн төслийг бол хэлэлцэх зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ бид сая Үүрийнтуяа гишүүний хэлсэнчлэн энэ хуулийн төслүүдийг нэгтгээд цааш нь явах нь зүйтэй. Өнөөдөр бид нар орон нутгийн өмч гээд тэгэхээр орон нутгийн өмчит компаниуд гээд ингээд хяналтгүй, өгөөжгүй ийм компаниуд маш их байгаа.

Өнөөдөр би бас энэ чуулганы танхимд орон нутгийн өмчит компани дээр гарсан маш том хулгайн талаар бас мэдээлэл өгөх гэж байгаа юм. Яаж өмч үнэгүүддэгийн жишээ Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт Баянтээгийн нүүрсний уурхай гэж уурхай байдаг. Улаанбаатар хотоос 560км зайтай, олон 10 сая тонны нөөцтэй, 10 гаруй аймгийг эрчим хүчээр хангадаг. Өвөрхангай аймаг 70 хувийг нь эзэмшдэг Баянтээгийн нүүрсний уурхай гэж уурхай байдаг. Тэгээд энэ уурхайн хувь, хувьцааг Өвөрхангайчуудад эзэмшүүлээч гэж сүүлийн 6, 7 жил шаардлага тавьж байгаа хүн би байгаа юм. Хамгийн сүүлд 2024 онд энэ асуудлыг хэлэлцээд нэг шийдвэр гаргаад иргэдийн хурал нь буцаасан.

Гэтэл юу болов гэхэд 2024 оны 1 сарын 27-ны өдөр лицензийнхээ хугацааг сунгуулах өргөдлөө өгөх байсныг зориуд санаатайгаар өгөлгүйгээр өнөөдөр Өвөрхангай аймгийн ард иргэдийн 70 хувийг нь эзэмшдэг Баянтээгийн нүүрсний уурхайн лиценз хугацаа дуусаж хүчингүй болсон байна. Бид энд Улаанбаатарт олон тэрбум төгрөгийн, олон сая долларын авлигал хулгай яриад байдаг. Орон нутагт ийм үйлдэл гарч байна. Өнөөдөр Өвөрхангай аймгийн Засаг даргаар ажиллаж байгаа нөхөр тэр үед аймгийн Иргэдийн хурлын дарга байсан. Өөрөөр хэлбэл, Өвөрхангай аймгийн ард иргэдийн өмчийг харж манах үүрэгтэй ийм хүн байсан.

Тэгэнгүүт одоо лиценз хүчингүй болсон. Энийг дагаад дагаад юу болох вэ гэхлээр сонгон шалгаруулалт зарлана. Сонгон шалгаруулалтад орж олон 10 тэрбум төгрөгийн санал өгсөн аль нэг компани, хувь хүн авна. Тэгэхлээр би энэ уурхайн лицензийг хүчингүй болгосон үйлдлийн цаана эс үйлдэл зориуд хийж энэ албан тушаалтнууд орон нутгийн өмч Өвөрхангайчуудын ард иргэдийн өмчийг үнэгүүдүүллээ гэж харж байгаа.

Цаашдаа бид Төрийн болон орон нутгийн тухай өмчийн тухай хуулийн энэ өөрчлөлтүүдээр орон нутагт энэ байдлаар хулгай хийдэг асуудлыг таслан зогсоох ёстой шүү. Ажлын хэсгүүдээ нэгтгэх ёстой. Сая дурдагдсан мэдээллийнхээ хүрээнд би энэ асуудлыг зохион байгуулсан нөхрийг хэний захиалгаар ингэж хийв гэж Авлигатай тэмцэх газарт эс үйлдлээр нь өргөдөл гаргаж шалгуулна. Шинэ нийслэл Хархорумыг цахилгаанаар хангах бүтээн байгуулалт ТЭЗҮ хийгдээд явж байх үед энийг тасалдуулах зорилго хэнд байв? Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын байгууллагад шалгуулна гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ авлига, хулгайг гарахаас нь өмнө таслан зогсоох нэг арга зам бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал учраас хэлэлцэх асуудлыг дэмжиж байгаа байр сууриа илэрхийлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих

эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна одоо танхимд.

Гишүүд санал хураалтад бэлдье. 41 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. Ирц нь 102 гишүүн байгаа. 61 гишүүнийг санал хураалтдаа бэлэн болохыг урьж байна. Танхимд 50 гишүүн байгаа юм байна. Танхимд 50 гишүүн байна гэдэг чинь бас 10-аад гишүүн ороод ирчихвэл болчих гээд байна. Уул нь 7 хоногийнхоо асуудлыг 7 хоногтоо шийдээд явбал их зүгээр байх. Бүлгийн дарга нар, бүлгийн дэд дарга нар ирцээ бүрдүүлье. Улсын Их Хурлын дэд дарга, бүлгийн дарга, бүлгийн дэд дарга нар бол бас энэ чуулганы хуралдааны ирцийг бүрдүүлэх бас үүрэгтэй. Тийм болохоор бас дарга нар бас үүргээ биелүүлцгээнэ. Гишүүд орж ирж байна.

Гишүүдийг ирцдээ, санал хураалтдаа хүрэлцэн ирэхийг урья. Одоо 4 дэх асуудал. 1 л асуудал үлдсэн байгаа. Энийгээ гялс танилцуулгаа хийгээд бас хэлэлцэхээ явуулчихъя.

13.24 цаг

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хороо санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирээрэй. Энэний дараа санал хураалттай шүү.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 02 дугаар тогтоолоор Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдалаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, Очирбат, Пунсалмаа, Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийг боловсруулсан байна.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүд төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргаагүй тул хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт заасныг үндэслэн уг хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаснаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60.9 хувь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэйгөөр холбогдуулан боловсруулсан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Өө энэ ч чинь бас нэлээн л олон юм. Энэ чинь хуулийн хугацаатай учраас хэлэлцэхгүй бол болохгүй юм байна. Энхцэцэг гишүүн алга байна. Уянга гишүүн хаслаа, нэрээ татлаа. Батын Батбаатар гишүүн нэрээ татлаа. Хишигдэмбэрэл Тэмүүжин гишүүн нэрээ татлаа. Лхагвасүрэн Соронзонболд гишүүн алга байна. Ганхүлэг гишүүн нэрээ татлаа. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Жаргалсайхан гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна.

Үг хэлэх гишүүд алга. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Танхимд 50 гаран гишүүн байна. Ирцэд орсон, санал хураалтдаа 42 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн бус гишүүд санал хураалтдаа бэлтгэе, танхимдаа хүрэлцэн ирнэ үү.

Ирцийн санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт. Тэгээд одоо ирцэд эсрэг гарч байгаа гишүүд бол чуулганы хуралдаан тасалсан гэж үзнэ. Гишүүд байраа, суудлаа эзэлье. Санал хураалтдаа бэлдсэн үү Жангабыл гишүүн хуруугаа уншуулсан уу тээ? Ирцийн санал хураалт.

48 гишүүн хуралдааны бүртгэлд ирцэд орсон байна. Зулпхар гишүүн, Мандхай, гишүүн, Хэрлэн гишүүн, Цэнгүүн гишүүн нар ирцдээ ороогүй байна. Ирцдээ оръё. Өөр ирцдээ ороогүй гишүүд байна уу? Дамдинням гишүүн. Бусад татгалзсанд гарч байгаа гишүүд ирцдээ оръё, хуралдаа сууя аа.

Одоо 53 гишүүн бэлэн болсон байна. Дахиад нэг шалгалт, ирцийн санал хураалт сая ороогүй гишүүд оруулаад.

52 гишүүн болж байна. Татгалзсан дээр гарч байгаа танхимд сууж байгаа гишүүд байвал нэрээ хэлээрэй. Өөрсдийгөө хараад. Батболд гишүүн. Татгалзсанд гарч байгаа бусад гишүүд чуулганы хуралдаандаа хүрэлцэн ирнэ үү. Ирцдээ орчихдог, санал хураалтад оролцдоггүй, түүнээсээ болоод хуулиуд унадаг, ажил явдаггүй ийм асуудал бас бидэнд их гардаг. Тийм болохоор ирцдээ орох ёстой, санал хураалтдаа оролцох ёстой. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооноос Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 99 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 54.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалдаа оръё.

13.32 цаг

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтыг явуулна.

Санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтад 53 гишүүн бэлэн болсон байна. Ганц нэг гишүүд бас бэлэн болж амжаагүй байх шиг байна. Хурууны хээгээ уншуулна уу. Ингээд санал хураалт явуулъя. Тэмүүлэн гишүүн суудлаа эзэлчихье. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй системийн зөрчил, хүний эрхийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Энэ хүний эрхтэй холбоотой маш чухал тогтоол гарч байгаа. Маш чухал тогтоол. Тийм болохоор хэрэгжилтийг ажлын хэсэгт ажилласан ажлын хэсгийн гишүүд Эрдэнэболд гишүүн тэргүүтэй, Хууль зүйн байнгын хорооны гишүүд, баталсан гишүүддээ баярлалаа. Хэрэгжилт дээр илүү бас бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр Улсын Их Хурал бас онцгой анхаарч ажиллана. Тэгээд тогтоол баталдаг хэрэгждэггүй байж таарахгүй. Тийм болохоор энд бас Тамгын газар энэ тогтоолын хэрэгжилтийг биелүүлэх тал дээр онцгой анхаарна шүү гэдгийг бас хэлье. Дараагийн асуудал руугаа оръё.

13.34 цаг

Улсын нисэхийн тухай хуулийн төслийг Засгийн газар өргөн мэдүүлсэн түүний санал хураалт явагдана.

Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Зочин танилцуулъя. “Монголын бартаат замын авто спортын холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүд, тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд бартаат замын спорт гэж мундаг хүнд спортоор хичээллэдэг тамирчид байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Санал хураалтдаа бэлдсэн үү? Хэдэн гишүүн бэлдсэн байна? 51 гишүүн бэлдсэн байна шүү. Бусад гишүүд маань бэлдээрэй санал хураалт нь дутуу байх шиг байна. Булгантуяа гишүүн санал хураалтдаа бэлдье. Сандаг-Очир сайд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт явуулъя.

Улсын нисэхийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцоноос 56 гишүүн буюу 56 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцоноос 54 гишүүн буюу 54 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ.

3.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцоноос 55 гишүүн буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын нисэхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн санал хураалтаа явуулъя.

13.37 цаг

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлал хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. 57 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалтыг уншиж танилцуулъя.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

100 гишүүн санал хураалтад оролцсоноос 54 гишүүн буюу 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 51 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ. Унах гээд байна шүү нөхөд өө.

3.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 100 гишүүн оролцсоноос 43 гишүүн дэмжиж, 43 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Энэ нөгөө БЭТ-тэй холбоотой хууль. Урьд нь хэлэлцэх нь шийдэгдчихсэн юм чинь бараг ялгаагүй юм байна даа тийм ээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудаас дэмжигдсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр, олонх дэмжсэн тул олон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

1 хууль буцсан БЭТ томилох, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын БЭТ томилох тухай хууль буцсан тул 36.14-д санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хуулийн төслийг “Хууль санаачлагчид буцаах тухай” тогтоол батлагдсанд тооцлоо.

13.41 цаг

Ингээд 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн “Баасан” гаргийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна. Өнөөдөр бас 5 сарын 1 олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл, ажилчдын өдөр бас.

Өнөөдөр бас ажлаа хийж байгаа нийт ажилтан, албан хаагч нартаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе. Улсын Их Хурлынхаа

чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон, санал хураалтад оролцсон сая 55 гишүүндээ бас баярлалаа. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье.

13.41 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР